



БОЛОВСРОЛ
СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



unicef
НҮБ-ын Хүүхдийн сан



*Цэцэрлэг, ерөнхий боловсролын
сургууль, дотуур байрын*

**УС, АРИУН ЦЭВЭР, ЭРҮҮЛ АХУЙН НОРМ,
ШААРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ**



УЛААНБААТАР 2015

**ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛЬ, ДОТУУР БАЙРЫН УС, АРИУН
ЦЭВЭР, ЭРҮҮЛ АХУЙН НОРМ, ШААРДЛАГЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ**





Энэхүү гарын авлагыг Австралийн Гадаад хэрэг, худалдааны яамны (DFAT-Australian Aid) дэмжлэгтэйгээр НҮБ-ын Хүүхдийн сангаас хэрэгжүүлж буй “Сургууль, цэцэрлэгийн ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуй” төслийн санхүүжилтээр хэвлүүлэв.

Боловсруулсан:

Б.Пүрэвжав	Монгол улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан, зөвлөх инженер
П.Ариунаа	Эй Си Эф (АСФ) Монгол Олон улсын байгууллагын төслийн менежер
Б.Шижиртуяа	“Ус ариун цэвэр, эрүүл ахуйн дэвшлийн төв” ийн Орчны ариун цэврийн менежер
Д.Мөнхжаргал	Эрүүл мэндийн боловсролын зөвлөх
Б.Дуламханд	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Сургуулийн өмнөх болон бага боловсролын хэлтсийн мэргэжилтэн

Хянасан:

Ж.Мягмар	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Сургуулийн өмнөх болон бага боловсролын хэлтсийн ахлах мэргэжилтэн
П.Ариунаа	Эй Си Эф (АСФ) Монгол Олон улсын байгууллагын төслийн менежер

“СЭЛЭНГЭПРЕСС” ХХК эхийг бэлтгэж хэвлэв. 2015 он

Гарчиг

ӨМНӨХ ҮГ.....	3
НОРМ ШААРДЛАГА БАТЛАХ ТУХАЙ БСШУ, ЭМС, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ.....	4
ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, ДОТУУР БАЙРЫН УС, АРИУН ЦЭВЭР, ЭРҮҮЛ АХУЙД ТАВИГДАХ НОРМ, ШААРДЛАГА.....	5-10
БҮЛЭГ 1. УСАН ХАНГАМЖИД ТАВИГДАХ НОРМ, ШААРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ.....	11-56
БҮЛЭГ 2. АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИД ТАВИГДАХ НОРМ ШААРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ, САЙН ТУРШЛАГУУД.....	57-95
БҮЛЭГ 3. ЭРҮҮЛ АХУЙН БОЛОВСРОЛ, ЗАН ҮЙЛИЙН ӨӨРЧЛӨЛТӨД ТАВИГДАХ ШААРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ.....	97-114
БҮЛЭГ 4. ГАЛ ТОГОО, ХООЛ ХҮНС БОЛОВСРУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ.....	115-141
БҮЛЭГ 5. ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ.....	143-146
ХАВСРАЛТ.....	147-189
Хавсралт-1: Ус ариун цэвэр, эрүүл ахуйн чиглэлээр ажилладаг байгууллагуудын товч мэдээлэл	
Хавсралт-2: Эрүүл мэндийн клубын үйл ажиллагаа	
Хавсралт-3: Сурагчдын эрүүл ахуйн зан үйлийн өөрчлөлтөнд үнэлгээ хийх нь	
Хавсралт-4: Ус нөөцлөх сав, усны шүүлтүүр худалддаг зарим байгууллагын мэдээлэл	
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР.....	190
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ.....	191-193

Өмнөх үг

Боловсрол бол хүүхдийг мэдлэг чадвартай болон хөгжих үндсэн суурь болдгоос гадна тэднийг нийгмийн дотор аж төрөх бэлтгэлтэй болгон төлөвшүүлэх гэсэн нэгдмэл хос зорилготой билээ.

Манай орны хүүхдүүд бусад орны үе тэнгийхний адилаар маш хурдтайгаар өөрчлөгдөж байгаа ертөнцөд өсөн бойжиж байна.

Даяарчлагдсан нийгэмд амьдарч буй хүүхдүүдээ бид бүтээлч чадвартай, бие даасан, чөлөөт амьдралын үнэ цэнийг ойлгодог, хүмүүнлэг, энэрэнгүй, эвсэг тусч, эх оронч сэтгэлтэй, эрүүл чийрэг, эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй Дэлхийн иргэн болон төлөвшүүлэхийг зорьж байна.

Хүүхэд, суралцагч, багш, ажилтнуудын эрүүл аюулгүй орчинд сурч хөгжих, суралцагчдад эрүүл зан үйл төлөвшүүлэх зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухааны Сайд, Эрүүл мэнд, спортын Сайд, Сангийн Сайдын 2015 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн А253/251/173 дугаар хамтарсан тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага”-ыг батлан хэрэгжүүлэх ажлыг эхлүүлж байна.

Цэцэрлэг, сургууль, дотуур байрынхаа ус, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл байдлыг тодорхойлон, нөхцөл байдалд тулгуурлан ажлын төлөвлөгөө гаргаж, эцэг эх, олон нийт, иргэд, орон нутгийн удирдлага, хувийн хэвшлийн санаачлага, оролцоо дэмжлэгтэйгээр норм, шаардлагыг хэрэгжүүлэх боломж их бий.

БСШУЯ, Францын Эй Си Эф (ACF) олон улсын төрийн бус байгууллага, ус, ариун цэвэр, эрүүл ахуйн чиглэлээр ажилладаг эрдэмтэн, судлаачдын хамтын оролцоотойгоор норм, шаардлагыг хэрэгжүүлэхэд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, багш нарт дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү гарын авлагыг бэлтгэн хүргүүлж байна. Гарын авлагыг боловсруулах, хэвлүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлж хамтран ажилласан НҮБ-ын Хүүхдийн сангийн хамт олонд талархлаа илэрхийлье.

Та бүхний үйл ажиллагаанд тус нэмэр болох үүднээс гаргаж буй энэхүү гарын авлагын талаарх саналаа БСШУЯ-ны Сургуулийн өмнөх, бага боловсролын хэлтэст гэсэн хаягаар ирүүлэхийг хүсч байна.

Хүүхдийн төлөөх Та бүхний ариун үйлсэд амжилт хүсье.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД, ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2015 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/253 /251 /173

Улаанбаатар хот

Норм, шаардлага батлах тухай

Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг үндэслэн, ТУШААХ нь:

1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлагыг хавсралт ёсоор баталсугай.

2. Норм, шаардлагыг жил бүрийн батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх, аймаг, дүүрэг бүрт цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байранд ус, ариун цэвэр, эрүүл ахуйн нийтлэг шаардлагыг хангасан загвар орчин байгуулах, арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Эрдэнэчимэг), Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Ц.Баярхүү), Эрүүл мэнд, спортын яамны Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (О.Баяр)-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (М.Оюунцэцэг), Эрүүл мэнд, спортын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Э.Оюунсүрэн), Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт тус тус даалгасугай.





Нэг. Унд, ахуйн ус хангамжид тавигдах шаардлага

1.1. Ундны усны хангамжид тавигдах шаардлага

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

1.1.1. Ундны ус нь үндэсний стандартын шаардлагыг хангасан байх.

1.1.2. Усны чанар, аюулгүй байдалд жилд 2-оос доошгүй удаа шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулах.

1.1.3. Төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэртэй байна. Усны эх үүсвэрт эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг 50 метрээс доошгүй зайд тогтоож, дэглэмийг мөрдөх.

1.1.4. Сургууль, цэцэрлэгт хүүхэд бүр өдөрт 1 литрээс доошгүй ундны цэвэр ус уух боломжоор хангагдсан байх.

1.1.5. Ундны ус зөөх, хадгалах сав нь таглаатай, угааж цэвэрлэхэд хялбар, хүнсний зориулалтын материалаар хийгдсэн, хүүхдийн эрүүл мэндэд эрсдэлгүй байх.

1.1.6. Ундны ус хадгалах савыг 7 хоногт 1-2 удаа бүрэн суллаж, угааж, халдваргүйтгэх.

1.1.7. Сурагчид хувийн аяга болон ундны ус уух савтай байх.

Сургуулийн дотуур байрын нэмэлт шаардлага

1.1.8. Дотуур байрын сурагч бүр өдөрт 2 литрээс доошгүй ундны ус уух боломжоор хангагдсан байх.

1.2. Ахуйн хэрэглээний ус хангамжид тавигдах шаардлага

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

1.2.1. Сурагч бүр хувийн ариун цэвэр сахихад 6-7 литр усны хангамжтай байх

1.2.2. Усаар зайлуулдаг бие засах газартай сургуулийн сурагчид өдөрт 10-15 литр усны хангамжтай байх.

1.2.3. Ил задгай усны эх үүсвэр нь жорлон болон бохир ус, ариутгах татуургын ус зайлуулах хоолойноос хөрсний байдлаас шалтгаалан наад зах нь 30-50 метр хол байх.

1.2.4. Угаалга цэвэрлэгээний ус авах газар нь бага ангийн сурагчид, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ойр, тохиромжтой, хүртээмжтэй байх.

1.2.5. Угаалга цэвэрлэгээний газар бүрт ус зайлуулах байнгын ажиллагаатай хоолой болон бохир усны цооногтой байх.

Сургуулийн дотуур байрын нэмэлт шаардлагууд

1.2.6. Хүүхэд бүр гар угаах, усанд орох болон бусад хэрэглээндээ өдөрт 20 литр усны хангамжтай байх.

Хоёр. Ариун цэврийн байгууламжид тавигдах шаардлага

2.1. Ариун цэврийн байгууламжийг төлөвлөх, барихад тавигдах шаардлага

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

2.1.1. Нэг ээлжинд хичээллэж буй 30 эмэгтэй хүүхдэд 1 суултуур, 40 эрэгтэй хүүхдэд 1 суултуур + 1 шээлтүүр ногдохоор тооцож байгуулах

2.1.2. Ариун цэврийн өрөө нь хүүхдийн нас, хүйсийн онцлогт тохирсон, хүүхдэд ээлтэй байх.

2.1.3. Эрэгтэй/эмэгтэй хүүхэд болон багш, ажилчдад зориулсан ариун цэврийн өрөө тусдаа байх.

2.1.4. Сургууль болон дотуур байрны ариун цэврийн өрөөнд явган суултуур суурилуулж болно.

2.1.5. Гадна жорлон нь хэрэглэгчээс 30 метрийн дотор байрлах бөгөөд улирлын ямар ч нөхцөлд ашиглагдахуйц байх.

2.1.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт тохирсон нэг жорлонтой байх.

2.1.7. Гадна жорлон нь зохих ёсны агааржуулагч, гэрэлтүүлэг, доторлогоо, дотроосоо түгждэг цоожтой, таглаатай хогийн савтай байх.

Цэцэрлэгийн нэмэлт шаардлага

2.1.8. Цэцэрлэг болон бага сургуулийн сурагчдад зориулсан ариун цэврийн өрөөг дотор байгуулах.

2.1.9. Цэцэрлэгийн 15-аас ихгүй хүүхдэд, бага ангийн 30 сурагчдад нэг суултуур тус тус ногдохоор тооцож байгуулах.

2.1.10. Хөтөвч ашигладаг хүүхэд бүр тусдаа хөтөвчтэй байх.

2.1.11. Суултуур, шээлтүүр нь хүүхдийн нас, өндөрт тохирсон хийцтэй, хэрэглэхэд хялбар байх.

Шилжилтийн насны охидод зориулсан нэмэлт шаардлага

2.1.12. Ариун цэврийн хэрэглэл бусад хог хаягдлыг хаях тагтай хогийн савтай байх.

2.1.13. Дотуур байранд охидын хувцсаа угаах, солиход нь зориулсан хаалгатай тусгай угаалгын өрөө байх ба шаардлагатай үед угаалга цэвэрлэгээндээ хэрэглэх цэвэр усаар хангагдсан байх.

2.1.14. Охидын угаалга болон хувцас солих өрөөний хогийн савыг өдөр тутам цэвэрлэж, хаягдлыг аюулгүй зайлуулж байх.

2.2. Ариун цэврийн байгууламжийн ашиглалт ба байнгын ажиллагааг хангах талаар

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

2.2.1. Суултуур/шээлтүүрийн засвар үйлчилгээ, цэвэрлэгээг цаг тухайд нь хийж, эвдрэл гэмтэлгүй, цэвэр байлгах (муухай үнэргүй, ялаагүй, ил задгай бие засаагүй).

2.2.2. Ариун цэврийн цаас болон цэвэрлэгээний бусад материалыг хүртээмжтэй байлгах.

2.2.3. Ариун цэврийн өрөө нь завсарлага болон хичээлийн үед ч ашиглаж болох байнгын ажиллагаатай байх.

2.2.4. Ариун цэврийн өрөөний хаалга, бариул нь бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохиромжтой байх.

2.2.5. Цэвэрлэгээ халдваргүйтгэл тогтмол хийх.

Цэцэрлэгийн нэмэлт шаардлага

2.2.6. Бага насны хүүхдийн хөтөвчийг хэрэглэх бүрт угааж цэвэрлэх, халдваргүйтгэх.

Гурав: Гар угаагуур болон шүршүүрт тавигдах шаардлага

3.1. Гар угаах байгууламж

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

3.1.1. Сургууль: 40 сурагчид нэг гар угаах угаагуур ногдохоор тооцож байгуулах.

3.1.2. Дотуур байр: 30 сурагчид нэг гар угаах угаагуур ногдохоор тооцож байгуулах.

3.1.3. Цэцэрлэг, сургууль, дотуур байранд хүүхдүүд бүлээн усаар гараа угаах нөхцлөөр хангагдсан байх.

3.1.4. Гар угаах угаагуур бүрийн дэргэд саван тогтмол байлгах.

3.1.5. Гар угаах байгууламж нь бага насны сурагчид, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ойр, тохиромжтой, хүртээмжтэй байх.

3.1.6. Гар угаах угаагуурын хажууд алчуур/гар хатаагч болон таглаатай хогийн сав байрлуулах.

Цэцэрлэгийн нэмэлт шаардлага

3.1.7. Цэцэрлэг: 20-оос ихгүй хүүхдэд нэг гар угаах угаагуур ногдохоор тооцож байгуулах.

3.1.8. Гар угаах угаагуурыг дотор байрлуулах ба халуун, хүйтэн усны холигчтой байх.

3.1.9. Гар угаах угаагуур нь хүүхдийн өндөрт тохирсон байх.

3.1.10. Угаалга цэвэрлэгээний бодис, хэрэглэгдэхүүнийг хүүхдийн гар үл хүрэх түгжээтэй шүүгээнд хадгалах.

Сургуулийн дотуур байрын нэмэлт шаардлага

3.1.11. Гадна жорлонтой сургуулийн дотуур байрны гар угаах угаагуурыг дотор байгуулах.

3.1.12. Хоолны газрын дэргэд гар угаагуурыг байгуулах.

3.2. Усанд орох онгоц, шүршүүр

Сургуулийн дотуур байрт

3.2.1. Охид, хөвгүүд тус тусдаа усанд орох боломжоор хангагдсан байх.

3.2.2. 20 охид, хөвгүүд тутамд нэг шүршүүр ногдохоор тооцож байгуулах.

3.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүдэд зориулсан тохиромжтой шүршүүр бүхий өрөө 1-ээс доошгүй байх.

3.2.4. Саванбусад тоног төхөөрөмжөөр хангагдсан угаалгын өрөөтэй байх.

Дөрөв. Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжийн засвар үйлчилгээнд тавигдах шаардлага

Сургууль, дотуур байрт:

4.1. Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжид засвар үйлчилгээг хийх төлөвлөгөөтэй, төлөвлөгөөний дагуу засвар үйлчилгээ хийдэг байх.

4.2. Ариун цэврийн байгууламжийн цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн материал худалдаж авах, ашигласан усны төлбөр төлөх зэрэг бусад шаардлагатай үйлчилгээнд зарцуулах төсөвтэй байх.

4.3. Сургуулийн дотоод болон гадаад орчныг тогтмол цэвэрлэж байх (хог хаягдал, бохир усыг цаг тухайд нь аюулгүй зайлуулах, мөсөн бүрхүүлгүй байлгах).

Тав. Эрүүл ахуйн боловсрол, зан үйлийн өөрчлөлтөд тавигдах шаардлага

5.1. Эрүүл ахуйн боловсрол

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

5.1.1. Эрүүл ахуйн боловсрол нь сургалтын хөтөлбөрийн салшгүй хэсэг байх ба ариун цэврийн өрөөг хэрхэн ашиглах, гар угаах, шүд угаах, хог хаягдал зэрэг агуулгыг багтаасан байх.

5.1.2. Эрүүл ахуйн боловсрол олгоход шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, материал нь хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон, хүртээмжтэй байх.

5.1.3. Сургууль (дотуур байр) бүр ус, ариун цэвэр, эрүүл ахуйн асуудлыг хариуцсан ажилтантай байх.

5.1.4. Эрүүл мэнд болон ус, ариун цэвэр, эрүүл ахуйн клубуудыг сургууль дээр байгуулж, идэвхтэй ажиллуулах.

5.1.5. Эцэг эх, асран хамгаалагчдад ариун цэвэр, эрүүл ахуйн чиглэлээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж, хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулдаг байх.

5.1.6. Ариун цэвэр, эрүүл ахуйн чиглэлээр хичээлээс гадуурх үйл ажиллагаа зохион байгуулах.

5.1.7. Сурагчдын мэдлэг, хандлага, зан үйлийн өөрчлөлтийг хянаж үнэлэх дотоод хяналтын тогтолцоотой байх.

Сургуулийн дотуур байрын нэмэлт шаардлага

5.1.8. Жендерийн болон нөхөн үржихүйн асуудал нь хичээлээс гадуурхи сургалтын хэсэг байх.

5.1.9. Хүүхдэд эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа явуулах болон үйлчилгээ үзүүлэх өрөөтэй байх.

5.1.10. Сургалтад хамрагдсан ажилтан өсвөр насны охид, хөвгүүдэд бие бялдрын өсөлт хөгжил, бие махбодийн өөрчлөлтийн талаар зөвлөгөө өгдөг байх.

5.1.11. Охидод сарын тэмдгийн хуанли хөтлөх, ариун цэврийг сахих талаар зөвлөж, дэмждэг байх.

5.2. Эрүүл ахуйн дадал, зан үйлийн өөрчлөлт

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

5.2.1. Ил задгай бие засахгүй, хог хаяхгүй байх.

5.2.2. Суултуур/шээлтүүрийг зөв ашигладаг байх.

5.2.3. Гараа савандаж угаах дадал хэвшилд суралцсан байх.

5.2.4. Гараа савандаж угаахын ач холбогдлыг ойлгосноор бусдад зааж сургадаг, сурталчилдаг байх.

5.2.5. Эцэг эхийн зөвлөл нь олон нийттэй хамтран жилд нэгээс доошгүй удаа эрүүл ахуйн талаарх мэдлэг сайжруулах талаар ажил зохион байгуулдаг байх (сургуулийн урлагийн тоглолт, жүжиг гэх мэт).

Зургаа. Гал тогоо болон хоол хүнс боловсруулахад тавигдах шаардлага

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

6.1. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн хүлээн авах хэсэг, хүнсний бүтээгдэхүүн хадгалах төрөлжсөн агуулах, бэлтгэлийн өрөө, халуун хоол боловсруулах өрөө, гурилан бүтээгдэхүүнээр үйлчилдэг бол нарийн боовны өрөө, халуун хоол олгох хэсэгтэй, технологийн урсгал дамжлагыг баримталсан, гал тогооны хүчин чадалд хүрэлцэхүйц бүрэн ажиллагаатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, багш, ажилчдаас тусдаа хувцас солих өрөө, ариун цэврийн болон шүршүүрийн өрөөтэй байх.

6.2. Гал тогооны өрөөний шал, хана, таазыг ус нэвтэрдэггүй, бат бөх, тэгш гөлгөр гадаргуутай, өнгө үзэмж сайтай, цэвэрлэхэд хялбар, сайн чанарын материалаар хийж, хортон шавж, бичил биетэн үржихээс хамгаалах өрөө тасалгаанд агааржуулагч, тоног төхөөрөмж бүрд агаар сэлгэлтийн систем байрлуулах бөгөөд гал унтраах хэрэгслүүдийг нүдэнд ил харагдах газарт байрлуулах.

6.3. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэсэг нь сайжруулсан усан хангамжтай, бохир ус зайлуулах цооногтой байх бөгөөд бие засах газар, хог хаягдлын цэг, бохирын эх үүсвэрээс хол байгуулах.

6.4. Хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэх ундны цэвэр ус нь стандартын шаардлага хангасан, гүний болон тээвэрлэн зөөвөрлөж ирсэн усыг стандартад нийцүүлэн шүүлтүүрт шүүсний дараа хоол хүнсэнд хэрэглэх.

6.5. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчдад гар бохирдох бүрт, хүүхдүүдэд хооллохын өмнө гар угаах, ариутгах орчин нөхцөлийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн бүрдүүлэх.

6.6. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын зөвшөөрөл бүхий худалдаа, үйлчилгээний байгууллагатай гэрээ хийж сав, баглаа боодол дээрх үйлдвэрлэгчийн нэр хаяг, үйлдвэрлэсэн он сар өдөр, цаг, хадгалах хугацаа, нөхцөл зэргийг шалган авч байх.

6.7. Түргэн гэмтэх түүхий эд, бүтээгдэхүүн /мах, сүү, өндөг г.м-ийг/ зориулалтын хөргөгч, хөргүүртэй агуулахад хадгалах, түүхий болон болсон хоол хүнсийг хооронд нь холих, хамт хадгалахаас зайлсхийх, шууд хэрэглэх бэлэн бүтээгдэхүүн, болгож бэлтгэсэн хоол хүнсийг 2 цагийн дотор олгох, болгож хонуулсан хоолыг хүүхдийн хоолонд дахин ашиглахгүй байх.

6.8. Хүүхдийн аманд орж байгаа бүхий л хоол хүнснээс дээж авах/чихэр, боов, хавчуургатай печень, хоол, шүүс, ундаа, цай/. Олгож буй хоолноос 250-500гр хүртэл, ширхэгийн бүтээгдэхүүн бол хүүхдэд өгч буй хэмжээгээр дээжийг авч 48-72 цаг хадгалж устгана.

6.9. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчид ажлын дүрэмт хувцас (өмсгөл, малгай, хормогч, ажлын гутал өмсөж гарын алчууртай)-аа бүрэн өмсөж, бөгж, бугуйвч, цаг зүүгээгүй, хумс ургуулаагүй, хумсны будаггүй, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд жилд хоёр удаа хамрагдах ба хэрэв халдварт өвчний нян тээгч илэрсэн тохиолдолд эрүүлжүүлэх арга хэмжээ авах, өвчин илэрвэл заавал эмчлүүлэх.

6.10. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэсгийн шал, хана, хаалгыг өдөр бүр цэвэрлэж, цэвэрлэгээг хийж дууссаны дараа ариутгалын бодистой халуун усаар халдваргүйжүүлэн, цэвэрлэгээний багаж хэрэгслийг тусгай байранд хадгалах.

6.11. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэсэн багаж хэрэгсэл, сав суулгыг зориулалтын угаалгын шингэнээр угааж, ариутгах.

6.12. Мэргэжлийн байгууллагаар улирал тутам хортон шавж, мэрэгчийн устгал, халдваргүйжүүлэлтийн ариутгал хийлгэх.

6.13. Хог хаягдлыг шинж чанараар нь зориулалтын таглаатай саванд ангилан цуглуулж, хогийн цооног, хог цуглуулах цэгт хаях.

Долоо. Хатуу хог хаягдал, бохир усыг зайлуулах менежментэд тавигдах шаардлага

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

7.1. Ариун цэврийн өрөө бүрт тагтай хогийн сав байрлуулах.

7.2. Сургууль бүр хатуу хог хаягдлыг цуглуулж хаях хогийн цэгтэй байх.

7.3. Сургууль, дотуур байр нь хог хаягдлын цуглуулах, зайлуулах талаар холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдөх.

7.4. Сургуулийн хогийн цооног, хог цуглуулах цэг нь сургуулиас болон усны эх үүсвэрээс 100 метр, барилга байгууламжаас 30 метрээс доошгүй зайд байрлах ба хана, хашаагаар тусгаарлагдсан битүүмжлэл сайтай хаалттай байх.

7.6. Хэсгийн цэвэрлэх байгууламжтай тохиолдолд цэвэрлэгдсэн ус нь үндэсний стандартын шаардлагад нийцсэн байх.

7.7. Бохирын цооногтой бол холбогдох дүрэм журамд заасны дагуу бохир усыг соруулан зайлуулах

БҮЛЭГ


I



**УНД, АХУЙН УС ХАНГАМЖИД ТАВИГДАХ
ШААРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ**



1 Ундны усны хангамжид тавигдах шаардлага.

Шаардлага: Ундны ус нь үндэсний стандартын шаардлагыг хангасан байх	
Тайлбар: Ундны усны аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээнүүдийг үндэсний стандартаар тодорхойлдог бөгөөд Монгол улсын стандарт нь MNS 0900:2005 юм. Энэхүү стандарт нь төвлөрсөн ба төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс хэрэглэгч хүртэлх шат дамжлаганд хүн амын унд-ахуйн зориулалтаар ашиглах усны эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын хяналт, үнэлгээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны бүх хүрээг хамарсан байдаг.	
<p>Зөвлөмж</p> 	<p>Ундны ус- хүн ам шууд уух болон хоол хүнсийг боловсруулах, ариун цэвэр, эрүүл ахуйн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор хэрэглэж байгаа чанартай аюулгүй усыг хэлнэ.</p> <p>Аюулгүй ус гэж усны эх үүсвэр, усны чанарыг сайжруулах арга, усан хангамжийн тогтолцооноос үл хамааран халдварт болон нутагшмал өвчин тархах аюулгүй, физикийн үзүүлэлт химийн найрлагаараа хор хөнөөлгүй, мэдрэхүйн үзүүлэлт(өнгө, үнэр, амт) хэвийн буюу уухад тааламжтай усыг хэлдэг.</p> <p>Ундны ус нь хэдийгээр стандартын шаардлагыг хангаж байлаа ч усны эх үүсвэрийн хамгаалалт, ус авах, зөөвөрлөх, тээвэрлэх, хадгалах явцад болон ус зөөвөрлөх хадгалах савыг цэвэрлэхгүй байх, эрүүл ахуйн буруу дадал хэвшлээс шалтгаалан бохирддог. Иймээс усны хэрэглээний зөв дадал хэвшлийг бага наснаас нь бий болгоно.</p>



Хэрэгжүүлэх арга зам

Стандартад хүн амын унд-ахуйн зориулалтаар ус ашиглагч, хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь усыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, техник технологи, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хариуцна гэж заасан байдаг. Иймд ундны усны эрүүл ахуйн нөхцөлийг хангах чиглэлээр дараах ажлуудыг хийх боломжтой юм. Үүнд:

- Ашиглагдаж буй ган хоолой нь хуучирсан бол шугам хоолойг хуванцар хоолойгоор шинэчилж солих.
- Ус хадгалах, нөөцлөх савны ариун цэвэр, эрүүл ахуйн байдалд тогтмол хяналт тавих, хэт хуучирч муудсан бол солих.
- Цэвэршүүлэх шүүлтүүр болон тоноглолын ашиглалтын зааварчилгааг дагаж мөрдөх.
- Багш, ажилчид, эцэг эх, хүүхдүүдэд ундны усыг цэвэршүүлэн халдваргүйжүүлж унданд хэрэглэх мэдлэг, дадал хэвшил эзэмшүүлэх сургалт явуулж, түүхий ус ууж болохгүй гэдгийг сайтар ойлгуулж буцалсан, шүүсэн ус уулгаж хэвшүүлэх.



Шаардлага: Усны чанар, аюулгүй байдалд жилд 2-оос доошгүй удаа шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулах

Тайлбар: Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээс баталгаатай ундны ус авах боломжтой гэж үздэг ч хэрэглэгчдийг стандартын шаардлагад нийцсэн ундны усаар найдвартай, тасралтгүй хангах үйл ажиллагаа, нөхцөл бололцоо алдагдах магадлал байдаг. Иймд усны чанарын үнэлгээг тогтмол хугацаанд хуваарийн дагуу байнга хийж байх ёстой. Ус ашиглагч, хэрэглэгч нь стандартад заасан тоо, давтамжийн дагуу усны чанар, аюулгүй байдлыг хянах, үнэлэхэд шаардагдах үзүүлэлтээр лабораторийн шинжилгээ хийлгэн баталгаажуулах, эрх бүхий байгууллагаар эрүүл ахуйн дүгнэлт гаргуулах үүрэг хүлээдэг.

Зөвлөмж



Сургууль, цэцэрлэг нь хэрэглэж буй ундны усныхаа чанар аюулгүй байдалд хяналт тавих зорилгоор шинжилгээ хийлгүүлж, дүгнэлт гаргуулах бөгөөд үүнийг аймаг, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллага болон орон нутгийн ус хангамжийн байгууллагууд хийнэ.

Шинжилгээний үр дүнд тулгуурлан эх үүсвэрийг бохирдлоос хамгаалах арга хэмжээ авах, ус цэвэршүүлэх тохиромжтой технологийг сонгох зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.



Хэрэгжүүлэх арга зам

- Усны чанар, аюулгүй байдлыг хянах, үнэлэхэд шаардагдах үзүүлэлтээр (физик хими, хатуулаг, микробиологи, цацрагийн аюулгүйн үзүүлэлт) лабораторийн шинжилгээ хийлгүүлж, баталгаажуулна.
- Мэргэжлийн хяналтын байгууллагаар эрүүл ахуйн дүгнэлт гаргуулна.
- Тухайн газар орны усны эх үүсвэр, усны чанараас шалтгаалан ус цэвэршүүлэх аргыг сонгон авдаг.


Жишээ нь: Хатуулагтай устай тохиолдолд- Ундны усны эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт “MNS 0900:2005” Үндэсний стандартад хатуулгын хэмжээ 7,0 мг.экв/л-ээс хэтрэхгүй байхаар зааж өгсөн байдаг. Хатуулагтай ус гэдэг нь кальци магнийн агуулга өндөртэй усыг хэлнэ.

Хатуулагтай усны дутагдалтай тал: Усны хатуулаг нь хүний эрүүл мэндэд хор нөлөөгүй ч хатуулагтай ус хэрэглэхэд шугам хоолой болон ус буцалгагч, цахилгаан индүү, угаалгын машин зэрэг халаах хэрэгслийн дотор өнгөр тогтдог ба үүнээс болж тухайн зүйлийн хэрэглэх хугацаа багасч, үр дүн мууддаг. Мөн саван, угаалгын нунтаг ба угаагч шингэний хөөсрөлт багасч угаалгын чанар мууддаг. Түмпэн сав, ванн, жорлонгийн дотор талд өнгөр тогтож толбо үлдэг дутагдалтай. Хатуулаг ихтэй устай газар ус зөөлрүүлэгч хэрэглэж болно. Ихэнх ус зөөлрүүлэгчид хатуулгийг багасгах зорилгоор натрийг хэрэглэнэ. Та хэдийгээр ус зөөлрүүлэгч ашигладаг ч зөөлрүүлсэн ус нь нилээд давс агуулсан байдаг тул шууд ууж хэрэглэж болохгүй. Ус зөөлрүүлэгч нь ус халааж ашигладаг хэрэгслүүдийн үр ашиг, бүтээмжийг дээшлүүлж, ашиглах хугацааг нэмэгдүүлдэг. Зарим нэг арьсны харшилтай хүмүүс юм угаахдаа зөөлрүүлсэн ус хэрэглэвэл тохиромжтой .



Шаардлага: Төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэртэй байна. Усны эх үүсвэрт эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг 50 метрээс доошгүй зайд тогтоож, дэглэмийг мөрдөх

Тайлбар: Ундны усны эх үүсвэрийн хамгаалалт нь ус бохирдох эрсдэлийг бууруулдаг, усны хамгаалалтын эхний үе шат юм. Эх үүсвэрийн хамгаалалтын бүсийн талаар мэдээлэл дутмаг байх, хамгаалалтын бүсийн дэглэмийг зөрчсөнөөр усны эх үүсвэр бохирддог.

<p>Зөвлөмж</p> 	<p>Унд ахуйн зориулалтаар ашиглаж буй гүний болон газрын гадаргын усыг ундны усны эх үүсвэр гэнэ. Эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг 50 метр зайд тогтооно. Эх үүсвэр тус бүрийн хамгаалалтыг сайжруулна.</p> <ul style="list-style-type: none"> - Гадаргын ус нь найрлага шинж чанарын хувьд тогтворгүй, улирлаар өөрчлөгдөж байдаг эрдэсжилт багатай, нянгаар амархан бохирдох боломжтой байдаг. Гадаргын усыг ундны усанд ашиглах үед зайлшгүй цэвэршүүлэх шаардлагатай. - Газрын доорх ус нь найрлага, чанарын хувьд харьцангуй тогтвортой, эрдэсжилт сайн, бохирдохдоо удаан боловч нэгэнт бохирдсон бол цэвэршүүлэхэд бэрхшээлтэй, бараг боломжгүй. Улирлаар усны түвшин, чанар өөрчлөгдөж байдаг. Газрын доорх усыг гар болон гүний худгийн тусламжтайгаар гарган авч унд ахуйд хэрэглэдэг. Газрын доорх ус нь элс, шороонд хангалттай шүүгдсэн байдаг учир ихэвчлэн нянгүй байдаг.
---	---



Хэрэгжүүлэх арга зам

Эх үүсвэр тус бүрийн хамгаалалтыг дараах байдлаар сайжруулах боломжтой.

Гар худгийн усыг ундны усны эх үүсвэр болгож буй нөхцөлд:

- Гар худгийн эргэн тойронд 30-50 м-т эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож хүн ба малын хөлөөс хамгаалж хашна.

Гүний худгийн усыг ундны усны эх үүсвэр болгож буй нөхцөлд

- Гүний худгийн эргэн тойронд 50 метрт эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож хүн малын хөлөөс хамгаалсан тор татна
- Гүний худаг голын сав газарт байгаа бол голын хоёр эргээс урсацын дагуу 50 м-т тэжээлийн дотоод бүс тогтоож тэмдэгжүүлнэ.
- Гүний худаг голын сав газарт биш бол эргэн тойрон 250 метрт хамгаалалтын бүс тогтоож тэмдэгжүүлнэ.

Нуурын усыг ундны усны эх үүсвэр болгож буй нөхцөлд

- Ус авч буй хэсэгт 50 метрт эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож хашна.
- Ус авч буй байгууламжаас 500 метрт тэжээлийн бүс тогтоож тэмдэгжүүлэн ундны усны эх үүсвэрээ хамгаалъя гэсэн анхааруулсан самбар тэмдэгийг хийж газар дээр нь босгоно.

Булгийн усыг ундны усны эх үүсвэр болгож буй нөхцөлд

- Булгийн урсацын дээд талд 50м, хажуу буюу доод талд 30м-т эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож, хүн ба малын хөлнөөс хамгаалж хашна.
- Булгийн усыг бохирдохоос хамгаалж, булгийн ус авах орчныг чулуу, тоосго, цементээр битүүмжлэх



Шаардлага: Сургууль, цэцэрлэгт хүүхэд бүр өдөрт 1 литрээс доошгүй ундны цэвэр ус уух боломжоор хангагдсан байх

Тайлбар: Хүний биеийн 55-75 хувийг ус эзлэх бөгөөд хүний бие махбодийн бүхий л эрхтэнд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүүхдийг багаас нь усыг зохистой хэрэглэх дадал, хэвшилд сургах, аюулгүй ундны ус уух нөхцөлийг бүрдүүлснээр аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлж чадна. Хүн өдрийн туршид хөлс, хэрэггүй бодисоо ялгаруулах, хоол боловсруулах явцдаа шингэнээ алдаж байдаг. Биеийн алдагдсан шингэнийг заавал нөхөж байх хэрэгтэй. Уснаас бусад шингэн(хийжүүлсэн ундаа, сүү г.м) биеийн алдагдсан шингэнийг нөхөхгүй, амны цангааг тайлахгүй учир ам цангасан үедээ цэвэр ус уух нь эрүүл мэндэд тустай юм.

Цэвэр ус уух цэгийг бий болгож, ус авах цэгээс дахин ус юулж авах боломжийг бүрдүүлнэ.



- Хүүхэд бүрийг өөрийн ус уух савтай болгох. Ингэснээр хүүхэд хүссэн үедээ хэрэгцээт ус уух боломжтой болно



- Төвлөрсөн ус хангамжийн системтэй бол ундны усыг шүүж цэвэршүүлэх тоног төхөөрөмжөөр хангана. Тухайн газар нутгийн усны чанараас хамааран ус цэвэршүүлэх тоноглолыг сонгон угсрах.
- Төвлөрсөн бус ус хангамжийн системтэй бол ундны усыг шүүж цэвэршүүлэх болон буцалгаж халдваргүйжүүлэн ус уух боломж бүрдүүлнэ.
- Гал зуухны өрөөнд ус цэвэршүүлэх шүүлтүүр тоноглох.
- Ус цэвэршүүлэх шүүлтүүрийн ашиглалтын зааврыг дагаж мөрдөх
- Сурагчдад гэрээсээ ус уух савандаа буцалгаж хөргөсөн буюу шүүж цэвэрлэсэн ус авчирч уух дадлыг хэвшүүлэх
- Хадгалах хугацаа, тээвэрлэлт болон шаардлага хангасан савласан ус ууж болно.

Зөвлөмж





Хэрэгжүүлэх арга зам

- Шүүсэн болон буцалгаж хөргөсөн ус бэлтгэж хангана.
- Сурагчид болон эцэг эхчүүдэд хүүхэд бүр ус уух савтай байх, ус уухын ач холбогдлыг ойлгуулж, мэдээлэл өгөх.
- Усны шүүлтүүр нь элсэн, керамик, мембран гэж байх бөгөөд бактер, вирус, эгэл биетэн, шимэгч хорхой, давс, өнгө, булингар, төмөр, манганийг цэвэршүүлнэ. Харин усанд ууссан химийн бодисыг шүүхэд үр дүн багатай. Усны хольц, юунд хэрэглэхээс хамааран усны шүүлтүүрээ сонгоно. Шүүлтүүр нь төрлөөсөө хамаараад усан дахь механик хольц, хүнд металл, хлор, органик нэгдэлүүд, хатуулгийн давс зэргийг арилгана. Шүүлтүүрүүд нь өрхийн түвшний бортогот, төвийн шугаманд холбогддог, зөөврийн ус хангамжийн системд холбогддог, угаагуурын доор, цоргонд суурилуулдаг гэх мэт олон төрөл байна.
- Ус цэвэршүүлэгч шүүлтүүрийн цоргыг байнга цэвэрлэх, шүүлтүүрийг хугацаанд нь солиж байх

(Усны шүүлтүүрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 32-58-р хуудсанд оруулсан бөгөөд та өөрийн цэцэрлэг, сургууль, дотуур байрын хэрэгцээнд тохируулан шүүлтүүрээ сонгон хэрэглээрэй.)

Ус цэвэршүүлэх шүүлтүүрийн ангилал

		Элсэн шүүлтүүр	Керамик(шавран) шүүлтүүр	Мембран шүүлтүүр
Ажиллах зарчим		Шүүлтүүр дотор байх элс, хайргаар ус шүүгддэг.	Шавар усны шүүлтүүрийг ус шүүх савны ёроолд суулгаж, шүүгдсэн усны савны амсар дээр, шүүх усны савны ёроолыг тааруулан байрлуулж шүүсэн усаа тосч авна.	Нимгэн, нүдэнд үл үзэгдэх сүвтэй ус шүүх зориулалтын мембранаар ус шүүгдэн гарч, том хэсгүүд нь шүүгдэж чадахгүй мөмбранд үлддэг.
Цэвэрлэгээний үр дүн	Үр дүнтэй	нян, эгэл биетэн, шимэгч, амт, үнэр, өнгө	нян, эгэл биетэн, шимэгч, амт, үнэр, өнгө	нян, вирус, эгэл биетэн, шимэгч хорхойг шүүнэ
	Бага үр дүнтэй	Вирус, төмөр	вирус, төмөр	Өнгө, булингар, төмөр, манган
	Үр дүнгүй	Ууссан химийн бодисууд	Ууссан химийн бодисууд	Химийн бодис, шавьж устгагчид, хүнд металл



Шаардлага: Ундны ус зөөх, хадгалах сав нь таглаатай, угааж цэвэрлэхэд хялбар, хүнсний зориулалтын материалаар хийгдсэн, хүүхдийн эрүүл мэндэд эрсдэлгүй байх

Тайлбар: Айл өрх, албан байгууллагууд ундны ус зөөх, хадгалахдаа зориулалтын бус савыг ашиглах нь түгээмэл байгаа бөгөөд энэ нь усны чанар, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөг үзүүлж байна. Хүнсний бүтээгдэхүүний зориулалттай сав суулгыг ган, хөнгөн цагаан, төмөр, зэс, шил, шаазан, шавар, хуванцар гэх мэт материалаар үйлдвэрлэдэг. Эдгээр материал нь эрүүл ахуйн хувьд хүнсэнд хоргүй шинж чанартай, мэдрэхүйн үзүүлэлтэд нөлөөлөхгүй байх, савны материалын бүрэлдэхүүн хэсгүүд хүнсэнд шилжиж ордоггүй байх, орсон тохиолдолд тогтоосон норм хэмжээнээс давахгүй байх шаардлагатай юм.

Зөвлөмж



Ус хадгалах болон зөөвөрлөх саванд тавих шаардлага:

1. Ус хадгалах ба зөөвөрлөх сав нь тусдаа байх;
2. Ус хадгалах, зөөвөрлөх сав нь усанд уусдаггүй, зэвэрдэггүй, хүний эрүүл мэндэд хоргүй материалаар(ган эсвэл хуванцар) хийгдсэн байх;
3. Эдэлгээ даах бат бөх, тогтвортой суурьтай байх;
4. Усны сав нь тоос шороо орохоос хамгаалах тагтай, дотор талыг нь цэвэрлэхэд хялбар том амсартай, жигд гадаргуутай;
5. Ус хадгалах, зөөвөрлөх сав нь хуванцар материалтай бол 7 PC тэмдэглэгээтэй 100% аюулгүй BPA –үгүй, бат бөх, үнэргүй, хуванцар савны амтгүй, ус хадгалах савнаас усанд химийн бодис шилждэггүй байх шаардлагатай.


(Хуванцар савны тэмдэглэгээг 25-26-р хуудаснаас харна уу)




Хэрэгжүүлэх арга зам

Ус хадгалах сав нь зөөвөрлөх савыг бодвол багтаамж ихтэй байна.


Ус нөөцлөх сав, усан сан нь сурагчдын тооноос хамааран 1-8 тонны багтаамжтай, ган болон хуванцар материалтай байна. Мөн тагтай, цэвэрлэж халдваргүйтгэх боломжтой байх. Хэрэв өөрийн гүний худагтай бол ус хадгалах савны хэмжээг багасгах эсвэл даралтат сав(вакум бак) суурилуулах



- Зориулалтын бус сав (химийн бодис байсан, ямар зориулалттай нь үл мэдэгдэх тэмдэглэгээгүй сав) хэрэглэхээс татгалзах



- Цорготой усны сав хэрэглэх. Энэ нь ус бохирдохгүй байх ач холбогдолтой



- Ундны ус хадгалах, зөөх савыг байнга таглаатай байлгах.



Усны сав хуучирч элэгдсэн бол яаралтай солих хэрэгтэй. Учир нь элэгдэж чанараа алдсан савны гадаргуу дээр зураас, толбо бий болж, ус хадгалах савнаас усанд шилжих хорт бодисын агууламж ихэсдэг. Мөн хуучирсан савны гадаргуу дээр төрөл бүрийн нян үржих аюултай байдаг.

Шаардлага: Ундны ус хадгалах савыг 7 хоногт 1-2 удаа бүрэн суллаж, угааж, халдваргүйтгэх

Тайлбар: Усны цэвэр байдлыг алдагдуулдаг хамгийн гол эх үүсвэр нь ус зөөвөрлөх болон хадгалах сав бохир байх явдал юм. Иймээс усны савыг тогтмол угааж цэвэрлэх нь эрсдэлийг бууруулах хамгийн гол арга хэмжээний нэг юм.

Зөвлөмж



- Усны саванд шинээр ус нэмж хийхийн өмнө заавал угаах шаардлагатай. Учир нь усны савыг цэвэрлэхгүй удахад савны хана, ёроолд нимгэн өнгөр тогтож энэ нь нян үржих таатай орчинг бүрдүүлдэг байна. Иймд 3-7 хоног тутамд угааж, цэвэрлэх хэрэгтэй.
- Усыг зориулалтын таглаатай саванд хадгалах, шинээр ус нэмэх бүрт ус хадгалах савыг бүрэн суллан цэвэрлэж байх.
- Ус хадгалах савыг нарны гэрэл шууд тусахгүй, сэрүүн газар байрлуулах ба гэрийн тэжээмэл амьтнаас хол байлгах;
- Хэрэв гол, мөрөн болон нуурын уснаас авч хэрэглэдэг бол шууд уухыг хориглох бөгөөд зөөвөрлөн авчирч ус хадгалах саванд хийхдээ самбай даавуу (марль) болон ЛаМотте шүүлтүүрээр шүүнэ. Заавал буцалгаж эсвэл халдваргүйжүүлж унданд хэрэглэнэ.
- Ундны усыг тасалгааны температурт 3 хоногоос илүү хугацаагаар хадгалж болохгүй. Учир нь ус хадгалж байгаа савны ёроолд үүссэн тунадасанд өвчин үүсгэгч нян үржих бололцоотой. Усны саванд бохир гар болон аяга, шанага дүрэхгүй байх
- Ус хадгалах савнаас шууд уухгүй байх
- Хүүхэд, гэрийн тэжээмэл амьтан, шувуу болон шавьж саванд хүрэхээс сэргийлэх.




Хэрэгжүүлэх арга зам

Багш, ажилчид, эцэг эх, хүүхдүүдэд ундны усыг зөөвөрлөх хадгалах явцад бохирдохоос урьдчилан сэргийлэх талаар сургалт хийж мэдээлэл хүргэх.

Ус хадгалах савыг угаахдаа:

- Усны савыг 3 хоногт 1 удаа бүрэн суллаж зайлж цэвэрлэх, долоо хоногт 1 удаа угааж халдваргүйжүүлнэ.





- Савыг угаахын өмнө гараа сайн угаасан байна.
- Ус хадгалах савыг бүрэн суллан усаар зайлна.
- Савны дотор талыг аяга таваг угаагч шингэн бүхий халуун усаар сайтар угаана.

Ялангуяа савны амсар, хүзүүвч хэсгийг сайн угаах хэрэгтэй. Үүний дараа савны гадна талыг аяга таваг угаагч шингэн бүхий халуун усаар сайтар угаана.

- Савны гадна, дотор хэсгийг усаар дахин зайлна.
- Усны савыг аль болох алчуураар арчихгүй өөрөөр нь хатаах буюу нарны гэрэлд 15-20 минут байлгана. Нар нь нян, бактерийг устгах нөлөөтэй тул савыг бүрэн ариутгаж өгдөг ач холбогдолтой.

Усны сав ихээр бохирдсон бол ариутгагч уусмалаар дүүргэн 30 минут байлгасны дараа ариутгагч уусмалыг асган цэвэр усаар сайтар зайлна. Савыг цэвэрлэхгүй бохир байлгах болон эрүүл ахуйн буруу дадал хэвшлээ өөрчлөх

Усны сав ихээр бохирдсон бол ариутгагч уусмалаар дүүргэн 30 минут байлгасны дараа ариутгагч уусмалыг асган цэвэр усаар сайтар зайлна. Савыг цэвэрлэхгүй бохир байлгах болон эрүүл ахуйн буруу дадал хэвшлээ өөрчлөх

Шаардлага: Сурагчид хувийн аяга болон ундны ус уух савтай байх

Тайлбар: Хүүхдийн бие, хөдөлгөөн, насны онцлогоос шалтгаалан амархан цангаж шингэн дутагддаг учир өөрийн ус уух савтай болсноор хэрэгцээтэй үедээ ус уух боломжтой болж, өсөлт хөгжилтөнд нь сайнаар нөлөөлнө.

Зөвлөмж



Хүүхдийн Ус уух саванд тавигдах шаардлага:

- Усны савны хэмжээ нь 250-500 мл байх.
- Хүүхдийн ус уух сав нь таглаатай, дахин ашиглах боломжтой, зориулалтын материалаар хийгдсэн байх.
- Авч явахад хөнгөн, бат бөх, богино оосортой байх
- Угааж цэвэрлэхэд хялбар, том амсартай байх
- Хүүхдийн ус уух савыг 7 хоногт 1-2 удаа бүрэн суллаж, угааж, халдваргүйтгэнэ.
- Сурагчдад өөрийн усны савандаа ус ууж хэвшүүлэх
- Усны савны зөв хэрэглээний талаар сургалт явуулах



Хэрэгжүүлэх арга зам

Хүүхэд бүрт өөрийн ус уух савтай байхын ач холбогдлыг ойлгуулж, савтай болгох





HDPE



PP



BPA FREE



OTHER

тэмдэглэгээ бүхий хуванцар сав хэрэглэж болно. (Хуванцар савны тэмдэглэгээг хавсаргав.)
Усны савыг бүрэн суллан усаар зайлна. Савны дотор талыг ариутгалын бодис ашиглан, тусгай
сойзоор үрж угаана.Цэвэр усаар сайтар зайлж хатаана.

Сургууль дээрх уст цэгээс ундны цэвэр ус авч ууж хэвших. Мөн гэрээсээ ус уух савандаа
буцалгаж хөргөсөн буюу шүүж цэвэрлэсэн ус авчирч ууна.

- Усны саваа бусдад дамжуулж болохгүй, бусад хүүхдийн ус уух савнаас ам дамжуулан ус ууж
болохгүй гэдгийг багаас нь зааж сургах.

Сургуулийн дотуур байрны нэмэлт шаардлага

Шаардлага: Дотуур байрын сурагч бүр өдөрт 2 литрээс доошгүй ундны ус уух
боломжоор хангагдсан байх

Тайлбар: Хүн өдрийн туршид хөлс, хэрэггүй бодисоо ялгаруулах, хоол боловсруулах
явцдаа шингэнээ алдаж байдаг. Биеийн алдагдсан шингэнийг заавал нөхөж байх
хэрэгтэй. Уснаас бусад шингэн(хийжүүлсэн ундаа, сүү г.м) биеийн алдагдсан
шингэнийг нөхөхгүй, амны цангааг тайлахгүй учир ам цангасан үедээ цэвэр ус уух нь
эрүүл мэндэд тустай юм.

Зөвлөмж



- Дотуур байрын сурагч бүрт өдөрт 2 литрээс доошгүй ундны ус уух боломж
нөхцөлийг бүрдүүлж, уст цэгийг бий болгоно.Халуун хүйтэн ус гардаг ус
цэвэршүүлэгч байрлуулж, суурилуулах
- Мөн усаа шүүх, тунгаах, цэвэрлэгээ хийж буцалгаад хөргөх (300 C). Зах
зээлд өргөнөөр хэрэглэгдэж буй 18,9 литр багтаамжтай хуванцар саванд
юулж дээр нь гар хөөргүүр (насос) тавьж суурилуулан хүүхдүүд өөр өөрсдийн
саванд хийж авч уух боломж бүрдүүлэх.



Хэрэгжүүлэх арга зам


- Төвлөрсөн системтэй сургуулийн дотуур байр бол шууд ус цэвэршүүлэгч холбоно.
- Төвлөрсөн бус системтэй сургуулийн дотуур байр 18,9 литрийн багтаамжтай ус
нөөцлөх савтай усны шүүлтүүр тавина.
- Мөн ус буцалгагч байрлуулах.
- Байрын багш дотуур байрын сурагчдад усны эрүүл ахуйн зөв дадлыг хэвшүүлэх
зөвлөмжийг өгдөг байх.

Сайн туршлага: УБ хотын Налайх дүүргийн “Эрдмийн Оргил” цогцолбор сургууль
дээр НҮБ-н Хүүхдийн сангаас дунд сургуульд 1ш, бага сургуульд 1ш, сурагчдын дотуур
байранд 3ш ус цэвэршүүлэгч суурилуулсан байна.





2. Ахуйн хэрэглээний ус хангамжид тавигдах шаардлага

<p>Шаардлага: Сурагч бүр хувийн ариун цэвэр сахихад 6-7 литр усны хангамжтай байх. Усаар зайлуулдаг бие засах газартай сургуулийн сурагчид өдөрт 10-15 литр усны хангамжтай байх</p>	
<p>Тайлбар: Хүүхдүүдэд сургууль дээрээ гар угаах, хувийн ариун цэвэр сахих хэрэгцээ байнга гардаг. Усан хангамж дутагдалтайн улмаас энэ хэрэгцээгээ хангаж чадахгүй байх нь халдварт өвчин гарах нэгэн шалтгаан болдог. Ус хангамж сайжирснаар эрүүл мэндтэй холбоотой зан үйл сайжирч улмаар халдварт өвчин гарахгүй байх боломж бүрддэг.</p>	
<p>Зөвлөмж</p> 	<ul style="list-style-type: none"> - Сургууль, сургуулийн дотуур байрны хүүхдийн тоо, хэрэглээнээс хамаарч ус нөөцлөх савны хэмжээг сонгоно. Жишээ нь тухайн сургуулийн сурагчид, багш ажилчдын тоо 450 гэж үзвэл $450 \times 6л = 2700$ буюу 2.7 тонн хэмжээтэй ус нөөцлөх сав хэрэгцээтэй болох нь. Ус нөөцлөх савыг сонгохдоо усанд уусдаггүй, зэвэрдэггүй хүний эрүүл мэндэд хоргүй материалаар хийгдсэн зориулалтын сав сонгоно. - Хөрсний онцлогоос шалтгаалан бохир ус зайлуулах системийг шийдэх




Хэрэгжүүлэх арга зам

Манай орны зах зээл дээр ус нөөцлөх сав, усан сан нь 1-200 тонны багтаамжтай олон янзын сонголттой байна. Мөн зөөврийн өөрийн хэрэгцээндээ тааруулж хүссэн хэмжээгээр угсарч болдог, ган болон хуванцар материалтай байдаг.

Усыг удаан хадгалах, ус хадгалах савыг цэвэрлэж, халдваргүйжүүлээгүйгээс бохирдол үүсч улмаар хүн амын дунд усаар дамжин халдвар тарах эрсдэлтэй байдаг. Иймд хавар, зун, намрын дулааны улирал тутамд ус хадгалах, нөөцлөх саванд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, угаалга хийх шаардлагатай.

(Хавсралт 4 -т ус нөөцлөх сав болон, усан сан худалддаг зарим байгууллагын мэдээллийг оруулсан болно.)

<p>Шаардлага: Ил задгай усны эх үүсвэр нь жорлон болон бохир ус, ариутгах татуургын ус зайлуулах хоолойноос хөрсний байдлаас шалтгаалан наад зах нь 30-50 метр хол байх</p>	
<p>Зөвлөмж</p> 	<p>Усны урсацын дээр жорлонгийн нүх, бохир усны хоолой, хог хаягдлын цэг, малын хашаа, уул уурхай, газрын тосны өрөмдлөгийн талбай байж болохгүй. Харин усны урсацын доор хамгийн багадаа 30 метрээс багагүй зайд байх</p>



Хэрэгжүүлэх арга зам

Гар ба гүний худагт дараах шаардлагуудыг тавина. Үүнд:

- Худгийн эргэн тойрны газрын хөрс бүрэн бүтэн, хөрсөнд ан цав, цууралт үүсээгүй байх



- Газрын гадарга нь тэгш, төвгөр, газар дээрх налуу хэсэг нь цементэн хучилт болон хашлагатай байх
- Худагт хамгаалалтын бүс тогтоох (Гүний өрөмдмөл худгийн эргэн тойрон 50 метрт)
- Эргэн тойрондоо хашаатай байх
- Хүрээлэн буй орчны бохирдлоос сэргийлсэн байх
- Худгийн амсар таг, халхавчтай байх
- Худгийн дотор талыг мод, чулуу, бетон зэргээр доторлосон байх

Сургуулийн дотуур байрны нэмэлт шаардлага

Шаардлага: Хүүхэд бүр гар угаах, усанд орох болон бусад хэрэглээндээ өдөрт 20 литр усны хангамжтай байх

Зөвлөмж



- Дотуур байрын сурагчдын тоотой уялдуулан ахуйн хэрэгцээний ус нөөцлөх савыг сонгоно.(1-10тонн)
- Хэрэгцээндээ тохирсон бие даасан халуун ус хангамжийн системийг сонгож суурилуулах
- Бие даасан халуун ус хангамжийн систем болон ус эрчим хүчинд хэмнэлттэй технологийн мэдээллийн дэлгэрэнгүйг энэхүү гарын авлагын ариун цэврийн байгууламжийн хэсгээс (94-97-р) хуудаснаас үзнэ үү.
- Ус хангамжийн эх үүсвэрийг өвлийн улиралд хөлдөлтөөс урьдчилан сэргийлэх. Тасралтгүй, найдвартай усаар хангахад хөлдөлтөөс хамгаалах нь чухал юм. Хүйтний улиралд газрын хөрсний хөлдөлтийн гүн, агаарын хэмээс хамаарч ус нөөцлөх сав, дамжуулах хоолойд хөлдөх аюул тулгарч байдаг.







Хэрэгжүүлэх арга зам

Бие даасан халуун ус хангамжийн системийн төрлүүд:






- Эзэлхүүний ус халаагч: Ус болон үл хөлдөх шингэний аль алинаар ажилладаг. Мөн хатуу түлшний(нүүрс, мод) зуухтай хавсруулж ашиглахад нэн тохиромжтой. Бүрэн автомат тохируулагчтай тул хэрэгцээндээ хяналт тавьж болно.
- Агшин зуурын ус халаагч: хэрэглээний халуун ус шаардлагатай үед усыг маш богино хугацаанд халааж гаргадаг, эрчим хүч бага зарцуулдаг, эдийн засагт хэмнэлттэй.
- Гүний худагт эргэлтийн шугам төлөвлөж өгөх
- Шугам хоолой, хаалт арматурыг дулаалах, халаалтын кабель угсрах
- Хүүхдүүдэд угаалга цэвэрлэгээгээ хийхэд шардлагатай угаалгын машин суурилуулж өгнө.



Хуванцар савны тэмдэглэгээ

Тэмдэглэгээ	Тодорхойлолт	Шинж чанар	Хэрэглээ
 PETE	PETE Полиэтилен терефталат хуванцраар хийсэн сав суулгыг хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний сав баглаа болгон ашигладаг.	Хий болон чийгийг маш сайн тусгаарлах шинж чанартай, хэт ягаан туяа, болон халууны нөлөөгөөр бүтэц нь задардаг тул халуун зүйл хийж болохгүй, наранд тавьж болохгүй, дахин хэрэглэж болдоггүй байна. (Зөвхөн нэг удаагийн хэрэглээний гэдгийг анхаарна уу.) Нягт 1.35-1.38г/см ³	Ус, ундаа, шар айрагны зөөлөн сав, ам зайлах сав, самрын тос, салат болон хачирны сав болгон ашигладаг. Мөн ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд өргөн ашиглаж байна.
 HDPE	HDPE Өндөр нягттай полиэтилен хуванцраар хийсэн савыг богино хугацааны хадгалалт даадаг (сүү г.м) бүтээгдэхүүний сав баглаа болгон хэрэглэхэд нэн тохиромжтой.	Хатуу, бат бөх чанартай, нугардаггүй, хэлбэр дүрсээ өөрчилдөггүй бөгөөд боловсруулах горим хялбар, чийг болон химийн бодисыг эсэргүүцэх чанартай, хий нэвчих чадвартай. (Хэт ягаан туяа, болон халууны нөлөөгөөр бүтэц нь задардаг тул халуун зүйл хийж болохгүй, наранд удаан тавьж болохгүй.) Нягт 0.94-0.96г/см ³	Ус, сүү, тарагны сав, гялгар уут, цайруулах болон угаалгын нунтаг, шампуны сав, хогийн уут, моторын тосны сав, цөцгий болон маргарины сав, үр тариа хадгалах сав хийхэд ашигладаг.
 PVC	PVC эсвэл V Винил, болон Поливинил хлорид хуванцар нь ус зайлуулах хоолой, сантехникийн хэрэгслүүдийг үйлдвэрлэхэд өргөн ашигладаг.	Хатуу бат бөх чанартай, нугардаггүй, хэлбэрт хурдан ордог, боловсруулах горим хялбар, тослох материал, тос болон химийн бодисыг эсэргүүцэх чанартай. (Ус, хоол хүнсний зориулалтаар ашиглаж болохгүй.) Нягт 1.32-1.42г/см ³	Шил өнгөлөгч, угаалгын нунтаг, шампуны сав, хүнсний скоч, цахилгааны утасны бүрхүүл, труба хоолой г.м.
 LDPE	LDPE Бага нягттай полиэтилен	Хатуу бат бөх чанартай, уян хатан шинж чанартай. Хүнсний бүтээгдэхүүн савлахад аюулгүй. Нягт 0,91-0,93г/см ³	Талхны сав, хивс, зургийн хальс, галын хэрэгслийн эд ангиуд, хөлдөөсөн хүнсний бүтээгдэхүүний сав үйлдвэрлэхэд ашигладаг.



 PP	<p>PP Полипропилен хуванцар нь халууныг тэсвэрлэх чанартай учир хүнсний бүтээгдэхүүнийг халаах зориулалттай сав суулга хийхэд ашигладаг.</p>	<p>Хатуу, бат бөх, уян хатан, халуунд тэсвэртэй(-20С-100С) Хүнсний хэрэгцээнд аюулгүй байдлыг хангаж чаддаг, халуун бүтээгдэхүүн хийхэд тохиромжтой, дахин хэрэглэж болдог. Нягт 0,90-0,93г/см³</p>	<p>Хүнсний бүтээгдэхүүн хадгалах сав, аяга таваг, автомашины эд анги</p>
 PS	<p>PS Полистирен хуванцар нь бага температурт хайлах чанартай тул хатуу болон хөөсөрдөг бүтээгдэхүүнийг хадгалах сав хийхэд голчлон ашигладаг.</p>	<p>Хэлбэрт хурдан ордог, дулааныг сайн тусгаарладаг. Нягт 1.03-1.06г/см³</p>	<p>Нэг удаагийн хоолны сав, хөөсөнцөр аяга таваг,поднус, өндөгний сав, дүрс бичлэгийн хуурцаг, гэрлийн унтраагуур, хөөсөрдөг бүтээгдэхүүний сав зэргийг хийхэд хэрэглэдэг,</p>
 TRITAN	<p>TRITAN савыг ундны цэвэр усны сав, баглаа болгон ашиглах нь түгээмэл бөгөөд үнэ хямд, хөнгөн жинтэй, хагарч хэмхрэхгүй учир удаан хэрэглэж болно.</p>	<p>Хий болон чийгийг маш сайн тусгаарлах шинж чанартай, халуун хүйтэнд тэсвэртэй, хөнгөн жинтэй, бат бөх чанартай.Нягт 1.35г/см³</p>	<p>Халуун, хүйтэн ус хийж өдөр тутам ашиглахад зориулагдсан</p>
 BPA FREE	<p>BPA FREE 7 савыг ундны цэвэр усны сав баглаа болгон ашигладаг. Хөнгөн жинтэй, хагарч хэмхрэхгүй.</p>	<p>Хий болон чийгийг маш сайн тусгаарладаг, хатуу, бат бөх, халуун тэсвэртэй, чийг болон хий нэвтрүүлдэггүй.Нягт 1.35г/см³</p>	<p>Ундны цэвэр ус хадгалах, уух зориулалттай сав</p>
 OTHER	<p>Бусад төрлийн хуванцарууд: acrylic acrylonitrile, butadiene styrene, fiberglass, nylon, polycarbonate, polyactic acid</p>	<p>Аюултай хуванцар Энэ төрлийн зарим хуванцар нь хорт хавдар үүсгэх магадлалтай “Bipshe-pol A” (BPA) гэдэг бодис агуулдаг тул анхааралтай сонгох хэрэгтэй, ийм саванд халуун зүйл хийж болохгүй.</p>	<p>Зөвхөн химийн бодис хадгалах, зөөвөрлөхөд ашиглана</p>



Манай зах зээл дээр зарагдаж буй усны шүүлтүүрийн төрөл, үнэ ханшийн мэдээлэл

Шүүлтүүрийн нэр	Шүүлтүүрийн төрөл	Үйлдвэрлэсэн улс	Өрхийн түвшинд хэрэглэх боломжтой эсэх	Нийтийн хэрэгцээнд ашиглах боломжтой эсэх	Хэмжээ (литр)	Үнэ	Худалдаг компани, дэлгүүрийн нэр
HYUNDAI Naturife	Мембран	Өмнөд Солонгос	тийм	тийм	3.5 литр	35,000 – 52,000 төг	Аргил сувд ХХК
MAGIC WPU 6200	Мембран	Өмнөд Солонгос	тийм	үгүй	4 литр	450,000 – 490,000 төг	Aquashop
Элсэн шүүлтүүр	Элсэн	АНУ	үгүй	тийм	500-600 литр	680,000 төг	Aquasana
Элсэн шүүлтүүр	Элсэн	Орос	тийм	тийм	500 литр	550,000 төг	Eco water
WPU8230	Мембран	Өмнөд Солонгос	тийм	тийм	4 литр	580,000 төг	Aquashop
WPU8200	Мембран	Өмнөд Солонгос	тийм	тийм	4 литр	550,000 төг	Aquashop
Romeo I / analogy/	Мембран, нүүрсэн	Өмнөд Солонгос	үгүй	тийм	20 литр	700,000 төг	Aquashop
Romeo II /analogy/	Мембран	Өмнөд Солонгос	тийм	тийм	6 литр	650,000 төг	Aquashop
Romeo I / digital/	Мембран, нүүрсэн	Өмнөд Солонгос	тийм	тийм	20 литр	700,000 төг	Aquashop
Romeo II / digital /	Мембран	Өмнөд Солонгос	тийм	тийм	6 литр	680,000 төг	Aquashop
Juliet II / digital/	Мембран	Өмнөд Солонгос	тийм	тийм	6 литр	690,000 төг	Aquashop
W2-340E	Мембран	Өмнөд Солонгос	тийм	тийм	5 литр	590,000 төг	Aquashop
Nov-ta-NWP-1100s	Мембран	Өмнөд Солонгос	тийм	үгүй	3 литр	650,000 төг	Aquashop
Fresh water 500RO	Мембран	Өмнөд Солонгос	тийм	үгүй	30 литр	590,000 төг	Ecowater
F-303	Мембран	Орос	тийм	үгүй	литр	680,000 төг	Ecowater
WPU8905	Мембран	Өмнөд Солонгос	тийм	тийм	19 литр	800,000 төг	Aquashop
FW 320B	Мембран	Өмнөд Солонгос	тийм	үгүй	5 литр	550,000 төг	Aquashop



FW 320sb	Мембран	Өмнөд Солонгос	тийм	үгүй	5 л литр	550,000 төг	Aquashop
WPU-5900F	Мембран	Өмнөд Солонгос	тийм	тийм	18 литр	650,000 төг	Aquashop
ECR-3000-R20	Мембран	Орос	үгүй	тийм	5000 литр	1.190,000 төг	Ecowater
Housing 10	Мембран	Өмнөд Солонгос	үгүй	тийм	5000 литр	1.290,000 төг	Ecowater
Multi Housing 3	Мембран	Өмнөд Солонгос	үгүй	тийм	5000-10000 литр	1.950,000 төг	Ecowater
Housing 20	Мембран	Өмнөд Солонгос	үгүй	тийм	5000-10000 литр	1.890,000 төг	Ecowater
Barier Винни	Мембран	Орос	тийм	үгүй	2,6 литр	41,000 төг	Барьер
$88 : 30 \approx 3$ $47 : 50 \approx 1$ Эрүүл ахуйн сургалтаар хөвгүүдэд шээлтүүр хэрэглэж хэвших талаар сургалт, мэдээлэл хүргэх.

Ашиглахгүй байгаа хуучин бие засах өрөөнүүдийг засаж янзлах.Энэ ажилд төсөл хөтөлбөрүүдийн дэмжлэг, орон нутгийг хөгжүүлэх сангийн мөнгийг татах.¹


Бага ангийн тасалгаагүй суултууруудын хоорондын зай 0,6м




Зөвлөмж: Шээлтүүр нь урт босоо байвал аль ч насны хөвгүүд хэрэглэх боломжтой

Сайн туршлага: “ЭйСиЭф-Монгол” ОУБ

Агуулах болгон хэрэглэж байсан ариун цэврийн өрөөг засварлаж дөрвөн тасалгаатай хөвгүүдийн ариун цэврийн өрөө болгосон. Сул байгаа орон зайд шээлтүүр суурилуулснаар хүртээмжийг нэмэгдүүлсэн.



Зураг 1. Зориулалтыг өөрчилсөн, зай талбайг бүрэн ашиглаагүй ариун цэврийн өрөөнүүд




Зураг 2. Гаднаа шээлтүүртэй, суултуур бүр тасалгаатай, хаалгатай ариун цэврийн өрөө

ТАЙЛБАР: Эх сурвалж: Сонгинохайрхан дүүргийн Ирээдүй цогцолбор

Ариун цэврийн өрөөг зөв төлөвлөх, засварлах, ашиглах зөвлөмж, сайн туршлага

Сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн өрөө нь хүртээмжтэй, **байнгын ажиллагаатай, ашиглагдахуйц**, аюулгүй, хувийн орон зайг хангасан, цэвэрхэн, хүүхдийн нас хүйсийн онцлогт тохирсон байх.

Шаардлага: Ариун цэврийн байгууламж нь стандартын шаардлага хангасан байнгын ажиллагаатай байх	
Тайлбар: Хүний бие засах хэрэгцээ хойшлуулашгүй байдаг тул бие засах газар нь байнга ажилладаг, хэзээ ч ашиглах боломжтой байх ёстой. Гэтэл зарим сургууль дээр ОО цоожтой, суултуур нь ус татах боломжгүй эвдэрхий эсвэл усыг хаасан байдаг. Энэ нь ОО-ын хүрэлцээг улам л бууруулдаг.	
	<ul style="list-style-type: none">- Бие засах өрөөг өдөр шөнийн аль ч цагт цоожгүй, нээлттэй байлгана.- Бие засах өрөө хичээлийн анги танхимтай аль болох ойр, олоход хялбар байна.- Бие засах өрөөний гадна тэмдэглэгээ заавал байна. (харанхуйд гэрэлтдэг байвал сайн)- Эвдэрсэн суултуур, ус татагч зэргийг тухай бүр засварлаж, бүх л суултуур шээлтүүрийг ашиглахад бэлэн байлгах- Сургуулийн ОО-д суултуур амархан бохирддог тул явган суултуур тавих нь ашиглахад хялбар, илүү цэвэрхэн байдаг.- Ая тухтай бие засч болохоор тоноглогдсон байна. Үүнд: хаалга дотор талдаа цоожтой, өндөр нам 2 өлгүүртэй, хогийн савтай, ОО-ын цаастай.



Хэрэгжүүлэх арга зам

Бие засах өрөөг нээлттэй байлгахын чухлыг үйлчилгээний ажилтнуудад ойлгуулсан, тэднээр зөвшөөрүүлсэн байна. Тэмдэглэгээ нь коридорт явах хүмүүст харагдахаар товойж хадагдсан байна.

Сурагчдад бие засах газрыг зөв боловсон ашиглах талаар сургалт явуулах, уралдаан зохион байгуулах. Сургуулийн захиргаа урсгал жижиг засвар хийх мөнгийг төсөвлөсөн байх.

Бие засах өрөөг тоноглоход гарах зардал харьцангуй бага Жишээ нь: цоож, 2ш өлгүүр, хогийн сав дунджаар 30-35мянган төгрөг Сурагчид өөрсдөө ОО-ын цаас биедээ авч явж хэвшихийг зөвлөх.



Зөвлөмж: Хажуу хананд өндөр, нам 2 өлгүүр хадаж өгөх. Хувцсыг өндөрт хадсан өлгүүрт, цүнхийг нам өлгүүрт өлгөж хэвшүүлэх.


Сайн туршлага: “ЭйСиЭф-Монгол” ОУБ

Тасалгааны талбайг нэмэгдүүлж тав тухай болгосон, явган суултуур суурилуулсан нь аль ч насны хүүхэд хэрэглэх боломжтой болж, илүү цэвэрхэн, удаан эдэлгээтэй зэрэг сайн талтай.



Зураг 3. Ариун цэврийн өрөөний таславчийг зай талбай бүрэн ашиглаагүй хийсэн, шээлтүүр нь ажилладаггүй

ТАЙЛБАР: Эх сурвалж: Сонгинохайрхан дүүргийн 12, 107-р сургууль



Зураг 4. Явган суултууртай бие засах өрөө

Ариун цэврийн өрөөг зөв төлөвлөх, засварлах, ашиглах зөвлөмж, сайн туршлага

Сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн өрөө нь хүртээмжтэй, байнгын ажиллагаатай, ашиглагдахуйц, **аюулгүй**, хувийн орон зайг хангасан, цэвэрхэн, хүүхдийн нас хүйсийн онцлогт тохирсон байх.

Шаардлага: Жорлон нь аюулгүйн шаардлагыг хангасан байна.	
Тайлбар: Сургууль цэцэрлэгийн нийтийн бие засах газар аюулгүй байх нь их чухал. Жишээ нь хальтиргаатай, цахилгааны утас ил, цонх нь хагархай, агааржуулалтгүй, гэрэлгүй гэх мэт байдал нь хүүхдийг аюул осолд өртөх эрсдлийг нэмэгдүүлнэ.	
<p>Зөвлөмж</p>	<ul style="list-style-type: none"> - ОО-ын өрөөний цахилгааны холболт зөв хийгдсэн, цахилгааны утас далдлагдсан, унтраалга, разетка галын аюулгүй байх. - Цонх, цонхны салхивч хамгаалалтын тортой байх эсвэл салхивч нь хүүхдийн гар хүрэхгүй дээд талдаа байх. - Агааржуулалтын хоолойтой, агаарын урсгал зөв байх. - Шал хальтирдаггүй байх. - Суултуур, шээлтүүр бүрэн бүтэн байх. - Суултуурын хоорондын хаалт хана нь тааз хүртэл гүйцэд эсвэл хүүхэд давах боломжгүй өндөр байх.



Хэрэгжүүлэх арга зам

Сургуулийн үйлчилгээний ажилчид цахилгааны утас, бусад тоноглолын бүрэн бүтэн байдлыг тогтмол хангах. Засвар хийхдээ цонхонд хаалт хийх эсвэл дээрээ салхивчтай цонх сонгох. Ихэнх сургуулийн агааржуулалт олон жилийн явцад бөглөрсөн байдаг тул агааржуулалтын хоолойг 2-3 жилийн давтамжтайгаар цэвэрлэж, шалгаж байх.


Хальтирдаггүй резинэн шал нь илүү аюулгүй байдаг.

Сайн туршлага: “ЭйСиЭф-Монгол” ОУБ

Агааржуулах хоолойд нэмэлт сэнс суурилуулж гэрэлтэй нь холбосон. Ингэснээр гэрэл ассан тохиолдолд агааржуулах сэнс ажиллана. Агааржуулах хоолойн сорох чадварыг сэнс суурилуулж сайжруулсанаар үнэргүй болсон.



Зураг 5. Эвдэрсэн, галын аюултай тоноглолууд




Зураг 6. Агааржуулах сэнсийг гэрэлтэй нь давхар холбосон байдал.

ТАЙЛБАР: Эх сурвалж: Сонгинохайрхан дүүргийн Ирээдүй цогцолбор

Ариун цэврийн өрөөг зөв төлөвлөх, засварлах, ашиглах зөвлөмж, сайн туршлага

Сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн өрөө нь хүртээмжтэй, байнгын ажиллагаатай, ашиглагдахуйц, аюулгүй, **хувийн орон зайг хангасан**, цэвэрхэн, хүүхдийн нас хүйсийн онцлогт тохирсон байх.

Шаардлага: Жорлон нь хэрэглэгчдэд аюулгүй байна	
Тайлбар: Сургуулийн бие засах газарт тавигдах маш чухал үндсэн шаардлага бол бие засах өрөө нь хүний хувийн нууцыг хадгалахуйц, ямар нэгэн гадны аюул, хүчирхийлэлд өртөхөөргүй байх ёстой. Манайд байдаг бас нэг дутагдал бол охидын хувийн орон зайд санаатай болон санамсаргүй халдах үүнийгээ тоглоом наадам болгох зэрэг зохисгүй үйлдэл юм.	
<p>Зөвлөмж</p> 	<ul style="list-style-type: none"> - Бие засах өрөө хичээлийн анги танхимтай аль болох ойр, олоход хялбар байх ба харанхуй булан тохойд байрлахгүй байвал сайн. - Шөнө оройн цагт гэрэлтүүлэгтэй байна. - Бие засах өрөөний цонх бүдэгрүүлэх наалттай байна. - Хөвгүүд охидын бие засах өрөө нь тус тусдаа байна. Хэрэв нэг өрөөг засаж байгаа бол заавал ханаар тусгаарлаж тус тусдаа хаалга хийж өгнө. - Хана нь тааз хүртэл гүйцэд, нэвт харагддаггүй байх ба хаалга нь шал хүртэл гүйцэд хаалга байна. - Хаалгыг гадна талаас харагдахгүй дотор талаас харагдах сараалжтай хаалга сонговол сайн. - Хаалга нь дотор талдаа заавал цоожтой байна




Хэрэгжүүлэх арга зам

Сургууль зориулалтын бус барилгад байрладаг эсвэл шинээр зураг төсөл гаргуулах гэж байгаа бол үүнийг заавал бодолцох ёстой. Бие засах өрөө болон коридор гэрэлтэй байна. Зарим газар цонхтой талдаа суултуур, шээлтүүр байрлуулсан байдаг. Энэ тохиолдолд заавал бүдгэрүүлэх наалт наана. Сурагчдад хүний эрх, хувийн соёл зэрэг сэдвийн хүрээнд сургалт, өдөрлөг, танилцуулга зохион байгуулах

Сайн туршлага: НҮБ-ын Хүүхдийг ивээх сан Хөвсгөл аймаг

Ханаар тусгаарласан тасалгаа, цоожтой хаалга хийсэн нь хувийн орон зайг бүрдүүлж тав тухтай бие засах боломжтой болгосон.



Зураг 7. Хувийн нууцлалыг хангаж чадахгүй суултуур хоорондын хаалт

ТАЙЛБАР: Эх сурвалж: Хөвсгөл аймаг Бүрэнтогтох сум.



Зураг 8. Суултуур хооронд хийсэн өндөр ханатай, тусдаа хаалгатай, дотор талдаа түгжээтэй хаалтууд

Ариун цэврийн өрөөг зөв төлөвлөх, засварлах, ашиглах зөвлөмж, сайн туршлага

Сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн өрөө нь хүртээмжтэй, байнгын ажиллагаатай, ашиглагдахуйц, аюулгүй, хувийн орон зайг хангасан, **цэвэрхэн**, хүүхдийн нас хүйсийн онцлогт тохирсон байх.

Шаардлага: Бие засах өрөө нь эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэрхэн байна

Тайлбар: Сургуулийн бие засах өрөөний талаар хийсэн судалгаанд хамгийн их дурьдагдсан сөрөг зүйл бол ОО бохир, муухай үнэртэй байдаг гэсэн байна. Нийтийн бие засах газрын гол шаардлага нь цэвэрхэн байх явдал. Энэ нь хэдийгээр байнгын үйлчилгээнээс хамаарах боловч дараах зүйлсийг анхаарах нь үйлчилгээний ажилчдын ажлыг хөнгөлж өгнө.

Зөвлөмж



- Нийтийн бие засах газарт явган суултуур хийх нь суултуур дээр гарч бие засах үүнээс болж бохирдох, амархан эвдрэх зэрэг асуудал үүсгэхгүй сайн талтай.
- Бие засах өрөөний дотор талыг амархан цэвэрлэж болох шаазан хавтангаар доторлоно.
- Бие засах өрөөнд ил явсан шугам хоолойн эргэн тойрныг цэвэрлэхэд хэцүү тул аль болох шугам хоолойг далдлах хэрэгтэй.
- Суултуур бүрийн дэргэд тагтай хогийн сав байрлуулна.
- Суултуурын дэргэд суултуур цэвэрлэх сойз заавал байрлуулах.
- Анги угаасан хогтой усыг суултуурт хийж бөглөх нь их байдаг тул цэвэрлэгээний ус авах, асгах тусгай намхан угаалтуур хийж өгөх.
- Бие засах өрөөний цэвэрлэгээ хийдэг үйлчлэгчдийг томилох, урамшуулах



Хэрэгжүүлэх арга зам

Засвар хийлгэх үедээ ил явсан шугам хоолойг далдалж өгөх нь цэвэрлэгээ хийхэд илүү амар болдог. Мөн эвдэрч гэмтэхгүй сайн талтай.

Сурагчдад бие засах өрөөг хэрхэн зөв хэрэглэх талаар сургалт явуулах, сурагчдыг энэ талын соёлтой болгоход анхаарах. Ингэхдээ хичээлийн жилийн эхэнд болон явцын дунд сануулах сургалтуудыг хийх.

Бие засах өрөөг зөв хэрэглэж хэвших талаар сурталчилгааны зурагт хуудас, плакат хадах. Эд зүйлс эвдсэн, биеэ буруу авч явсан хүүхдүүдэд сануулах, анхааруулах аяныг сурагчдын дунд өрнүүлэх зэргээр нийтийг татан оролцуулсан арга хэмжээ зохиох.

Үйлчилгээний ажилтнуудын ажлыг үнэлэх, нэр хүндийг сурагчдын дунд өргөх

Сайн туршлага: “Эй Си Эф-Монгол” ОУБ

Цэвэрлэгээний ус авах асгах тусгай тосгуур суурилуулсан нь суултуурлуу хог болон шалны алчууртай ус хийж бөглөрдөг асуудлыг шийдсэн.

Суултуур, шээлтүүрийн ус татагчийг хөлөөр гишгэж, усаа татдаг байдлаар шийдсэн нь гараар халдвар дамжих эрсдэлийг бууруулсан.



Зураг 9. Бохир суултуур, суултуур бөглөрөхөөс хамгаалж тавьсан төмөр тор



Зураг 11. Хөлөөр ус татдаг шээлтүүр



Зураг 10. Цэвэрлэгээний ус авдаг намхан тосгуур



Зөвлөмж: Цэвэрлэгээний ус авдаг угаалтуур нь намхан, уян хоолойтой, хувин багтах том зайтай, хог хамах шүүлтүүртэй мөн никель тул ус авах үед асгарахгүй, бөглөрөхгүй, хагарч эвдрэх нь бага зэрэг сайн талтай

Ариун цэврийн өрөөг зөв төлөвлөх, засварлах, ашиглах зөвлөмж, сайн туршлага

Сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн өрөө нь хүртээмжтэй, байнгын ажиллагаатай, ашиглагдахуйц, аюулгүй, хувийн орон зайг хангасан, цэвэрхэн, **хүүхдийн нас хүйсийн онцлогт тохирсон** байх.

Шаардлага: Жорлон нь хүүхдийн нас, хүйсийн онцлогт тохирсон, хүүхдэд ээлтэй байх

Тайлбар: Жорлонг хамгийн олдоц сайтай хямд зүйлсээр тоноглох нь нийтлэг байдаг. Гэтэл сургуулийн хувьд бие засах өрөөний тоноглолууд хүүхдийн өндөрт тохирсон, хэрэглэхэд хялбар, бага насны хүүхдийг суултуур, угаалтуурыг зөв хэрэглэхэд дэм болохуйц байх хэрэгтэй. Орчныг нь бүрдүүлж өгөөгүй нөхцөлд хүүхдэд эрүүл ахуйн зөв дадал хэвшил бий болох бололцоогүй юм.

Зөвлөмж



- Сургуульд явган суултуур хэрэглэхийг санал болгож байгаа. Хэрэв суултуур ашиглах бол хүүхдэд зориулсан намхан суултуур сонгох, аль эсвэл өндөр суултуурыг шаланд суулгаж намхан болгон хэрэглэж болно.
- Суултуурын хажуу хананд хүүхэд суухад дэмнэх 2ш бариул хадаж өгнө.
- Суултуурын ус татагч нь хөлөөр дардаг педалтай байвал сайн.
- Суултуур бүрийн дэргэд тагтай хогийн сав байрлуулна.
- Бие засах өрөө нь суултуур, гар угаагуур, алчуур эсвэл гар хатаагч гэсэн зөв дараалал, урсгалтай байна.



Хэрэгжүүлэх арга зам

- Өндөр суултуурт хүүхэд суултуурнаас барьж суух болдог тул өндөр суултуурын эргэн тойрны шалыг өндөрлөж тавцан үүсгэх аргаар суултуурын өндрийг багасгана.
- Хөлөөр гишгэж бохирыг зайлуулдаг ус татагч нь эрүүл ахуйн хувьд хамгийн зөв шийдэл болдог.
- Хогийн савны таг хөлөөр дарж онгойдог бол сайн.

Сайн туршлага: “НҮБ-ын Хүүхдийн сан” Хөвсгөл аймаг



Зураг 12. Бага сургуулийн хүүхдийн өндөрт тохирсон намхан суултуур, шээлтүүр, гар угаагуур

ТАЙЛБАР: Эх сурвалж: Хөвсгөл аймаг, Бүрэнтогтох сум

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ариун цэврийн өрөөний зөвлөмж

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт тохирсон 1 ариун цэврийн өрөө байх.

Шаардлага: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт тохирсон нэг жорлонтой байх.

Тайлбар: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгэмшүүлэх зорилгын үүднээс тэднийг энгийн ерөнхий боловсролын сургуульд суралцуулж байгаа. Гэтэл тэдний зарим хэрэглээ ялангуяа бие засах өрөө хэрэгцээг нь хангаж чадахгүй байсаар байна. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт тохируулж засаж сайжруулж өгөх нь маш чухал бөгөөд тэдэнд хүний эрхээ эдлэх боломжийг нь олгож байгаа явдал юм.

Зөвлөмж



- Тэргэнцэртэй хүүхдүүдэд зориулсан 1 бие засах өрөөг давхар бүрд байрлуулах
- Тэргэнцэртэй иргэдэд зориулсан тасалгааг 1.65x1.8 м-ээс багагүй байхаар тооцно. Учир нь тэргэнцэрийг суултуурын хажуу хэсэгт байршуулах чөлөөт орон зай хэрэгцээтэй байдаг.
- Хаалганы өргөн нь 0.85м-ээс багагүй, босгогүй, стандартын шаардлага хангасан налуу замтай байх
- Тэргэнцэрээс суултуурт шилжин суухад туслах, сууж байхад гар, мөр, нурууг дэмнэх тулгуур хэрэгсэлтэй байх
- Тэргэнцэртэй ижил өндөртэй, зөөлөвч бүхий суултуур, хамгаалалтын бүстэй байх.
- Суултуураас босохдоо татах бариул, татлагатай байх
- Гар угаагуурыг боломжтой бол нэг өрөөнд үгүй бол аль болох ойр байрлуулах
- Гар угаагуурыг шалнаас 0.8м-ээс ихгүй өндөрт байрлуулж, дэмнэх тулгуур хэрэгсэл, хамгаалалтын бүстэй байх.
- Гар угаагуурын усны цорго мэдрэгчтэй байх




Хэрэгжүүлэх арга зам


- Хүүхдүүд бие засахын тулд шатаар өгсөж уруудах нь тэдний хувьд маш хүнд хөдөлмөр тул аль болох давхар бүрд нэг өрөөг тэдэнд зориулж тоноглож өгөх.
- Бие засах өрөө том байх нь тэргэнцэр байрлуулах, хэн нэгэн тэдэнд туслахад хялбар байх сайн талтай.
- Бариул, тулгуур хэрэгсэлийг суултуурын эргэн тойрон байрлуулна.
- Явган суултуур тавьж болохгүй
- Бочкины ус татдаг нээлхийг аль болох амархан дарж болох хэлбэртэйг нь сонгох.
- Суултуурыг цэвэрлэх нь тэдний хувьд хэцүү тул үйлчилгээний ажилтнуудад энэ талаар ойлгуулах, илүү анхаарал тавих
- Эрүүл ахуйн сургалтаар дамжуулан хүүхдүүдэд тэргэнцэртэй найзууддаа туслахыг уриалах (бие засах өрөө явах г.м).



Анхаар: Хэрэв шинээр барилга төлөвлөж эсвэл их засвар хийх гэж байгаа бол тэргэнцэртэй иргэдийн бие засах өрөөний хаалгыг гүйдэг хаалга эсвэл хоёр тийш онгойдог байхаар хийвэл тэдний хувьд маш их дөхөмтэй, ээлтэй байх болно.



Зураг 13. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан том талбайтай, гүйдэг хаалгатай ариун цэврийн өрөө



Зураг 14. Гар угаагуур, суултуур хоёр хамт нэг өрөөнд байрласан. Дэмнэх хэрэгслийг тус тусад нь суурилуулсан байдал

Багш, ажилчдын ариун цэврийн өрөөний зөвлөмж

Багш ажилчдад зориулсан жорлон тусдаа байх; дунд болон ахлах сургуульд зайлшгүй мөрдөх.

Багш ажилчдад зориулсан ариун цэврийн өрөө тусдаа байх хэрэгтэй.

Энэ өрөө нь дараах шаардлагыг хангасан байна.

Сурагчдын ариун цэврийн өрөөнөөс тусдаа байх.

Эрэгтэй эмэгтэй ариун цэврийн өрөө тус тусдаа байх.

Ариун цэврийн өрөөний хаалга, хана гүйцэд байх.

Хүмүүсийн бие засах дадал хэвшлээс хамааран суултууртай, гишгүүртэй 2 янз байж болно.

Хаалга нь дотор талдаа цоожтой, өндөр нам 2 өлгүүртэй байна.

Суултуурын дэргэд тагтай хогийн сав, суултуур угаах сойз зайлшгүй байна.

Гар угаалтууртай байна.

Гар угаагуурт тавигдах шаардлага, зөвлөмж

Гар угаагуур нь хүүхдүүдэд хүртээмжтэй, ажиллагаатай, усны хэмнэлттэй цэвэрхэн байх.

Шаардлага: 40 сурагчид нэг гар угаах угаагуур ногдохоор байх. Сургууль, дотуур байранд хүүхдүүд бүлээн усаар гараа угаах нөхцлөөр хангагдсан байх. Гар угаах угаагуур бүрийн дэргэд саван тогтмол байлгах, Гар угаах цэг/байгууламж нь бага насны сурагчид, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ойр, тохиромжтой, хүртээмжтэй байх. Угаагуурын хажууд гар/алчуур хатаагч болон таглаатай хогийн сав байрлуулах

Тайлбар: Гар угаах нь халдварт өвчнөөс сэргийлэх хамгийн үр дүнтэй мөртлөө хамгийн хямд арга юм. Хэдийгээр гар угаах тухай сургалт, сурталчилгаа явагддаг хэдий ч гар угаах боломж, нөхцлийг нь бүрдүүлж өгөхгүй бол энэ нь дадал болж хэвшдэггүй.



Хэрэгжүүлэх арга зам

- Угаагуурын хүртээмжийг сайжруулах зорилгоор цөөн хэдэн шаазан тосгуур биш урт үргэлжилсэн тосгуур байвал илүү олон хүүхэд ашиглах боломжтой болно.
- “ЭйСиЭф” ОУБ-аас хийсэн судалгааны дүнд 1 хүүхэд 1 жилд 1 саван хэрэглэдэг

гэсэн тооцоо гарсан тул хүүхдүүдийг жилд 1 удаа 1 саван авчирч эрүүл мэндээ хамгаалах тухай нийтийг хамарсан аянд уриалах ажлыг хийх

- Угаагуурт усны хэмнэлттэй цорго хэрэглэх.
- Хүүхдүүдэд усны үнэ цэнийг ойлгуулах сурталчилгааны материал хийх, ашиглах
- Угаагуурын дэргэд гар хатаагч суурилуулж өгөх



Анхаар: Ус хэмнэх боломжтой цорго бусад тоноглолын талаарх мэдээллийг 94-97-р хуудаснаас харна уу..

Сайн туршлага – “ЭйСиЭф-Монгол” ОУБ

Зай эзэлсэн цөөхөн хуучин угаагуурыг солиж, олон цорготой зай хэмнэсэн нержэн угаагуур суурилуулснаар нэг удаа олон сурагчид гараа угаах боломж бүрджээ.



Зураг 16. Зай талбайг бүрэн ашиглаагүй гар угаагуур



Зураг 17. Үргэлжилсэн урт угаагуур суурилуулж хуучин 3 байсан цоргыг 5 болгосноор хүртээмж нэмэгдсэн.

ТАЙЛБАР: Эх сурвалж: Сонгинохайрхан дүүрэг Ирээдүй цогцолбор

ХОЁР. БИЕ ДААСАН АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИД ТАВИГДАХ НОРМ ШААРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ, САЙН ТУРШЛАГУУД

Төвлөрсөн ариутгах татуургын системд холбогдоогүй сургууль цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийг шийдэх оролдлого төрийн болон олон улсын хандивлагч байгууллагуудын дэмжлэгтэйгээр хийгдэж байна.

Гэвч зарим тохиолдолд энэ нь тухайн орон нутгийн онцлог байдалд нийцэхгүй тохиолдол гардаг. Үүний улмаас хөрөнгө мөнгө үр ашиггүй зарцуулагдах, тухайн байгууллагад түүнээс үүдэлтэй өөр бэрхшээлүүд үүсэх гэх мэт сөрөг талууд гардаг. Иймд орон нутгийн түвшинд анхаарах дараах зөвлөмжийг хүргэж байна.

1. Сонгосон шийдэл нь тухайн орон нутгийн цаг уур, хөрсний нөхцөлд тохирсон байх.

Манай улс шиг өргөн уудам нутагтай цаг уур, хөрсний нөхцөл, гүний болон гадаргын усны байдал харьцангуй олон янз байдаг газарт усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хувилбарыг сонгохдоо тухайн орон нутгийн онцлог нөхцлийг зайлшгүй харгалзан үзэх ёстой.

Харин эдгээр нөхцлийг тооцолгүйгээр суурилуулсан хувилбарууд ажиллахгүй байх, өөр бусад асуудал, бэрхшээл дагуулах тохиолдол байсаар байна. Жишээ нь: Хөрсний ус өндөртэй газар шүүрүүлэх талбайтай септик тавьснаар цэвэрлэгдсэн ус шүүрэх боломжгүй болж халих, намагших зэрэг тохиолдол байна.

2. Сургууль, цэцэрлэгийн онцлогт нийцсэн, ашиглалт үйлчилгээ нь хэрэглэгч байгууллагад дарамт үүсгэхээргүй байх.

Технологийн шийдлийн хувьд анхаарах дараагийн зүйл нь сонгосон хувилбар нь тухайн сургууль, цэцэрлэгийн хүүхдийн тоо, өвөл зуны хэрэглээний зөрүүтэй байдалд тохирсон байх хэрэгтэй. Мөн аль болох хэрэглэгч байгууллагад эдийн засгийн болон бусад дарамт үзүүлэхээргүй ашиглалтын зардал хямд, ашиглалт үйлчилгээг орон нутгийн түвшинд хийх боломжтой байх. Гэтэл зарим тохиолдолд ашиглалтын цахилгааны зардал хэт өндөр байх, бохир сорох машин байхгүй байтал сорж зайлуулах технологитой хувилбар суурилуулсан зэрэг сөрөг зүйлс харагдаж байна.

Иймд эдгээр дутагдлаас зайлсхийхийн тулд:


Аймгийн түвшинд мэргэжлийн баг бүрдүүлэн хэрэгжүүлэх гэж буй төсөлдөө үнэлгээ, хяналт хийлгэх. Энэ багт сантехникийн инженер, барилгын инженер, байгаль орчны болон эрүүл ахуйн байцаагч, санхүүч нарыг оруулах нь зүйтэй. Энэ баг нь тухайн шийдэл орон нутгийн онцлогт тохирох эсэх, үр ашгийн тооцоо болон сайжруулалт өөрчлөлт хийх боломжуудыг судлан үздэг байх. Өөрсдөө гүйцэтгэгч байгууллагаа сонгож байгаа бол өөрсдийн нөхцөл, боломж, онцлог байдлаа сайтар тусган хэрэгцээ шаардлагаа тодорхойлох нь зүйтэй. Ингэсний дараа үүндээ тохирсон хувилбар санал болгохыг гүйцэтгэгчээс шаардах, тэдний ажилд мэргэжлийн багаар хяналт тавиулан ажиллах нь илүү дүнтэй юм.

Бие даасан ариун цэврийн байгууламжийн хувилбарууд

Хөдөө орон нутгийн ихэнх сургууль, цэцэрлэг одоо ч энгийн нүхэн жорлонг ашигласаар байна. Хэдийгээр зарим газруудад нүхэн жорлонг халах шинэ сайн технологи туршигдан, нэвтэрч байгаа ч түүнийг хүлээн хуучин, бохир жорлонгоо ашигласаар байгаа нь хүүхдүүдийн эрүүл мэнд, ариун цэвэр, хувийн соёлд сөрөг нөлөө үзүүлсээр байна. Иймд энэхүү норм шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжийн 3 энгийн загварыг буюу энгийнээс илүү сайжирсан 3 шатлалын бие засах газрыг танилцуулья. Эдгээр техникийн шийдэл нь одоо байгаа нөхцөл байдлыг сайжруулан норм шаардлагыг хангахад туслах хэдий боловч хамгийн сайн төгс шийдэл биш бөгөөд энэ салбарт судалгаа шинжилгээ хийгдэж, шинэ бүтээгдэхүүн, шийдлүүд гарч ирсээр байна.

1. Агааржуулагчтай энгийн нүхэн жорлон
2. Агааржуулагчтай, сайжруулсан нүхэн жорлон
3. Сайжруулсан ариун цэврийн байгууламж

1. Агааржуулагчтай энгийн нүхэн жорлонгийн танилцуулга




Зураг 18. Агааржуулагчтай энгийн нүхэн жорлонгийн схем

Энэ нь нүхэн жорлонгийн сайжруулсан хувилбар бөгөөд гол онцлог нь агааржуулалтын хоолой суулгаж өгснөөр тасралтгүй үргэлжлэх агаарын урсгалын нөлөөгөөр үнэр гадагшлах нөхцлийг бүрдүүлнэ. Агааржуулалтын хоолойг хар өнгөөр будах нь хоолой дахь агаарыг халааж, халсан агаар дээш хөөрч үнэр гадагшлах явцыг дэмжих үүрэгтэй. Бүхээгийг аль болох гэрэл нэвтрэхгүй хийх бөгөөд ингэснээр зөвхөн агааржуулалтын хоолойгоор тусч буй гэрэлд ялаа шавьж татагдаж, хоолойн дээд талын торонд баригдана. Ингэснээр жорлонд үнэргүй, ялаагүй, тав тухтай байх нөхцөл хангагдана.

Бүхээг


Бүхээгийг банзаар хийсэн тохиолдолд хатаж, зай завсар гарч битүүмжлэл алдагдан агаар сэлгэлтийн горим зөрчигддөг. Иймээс бүхээгийг зай завсаргүй хийх нь агаар сэлгэлт зөв явагдаж үнэргүй байх нөхцлийг бүрдүүлдэг. Үүний тулд модон, цементэн хавтан ашиглаж болно.

Бүхээгийг модон материалаар хийвэл гадна талыг будах, уснаас хамгаалах түрхлэг түрхэх, шавраар хийсэн бол шохойдох зэргээр өнгө үзэмжийг сайжруулж, эдэлгээг уртасгана.



Зураг 19. Сургуулийн агааржуулагчтай энгийн нүхэн жорлон

Агааржуулалт



Дотор болон гадна агаарын даралтын зөрүүгээр агаар сэлгэлт явагдана. Агаарын урсгалыг чөлөөтэй нэвтрүүлэх үүднээс түүнийг хаах ямар нэг зүйл байвал агааржуулалтын хоолойг өндөрсгөх шаардлагатай.

Зураг 20. Агааржуулагчтай энгийн нүхэн жорлонгийн агааржуулалтын урсгал

ТАЙЛБАР: Эх сурвалж: ДЭМБ 1992, Орон нутагт ариун цэврийн байгууламж барих зөвлөмж



Агааржуулалт хангалтгүй явагдаж байгаа нөхцөлд түүнийг идэвхжүүлэх зорилгоор салхиар ажилладаг агаар сорох салхин сэнсийг ашиглаж болно. (Зураг 21).

Зураг 21. Салхин сэнс бүхий агааржуулалт

ТАЙЛБАР: Эх сурвалж: “ЭйСиЭф-Монгол” ОУБ, Сонгинохайрхан дүүргийн 4 хорооны иргэн А-ын ариун цэврийн байгууламж

Нүх

Нүхийг доторлоогүй тохиолдолд нуранги байнга үүсч, хурдан хугацаанд дүүрдэг. Доторлогооны материалын хувьд мод, металл, блок, тоосго зэрэг материал ашиглаж болно. Хэлбэрийн хувьд дугуй байх нь илүү тохиромжтой.

Агааржуулагчтай нүхэн жорлонгийн байршил

Орон нутгийн ноёлох салхины доор байрлана.

Агаарын урсгалыг хаах ямар нэгэн зүйлээс хол байрлана.

Бороо болон цасны ус орохоос сэргийлж бага зэрэг өндөрлөг газар байрлуулна.

Бүхээгний хаалга ноёлох салхи руу харсан чиглэлтэй байна. Энэ нь агааржуулалтад чухал ач холбогдолтой.

Хэрэглээ, үйлчилгээ


Жорлонгийн хэвийн үйл ажиллагааг хангахад доорх эрүүл ахуйн дэглэмийг мөрдөх хэрэгтэй. Үүнд:

Жорлонгийн бүхээгийн эргэн тойронд хаяавч хийх бөгөөд энэ нь нүх рүү цас, бороо, үерийн ус орох, өт авгалдай нүхнээс гарахаас сэргийлнэ. Хаяавч цоорч бүрэн бүтэн байдал алдагдвал битүүлнэ. Ялааны торыг үргэлж шалгах хэрэгтэй бөгөөд дулааны улиралд сард нэгээс доошгүй удаа усаар шүршиж цэвэрлэн, бүрэн бүтэн байдлыг хянаж байх ёстой. Жорлонгийн шал буюу тавцанг тогтмол усаар угааж цэвэрлэнэ. Мөн бүхээгийн гадна, дотор талыг тогтмол угааж, цэвэрлэж байна. Шал нь хатуу цемент, муудахаас хамгаалсан модоор хийгдсэн, будсан буюу зориулалтын хавтангаар өнгөлсөн, гадаргуу нь тэгшхэн байна. Бие засах нүхийг стандартад заасан хэмжээний дагуу төлөвлөнө. (зориулалтын хавтан гэж өвөл хальтирахгүй, хөлдөхгүй резинин хавтан энэ талаарх мэдээллийг www.mongolrubber.mn хаягаар буюу 317495, 98115097 утсаар холбогдож авч болно) Шалыг битүү хийж дунд нь бие засах нүх гаргаж өгнө.

2. Агааржуулагчтай сайжруулсан нүхэн жорлонгийн танилцуулга

Нүхийг соруулах боломжтой байдлаар битүү доторлож хийсэн, агааржуулалтай, бүхээг дотроо олон тасалгаатай, дулаахан тохилог жорлон юм.

Байшин дотор байрлах тул өвөл зуны аль ч цагт ашиглахад тохьтой, цэвэрхэн. Өвлийн улиралд байшинг цахилгаан халаагчаар халааж, тав тухтай бие засах боломжтой. Агааржуулагч суурилуулж өгсөнөөр үнэргүй, ялаагүй байх нөхцөл бүрдсэн. Соруулах боломжтой тул дахин дахин нүх ухах шаардлагагүй, удаан хугацаанд ашиглах боломжтой.



Зураг 22. Агааржуулагчтай сайжруулсан нүхэн жорлонгийн схем

Суллах зайлуулах

Нүх амсраас доош 0.5м хэмжээнд хүртэл дүүрсэн үед ялгадсыг соруулж төвлөрсөн цэвэрлэх байгууламжинд хаях эсвэл нүхийг дараад шинэ нүх ухна.



Зураг 23. Сургуулийн агааржуулагчтай сайжруулсан нүхэн жорлон

ТАЙЛБАР: Эх сурвалж: “ЭйСиЭф-Монгол” ОУБ, Сонгинохайрхан дүүрэг Партизаны 74-р сургууль

Хийц бүтээц /Бүхээг

Бүхээгийг орон нутагт олдоцтой хямд төсөр материалаар барьж болно. Хамгийн гол нь зураг төслийн дагуу, шаардлага хангасан барилгын материалаар барих ба өвлийн улиралд халаалт тавьж ашиглах тохиолдолд дулаан хадгалах хийцтэй байх нь зүйтэй. Бүхээгийг 23-р зурагт үзүүлсний дагуу охид хөвгүүдийн гэсэн 2 хэсэгт хувааж дундын ханыг гүйцэд хана байхаар төлөвлөж барина. Хэсэг тус бүр гаднаа тусдаа хаалгатай байна. Суултуурын тоог 3-р хуудсанд дурьдсан тооцооллын дагуу сургуулийн хүүхдийн тоонд харьцуулж тогтооно. Бүхээг дотор суултуур хооронд хаалттай, хаалт нь хүүхэд давахгүй өндөр, тус тусдаа хаалгатай байна. Бүхээгний дотор хана, шал нь угааж цэвэрлэх боломжтой материалаар хийсэн эсвэл бүрсэн байна.



Зураг 24. Агааржуулагчтай сайжруулсан нүхэн жорлонгийн дотор тал /өндөр ханатай, хаалгатай тасалгаанууд/

ТАЙЛБАР: Эх сурвалж: “ЭйСиЭф-Монгол” ОУБ, Сонгинохайрхан дүүрэг Партизаны 74-р сургууль



Зураг 25. Цэцэрлэгт зориулсан агааржуулагчтай сайжруулсан нүхэн жорлонгийн дотор тал/цэцэрлэгийн хүүхдүүдэд зориулсан хаалгагүй хаалтнууд/

ТАЙЛБАР: Эх сурвалж: “НҮБ-ын хүүхдийн сан” Хөвсгөл аймаг Түнэл сум

Нүх

Агааржуулагчтай сайжруулсан нүхэн жорлонгийн нүхийг ухаж, доторлоход дараах зүйлсийг анхаарна. Нүхний хэмжээ том тул доторлоход төвөгтэй байх, нурах, дамнуурга хийх боломжгүй байх зэрэг бэрхшээл гарах эрсдэлтэй тул 2 эгнээ зэрэгцээ 4-6 нүх ухаж түүнийгээ тус тусад нь доторлоно. Доторлогоог соруулах боломжтой болгохын тулд орон нутагт олдоцтой бетон цагираг, тоосго, блок зэргээр эсвэл цутгаж доторлоно.

Доторлогоотой нүхнүүдийг нийтэд нь буюу ачаалал даах материалаар шаллана. Шаланд зөвлөмжинд заагдсан хэмжээгээр нүх гаргах буюу шууд уналттай, энгийн суултуур тавьж болно.



Зураг 26. Шууд уналттай энгийн хуванцар суултуур

ТАЙЛБАР: Эх сурвалж: “НҮБ-ын хүүхдийн сан” Хөвсгөл аймаг Түнэл сум

Агааржуулалт

Дотор болон гадна агаарын даралтын зөрүүгээр агаар сэлгэлт явагдана. Агаарын урсгалыг чөлөөтэй нэвтрүүлэх үүднээс түүнийг хаах ямар нэг зүйл байвал агааржуулалтын хоолойг өндөрсгөх шаардлагатай.

Агааржуулалтын хоолойг хараар будах нь агаар сэлгэлтийг дэмжих сайн талтай.

Агааржуулалт хангалтгүй явагдаж байгаа нөхцөлд түүнийг идэвхжүүлэх зорилгоор салхиар ажилладаг агаар сорох салхин сэнсийг ашиглаж болно.

Байршил

Орон нутгийн ноёлох салхины доор байрлана. Агаарын урсгалыг хаах ямар нэгэн зүйлээс хол байрлана. Бороо болон цасны ус орохоос сэргийлж бага зэрэг өндөрлөг газар байрлуулна. Бүхээгний хаалга ноёлох салхи руу харсан чиглэлтэй байна.

Энэ нь агааржуулалтад чухал ач холбогдолтой.



Зураг 27. Агааржуулагчтай сайжруулсан нүхэн жорлон
ТАЙЛБАР: Эх сурвалж: “: “НҮБ-ын хүүхдийн сан” Хөвсгөл аймаг Түнэл сум

Хэрэглээ, үйлчилгээ

Жорлонгийн хэвийн үйл ажиллагааг хангахад доорх эрүүл ахуйн дэглэмийг мөрдөх хэрэгтэй. Үүнд:

- Бүхээгийн эргэн тойронд хаяавч хийх бөгөөд энэ нь нүх рүү цас, бороо, үерийн ус орох, өт авгалдай нүхнээс гарахаас сэргийлнэ. Хаяавч цоорч бүрэн бүтэн байдал алдагдвал битүүлнэ.
- Нүхэнд соруулах таг гаргаж өгнө. Соруулах таг цоожтой, хүүхэд онгойлгох боломжгүй байна.
- Агааржуулалтын яндангийн ялааны торыг үргэлж шалгах хэрэгтэй бөгөөд дулааны улиралд сард нэгээс доошгүй удаа усаар шүршиж цэвэрлэн, бүрэн бүтэн байдлыг хянаж байх ёстой.
- Жорлонгийн шал буюу тавцанг тогтмол усаар угааж цэвэрлэнэ. Мөн бүхээгийн гадна, дотор талыг угааж, цэвэрлэж байна.
- Бие засах нүхийг стандартад заасан хэмжээний дагуу гаргаж шаланд резинэн хавтан нааж болно.


Суллах зайлуулах

Нүх амсраас доош 0.5м хэмжээнд хүртэл дүүрсэн үед ялгадсыг соруулж төвлөрсөн цэвэрлэх байгууламжинд хаяна.

Агааржуулагчтай энгийн болон сайжруулсан нүхэн жорлонд тавигдах норм шаардлага

Агааржуулагчтай энгийн болон сайжруулсан нүхэн жорлонгийн хийц бүтээц, онцлог, анхаарах зүйлсийг дээрх бүлэгт дэлгэрэнгүй дурьдсан. Харин энэ хэсэгт сургууль, цэцэрлэг, дотуур байрны хувьд ийм төрлийн жорлонг төлөвлөж, барихдаа норм шаардлагыг хангахын тулд юуг анхаарах ёстой талаар зөвлөгөө өгье.

Барилгын хувьд


Шаардлага: Хүртээмжтэй, ашиглагдахуйц, аюулгүй, агааржуулагчтай, гэрэлтүүлэгтэй, хүүхдийн нас хүйсийн онцлогт тохирсон байна	
<p>Зөвлөмж</p> 	<p>Хүртээмжтэй:</p> <ul style="list-style-type: none"> - 30 эмэгтэй хүүхдэд 1 бүхээг, 50 эрэгтэй хүүхдэд 1 бүхээг, 1шээлтүүр оногдох - Ашиглагдахуйц: - Гадна жорлонг сургуулиас 30м-ийн дотор байрлуулах - Жорлон хүрэх замыг засах, гэрэлтүүлэг хийх зэргээр ямар ч улиралд, өдөр шөнийн аль ч цагт ашиглах боломжтой болгох - Бүхээгний эргэн тойронд бороо цасны усанд элэгдэж нуралт үүсэхээс хамгаалсан налуу хаяавч хийнэ.



Хэрэгжүүлэх арга зам

- Бүхээгний тоог зөвлөмжийн дагуу нэмэгдүүлэх , ингэхдээ охид хөвгүүдийн жорлонг заавал тусдаа хаалгаар ордог байхаар хийх
- Гадаах жорлонг зааврын дагуу агааржуулагчтай, цэвэрхэн барьж чадвал заавал сургуулиас хол байлгах бохир эд биш юм. Жорлон нь хүний хэрэглээ учир аль болох хэрэглэгчтэйгээ ойр байрлах ёстой. Нүхийг доторлох, хаяавч хийх зэрэг нь нүхний хана нурах, бүхээгний эргэн тойронд нүх гарах зэрэг аюултай байдал үүсгэхгүй.

Хэрэглэгчийн хувьд

Шаардлага: Хувийн орон зайг хангасан, хүүхдийн нас хүйсийн онцлогт тохирсон, цэвэрхэн байна	
<p>Зөвлөмж</p> 	<p>Хувийн орон зайг хангасан:</p> <ul style="list-style-type: none"> • Охид хөвгүүдийн жорлонг тус тусдаа эсвэл хоёр эсрэг талаасаа ордог байдлаар хийнэ. • Суултуур хооронд таславч хийнэ. Таславч хүүхэд давахааргүй өндөртэй, тусдаа хаалгатай байна • Бүхээгний хаалга дотор, гадна талаасаа цоожтой байна. • Гадна жорлонг багш, жижүүр нарын хараанд өртөхүйц газар байрлуулах хэрэгтэй. <p>Хүүхдийн нас хүйсийн онцлогт тохирсон:</p> <ul style="list-style-type: none"> • Хүүхдийн агааржуулагчтай нүхэн жорлонгийн бүхээгний ар талын өндөр 1,6м, урд талын өндөр 1,4м, хажуу талын өргөн 1м x 1м байна. • Хажуу хананд бариултай байна • Хүүхдийн жорлонгийн нүхний амсрын урт 0,28м, өргөн нь 0,18м. Нүхний голч 0,25м-ээс ихгүй зуйван хэлбэртэй байна.

Цэвэрхэн:

- Бие засах нүхний хоёр талд хөлний хэлбэртэй гишгүүр байна. Гишгүүр нь шалнаас 0,05м өндөр, 0,30м х 0,15м хэмжээтэй байна
- Бүхээгний ханыг доод тал нь 1м өндөрт угааж цэвэрлэх боломжтой зүйлсээр доторлосон байна
- Нүхэн жорлонгийн дотор хана, шалыг тодорхой давтамжтайгаар ариутгалын бодистой усаар угааж, халдваргүйжүүлэх.




Хэрэгжүүлэх арга зам

- Гадаах нүхэн жорлонд хувийн орон зайг хангах өөрчлөлт сайжруулалтыг заавал хийх ёстой.
- Жорлонг ойрхон харагдахуйц газарт байрлуулах, хаалга дотор талдаа цоожтой байх зэрэг нь хүүхдийг аюултай нөхцөл байдалд орохоос хамгаалж, сэргийлэх ач холбогдолтой.
- Хүүхэд жорлонд унах, эд зүйлсээ унагаах зэргээс хамгаалах (мөн агааржуулалтыг зөв явуулах) үүднээс жорлонг битүү шаллаж, дунд нь бие засах жижиг нүх гаргаж өгнө.
- Бага сургуульд жорлонгийн өндрийг зөвлөмжинд дурьдсаны дагуу төлөвлөж барих нь зүйтэй.
- Бие засах нүхний хажууд хөлийн мөртэй жижиг тавцан буюу гишгүүр байх нь бохирдсон шалан дээр гишгэж бохирдол дамжуулахаас сэргийлнэ. Суулгалт өвчнөөс сэргийлэх аргуудын нэг нь энэ энгийн хямд арга юм.
- Зардлыг бууруулах эсвэл хуучин жорлонгоо сайжруулах үедээ энэ зөвлөмжийн дагуу шалнаас дээш 1м өндөрт угааж цэвэрлэх боломжтой материал буюу плита, лампир зэргээр доторлох эсвэл будаж болно.
- 7 хоног бүр нүхэн жорлонгийн дотор хана, шалыг угааж, халдваргүйжүүлж хэвших нь халдварт өвчин тархах замыг зогсоох ач холбогдолтой.

Агааржуулагчтай энгийн болон сайжруулсан нүхэн жорлонтой газарт гар угаагуурыг шийдэх зөвлөмж

Шаардлага: Гар угаагуур нь хүүхдүүдэд хүртээмжтэй, ажиллагаатай, усанд хэмнэлттэй цэвэрхэн байх.

Тайлбар: Гар угаах нь халдварт өвчнөөс сэргийлэх хамгийн үр дүнтэй арга юм. Гар угаах дараалал болон ач холбогдлын талаарх танилцуулга, ухуулах материал элбэг байдаг мөн цэцэрлэгт ч энэ талаар зааж сургадаг. Гэвч нөгөө талаас гар угаах угаагуур хүртээмжтэй, ашиглагдахуйц биш бол энэ нь хүүхдийн зөв дадал хэвшил эзэмшихэд сөргөөр нөлөөлдөг.

<p>Зөвлөмж</p> 	<p>Гар угаагуур жорлонтой аль болох ойр байрлах</p> <p>Сургуулиуд: 40 сурагчид нэг гар угаах угаагуур ногдохоор байх</p> <p>Цэцэрлэг, сургууль, дотуур байранд хүүхдүүд бүлээн усаар гараа угаах нөхцлөөр хангагдсан байх</p> <p>Гар угаах угаагуур бүрийн дэргэд саван тогтмол байлгах,</p> <p>Гар угаах цэг/байгууламж нь бага насны сурагчид, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ойр, тохиромжтой, хүртээмжтэй байх.</p> <p>Угаагуурын хажууд гар/алчуур хатаагч болон таглаатай хогийн сав байрлуулах</p>
---	---



Хэрэгжүүлэх арга зам

Гадна жорлонтой сургуульд гар угаагуурыг сургууль дотор тусгай угаалгын өрөөнд эсвэл анги тус бүрд тавих.

Гар угаагуурын дэргэд ус нөөцлөх сав байна. Ус нөөцлөх саванд вакум насос суурилуулж цорготой холбож өгнө. Вакум насосны зах зээлийн дундаж үнэ 60,000төгрөг

Вакум насостой, цорготой нөхцөлд агшин зуурын ус халаах төхөөрөмжүүдийг суурилуулж болох бөгөөд энэ тохиолдолд хүүхэд бүлээн усаар гар угаах боломжтой болно. Цахилгаан бага зарцуулдаг ус халаагчийн талаар 5-р бүлгээс харна уу. Угаагуураас гарах бохир усыг MNS 5924 : 2008 стандартын дагуу барьсан бохир усны цооногт асгана. “ЭйСиЭф” ОУБ-аас хийсэн судалгааны дүнд 1 хүүхэд 1 жилд 1саван хэрэглэдэг гэсэн тооцоо гарсан тул хүүхдүүдийг 1 удаа 1 саван авчирч эрүүл мэндээ хамгаалах тухай нийтийг хамарсан аянд уриалах ажлыг хийж болно. Бага сургуулийн угаагуурыг намхан хийж, цоргоны эргүүлдэг биш сөхдөг загвартайг нь авах. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулж нэг угаагуурын дэргэд тулж зогсох бариул тулгуур хийж өгөх

3. Сайжруулсан ариун цэврийн байгууламжийн танилцуулга

Сайжруулсан ариун цэврийн байгууламж нь сургууль, цэцэрлэг, дотуур байрны одоо ашиглаж байгаа байгууламжинд залгаж барих боломжтой, дулаан, тохилог контейнор байшин юм. Инженерийн шийдлийн хувьд шүүрүүлэх талбайтай септик бүхий усаар зайлуулдаг жорлон. Өөрөөр хэлбэл төвлөрсөн шугаманд холбогдсон сургуулиудын адил дулаан тохилог орчинд ус татдаг цэвэрхэн суултуур ашиглах боломжтой болсон. Харин суултуур болон гар угаах усыг шийдэхийн тулд тухайн сургууль, цэцэрлэг гүний худагтай байх хэрэгтэй.



Зураг 28. Сургуулийн барилгад залгаж барьсан сайжруулсан ариун цэврийн байгууламж
ТАЙЛБАР: Эх сурвалж: “: “НҮБ-ын хүүхдийн сан” Хөвсгөл аймаг Түнэл сум

Хийц бүтээц

Сайжруулсан ариун цэврийн байгууламжийг хэрэглэгчийн хэсэг, газар доорх хэсэг 2 хэсэгт хувааж танилцуулъя.

Хэрэглэгчийн хэсэг:



Энэ нь сургуулийн барилгад залгаж барьсан хүзүүвч хоолой, дулаалсан контейнор хаусаас бүрдэнэ. Үүн дотор суултуур, угаалтуур, усанд орох шүршүүр байрлуулсан. Суултуур, шээлтүүр, угаагуурыг хүүхдийн тоонд хүртээмжтэй байхаар тооцсон. Мөн бүхий л тоноглол хэрэгсэл хүүхдийн өндөрт тохирсон байхаар суурилуулагдсан байна. Контейнор хауст цахилгаан халаагуур суурилуулж өвлийн улиралд хүүхдүүдэд дулаан тохилог орчин бүрдүүлж өгнө. Дулаан алдагдлыг багасгаж эрчим хүчийг хэмнэх үүднээс хүзүүвч хоолой болон контейнорыг сайтар дулаалах хэрэгтэй.

Энэ ариун цэврийн байгууламжийн хэрэглэгчийн хэсэгт төвлөрсөн шугаманд холбогдсон сургууль цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжид тавигдах норм шаардлагатай адилхан байна

Зураг 29. Сургуулийн сайжруулсан ариун цэврийн байгууламжийн дотор тохижилт
ТАЙЛБАР: Эх сурвалж: “: “НҮБ-ын хүүхдийн сан” Хөвсгөл аймаг Бүрэнтогтох сум



Зураг 30. Цэцэрлэгийн сайжруулсан ариун цэврийн байгууламжийн дотор тохижилт

ТАЙЛБАР: Эх сурвалж: “: “НҮБ-ын хүүхдийн сан” Хөвсгөл аймаг Бүрэнтогтох сум

Септик системийн ажиллах зарчим, бүтэц:

Бохирын септик систем нь


Бохир дамжуулах хоолой, септик шугам

Тунгаагч сав буюу септик танк

Хувиарлах хайрцаг

Бохирын тунасан саарал усыг газарт тархаагч гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Энэ систем нь механик, биологийн, хөрсний гэсэн 3 үндсэн цэвэрлэгээг хийдэг.



Зураг 31. Септик системийн ажиллах зарчим

Механик цэвэрлэгээ:

Онолын хувьд 24-72 цагийн дотор септик танк руу урсан орсон бохирын хүнд хэсэг нь септик танкны ёроолд нь лаг давхарга болон тогтож, хөнгөн хөөс, тостой хэсэг нь хөөсөн давхарга болж дээгүүрээ хөвдөг бөгөөд дээрх 2 давхаргын дунд ялгаран тогтож, шүүгдсэн усан давхарга нь септик танкны гарах хоолойгоор дамжин шүүлтүүрийн хэсэг рүү урсана. Үүнийг механик цэвэрлэгээ гэдэг. Үүгээр зогсохгүй анаэробик бактерийн нөлөөгөөр хөөсөн болон лаг давхаргын 90 орчим хувь нь байнгын задралд орж шингэрч байдаг. Септик танкны эзэлхүүн болон хэрэглэгчийн тооны харьцаанаас шалтгаалан септик танкыг жилд доод тал нь 1 удаа цэвэрлэх шаардлагатай.

Биологийн цэвэрлэгээ:

Бохир ус нь септик танкан дахь агааргүй орчинд орсны дараа бохирын найрлага дахь хүчилтөрөгчийн процесс зогсож хүчилтөрөгчгүй орчинд амьдардаг микро организмуудын идэвхжил эхэлнэ. Эдгээр анаэробик бактери нь гаднаас орж ирж байгаа бохир усан дахь бусад бактериудыг идэж устгаснаар Биологийн цэвэрлэгээ явагддаг.

Хөрсний цэвэрлэгээ буюу шүүрүүлэлт:

Шүүрүүлэх хэсэг нь биологийн цэвэрлэгээнээс гарсан усыг газрын хөрсөнд шүүрүүлэх замаар бүрэн цэвэршүүлэх зарчимтай. Шүүрч буй ус нь газрын хөрсөнд шингэх явцад үлдсэн бохирдуулагч бодисууд нь хөрсний молекулуудын гадаргуу дээр наалдаж тогтдог ба тэдгээр хэсгүүдийн ихэнх нь микробын ялзрал болон шүүрүүлэх явцаар цэвэршдэг. Микробын ялзрах процесс явагдснаар эцсийн буюу “хөрсний цэвэрлэгээ” хийгддэг.

Агааржуулалт

Дотор болон гадна агаарын даралтын зөрүүгээр агаар сэлгэлт явагдана. Агаарын урсгалыг чөлөөтэй нэвтрүүлэх үүднээс түүнийг хаах ямар нэг зүйл байвал агааржуулалтын хоолойг өндөрсгөх шаардлагатай. Агааржуулалт хангалтгүй явагдаж байгаа нөхцөлд түүнийг идэвхжүүлэх зорилгоор салхиар ажилладаг агаар сорох салхин сэнсийг ашиглаж болно.



Зураг 32. Сайжруулсан ариун цэврийн байгууламжийн агааржуулалт
ТАЙЛБАР: Эх сурвалж: “: “НҮБ-ын хүүхдийн сан” Хөвсгөл аймаг Түнэл сум

Байршил

Сургууль, цэцэрлэг, дотуур байрны ашиглаж байгаа барилгатай залгаж байрлуулна. Ингэхдээ коридорын төгсгөл эсвэл ханыг цоолж залгах боломжтой өрөөтэй залгана. Контейнер хаус, барилга хоёрын хооронд хүзүүвч хоолой хийх бөгөөд хүзүүвчийг мөн адил дулаалж, дулааны алдагдалгүй байхаар хийнэ.



Зураг 33. Сайжруулсан ариун цэврийн байгууламжийг дотуур байрны барилгад залгаж барьсан хувилбар
ТАЙЛБАР: Эх сурвалж: “: “НҮБ-ын хүүхдийн сан” Хөвсгөл аймаг Бүрэнтогтох сум

Давуу талууд:

Энэ хувилбар нь гэр, төрөл бүрийн байшин гээд бараг бүх нөхцөл байдалд таарна
Зөөвөрлөх боломжтой тул дахин өөр газар суурилуулах боломжтой

Сургууль цэцэрлэг хуучин байшингаа ашиглахгүй болсон ч энэ ариун цэврийн
байгууламжийг өөр газар, өөр байшинд залган ашиглаж болох удаан хугацааны
хөрөнгө оруулалт болно.Өөрсдийн усны эх үүсвэр /гүний худаг/-тэй газруудад түүнээс
ариун цэврийн байгууламжиндаа ус татах хоолой, шугам хэрэгтэй болох бөгөөд хэрэв
өөрсдийн усны үүсвэргүй бол гүний худаг шинээр гаргуулах шаардлагатай.

Хэрэглээ, үйлчилгээ

Жорлонгийн хэвийн үйл ажиллагааг хангахад доорх эрүүл ахуйн дэглэмийг мөрдөх
хэрэгтэй. Үүнд:

- Ариун цэврийн өрөөний дотор талд цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийнэ.
- Цэвэр усны хэрэглээг багасгахын тулд дараах төрлийн тоноглол суурилуулна.
- Усны зарцуулалт багатай, суултуур, шээлтүүр (5-р бүлгээс харна уу)
- Усны зарцуулалт багатай угаагуур, шүршүүр (5-р бүлгээс харна уу)
- Хүүхдүүдэд ийм төрлийн байгууламжийн талаар мэдээлэл хүргэж, зөв соёлтой хэрэглээнд сургах ажлыг хийнэ.
- Цэвэр усны зохистой хэрэглээ, хэмнэлтийн ач холбогдол
- Суултуур, угаагуурт усанд уусахгүй, бөглөрөх аюултай болон химийн бодистой хаягдал хийхгүй байх.
- Септик танкны хяналтын худгийг шалгах, лагийг цэвэрлэх зэрэг явцын засварыг зохих байгууллагаас аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан хүмүүс хийх бөгөөд угаартах, унах, нурах зэрэг бодит аюул байгааг санах нь зүйтэй.

Суллах зайлуулах

Септик системийн онцлог, суурилуулсан байгууллагын зөвлөмжийн дагуу септик
танкан дахь лагийг соруулж төвлөрсөн цэвэрлэх байгууламжинд хаяна.

3.ЦЭЦЭРЛЭГИЙН АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА ЗӨВЛӨМЖ

Цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийг сайжруулахад бага насны хүүхдийн хөгжлийн онцлогийг харгалзан үзэх хэрэгтэй. Хүүхдүүд эхлээд бие бялдар оюуны хувьд хөгждөг. Иймээс ариун цэврийн өрөө түүний тоноглол хүүхдийн хөгжлийн үе шатанд тохирсон байх шаардлагатай. 2-3 настай хүүхэд насанд хүрэгсдийн тусламжгүйгээр суултуур ашиглаж чадахгүй тул ариун цэврийн өрөө, түүний тоноглолууд багш хүүхдэд ариун цэврийн өрөөг бие даан ашиглах талаар зааж сургахад дөхөмтэй байх хэрэгтэй. 4-5 настай хүүхэд бие дааж суултуур хэрэглэж чадах боловч ихэнх нь зөв хэрэглэдэггүй, хэрхэн усаа татах, гараа угаахыг сурах шаардлагатай байдаг. Тиймээс ариун цэврийн өрөө, ариун цэврийн тоноглолуудыг аль болох хүүхэд хэрэглэхэд дөхөмтэй байдлаар зохион байгуулах шаардлагатай.


Нас	2-3нас (бага)	3-4нас (дунд)	4-5нас (ахлах)
	Аажмаар өөрөө бие засдаг болно, гэхдээ заримдаа тусламж хэрэгтэй байх болно		
Онцлог	1.Бие засмаар байна гэдгээ илэрхийлдэг 2.Заримдаа өөрөө өмдөө доошлуулдаг 3.Өөрөө суудаг 4.Ариун цэврийн цаасанд гар нь хүрч байвал авч хэрэглэдэг 5.Усны цоргыг бие дааж нээдэг	1.Өөрөө бие засахыг хүсдэг, гэхдээ тусламж их хэрэгтэй 2.Заримдаа өөрөө хувцсаа өмсөж, өмдөө доошлуулдаг 3.Ариун цэврийн цаас авч хэрэглэж чаддаг	1.Хэрэгтэй үедээ өөрөө ариун цэврийн өрөөнд орж бие засдаг 2. Аливааг үйлдэхийн өмнө үр дүнг нь боддог 3.Бусдын тусламжгүй хувцсаа өмсөж, өмдөө зөв доошлуулж чаддаг 4.Үсээ өөрөө зөв самнаж чаддаг
Нийгэмшихүй сэтгэл зүйн хөгжил	1.Энгийн зааврыг ойлгож, биелүүлдэг 2.Өнгө тэмдэг ялгадаг 3.Бусад хүүхдийг таньж эхэлсэн	1.Өөртөө итгэлтэй болж эхэлсэн 2.Бүхнийг мэдэхийг хүсдэг 3.Өөрийнхөө хүссэнээр аливааг үйлддэг, бусдыг бодож сураагүй 4.Нийгмийн хэм хэмжээг ойлгож, заримдаа дагаж биелүүлдэг 5.Заримдаа бусадтай хуваалцдаг	1.Өөртөө итгэлтэй болж байгаа 2.Аажмаар бусдыг бодож сурна, гэхдээ өрсөлдөх сэтгэл хүстэй байна 3.Бүлгийн дотор хэрхэн харилцахад суралцаж, дүрмийг дагаж биелүүлнэ 4.Асуудлыг өөрөө шийдвэрлэхийг оролдоно
Ариун цэврийн өрөөний шаардлага	1.Шүршүүр хэрэгтэй. Хүүхдэд зориулж хоёр бариул хийх хэрэгтэй 2.Тусгаарлах шаардлагагүй. Багшид ажиллах зайтай байх нь илүү чухал	1.Заримдаа шүршүүр хэрэг болно. 2.Багш нь ажиглаж, харж байх боломжтой байхын тулд тусгаарлагч нь нам байх хэрэгтэй	1.Шүршүүр хэрэггүй 2.Хувийн нууцлалыг хангах үүднээс тусгаарлагч нь жирийн хэмжээтэй байна

Суултуур	1.Шалнаас дээш 20см өндөртэй байх шаардлагатай 2.Жижиг босоо хөшүүрэгтэй байх 3.Хоёр жижиг бариултай байх	1.Шалнаас дээш 27,5см өндөртэй байх 2.Дээш доош дардаг урт бариултай байх 3.Хоёр бариултай байх. Хийц нь энгийн байж болно.	1.Шалнаас дээш 27,5см өндөртэй байх 2.Дээш доош дардаг урт бариултай байх 3.Хоёр бариултай байх. Хийц нь энгийн байж болно.
Хөвгүүдийн шээлтүүр	1.Шалнаас дээш 23см өндөртэй байх 2.Бариултай байх хэрэгтэй	1.Шалнаас дээш 26см өндөртэй байх 2.Бариултай байх	1.Шалнаас дээш 31см өндөртэй байх 2.Заримдаа барих бариултай байх
Гар угаагуур	1. 50см өндөртэй байх 2. 40-50см өргөн, дугуй хэлбэртэй байх 3.Саван байрлуулах зай хэрэгтэй	1. 50см өндөртэй байх 2. 50см өргөн байх 3. Саван байрлуулах зай хэрэгтэй	1. 60см өндөр байх 2. 50см өргөн байх 3. Саван байрлуулах зай хэрэгтэй
Бусад	1. Багш нарт зориулсан угаагуур 2. 4 төрлийн шүүгээ хэрэгтэй • Аюултай ариутгалын бодис байрлуулах шүүгээ цоожтой буюу өндөр байрлалд байна. • Шүүр, шалны мод хийх өндөр шүүгээ • Хувин, түмпэн хийх өргөн хэмжээтэй шүүгээ • Хувийн алчуур, бүлгийн алчуур, шүдний сойз, ариун цэврийн цаас хадгалах цэвэрхэн шүүгээ 3. Цахилгаан гар хатаагч эсвэл алчуур, гар арчдаг цаас байх хэрэгтэй 4. Агааржуулалтын систем хэвийн ажиллагаатай байх эсвэл аюулгүй байдлыг хангасан салхивчтай байх хэрэгтэй		

Цэцэрлэгийн ариун цэврийн байгууламж

Цэцэрлэгийн бие засах өрөө нь хүртээмжтэй, хүүхдийн хөгжилд дэмтэй, багш (туслах багш) хэрэглэхэд дөхөмтэй, цэвэрхэн, аюул осолгүй байх.

Шаардлага: Цэцэрлэгийн бие засах өрөө нь хүртээмжтэй, хүүхдийн хөгжилд дэмтэй байх
Тайлбар: Сургууль, цэцэрлэгүүдийн хүүхдийн тоо ихэссэнтэй холбоотой нэг суултуурт ногдох хүүхдийн тоо стандарт нормоос давсан тохиолдол их байна. Үүнээс гадна зарим цэцэрлэгт хүүхдийн нас, хөгжлийн үе шатыг харгалзан үзээгүйгээс хүүхэд 4-5 жилийн турш нэг л ариун цэврийн өрөөг ашиглаж байгаа нь 2 настай хүүхэд том суултуур хэрэглэх, том хүүхэд өөртөө багадсан суултуур хэрэглэх гэх мэт сөрөг байдал үүсгэж байна.

<p>Зөвлөмж</p> 	<p>Суултуурын тоог 20-иос ихгүй хүүхдэд 1 суултуур оногдож байхаар тооцох</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхэд ариун цэврийн өрөөг ашиглахдаа өдөр тутмын зөв зан үйлд суралцах боломжтой байх - Ариун цэврийн өрөө, суултуур нь хүүхэд хэрэглэхэд хялбар байх - Тоноглол, хэрэгслүүд (суултуур, угаагуур) хүүхдэд тохирсон хэмжээтэй байх <p><i>Суултуурын өндөр</i></p> <p>2-3 нас 20см 4-5 нас 27см</p>
---	--

Шээлтүүрийн өндөр

2-3 нас дээрээ бариултай 15см

4-5 нас бариулгүй 20см

Угаагуурын өндөр

2-3 нас 50см-ээс дээшгүй

4-5 нас 60см-ээс дээшгүй

- Тоноглол, хэрэгслүүд хүүхэд бие дааж хэрэглэхэд тохиромжтой байх (ус, татуурга/гэрэл/ариун цэврийн цаас

- Тоноглол нь ариун цэврийн өрөөнд хүүхдийн явах замыг зөв тооцсон байх (суултуур – угаалтуурт гараа савандаж угаах – алчуур/гар хатаагч)



Хэрэгжүүлэх арга зам


Цэцэрлэгийн дотоод дэглэм, хүүхдүүдийн онцлогоос шалтгаалан хүүхдүүд нэг дор олноороо ариун цэврийг өрөөг ашиглах болдог тул суултуур, шээлтүүрийн тоог аль болох нэмэгдүүлэх нь зүйтэй.

Хүүхэд суултуур дээр сууж бие засах, ариун цэврийн цаасыг зөв хэрэглэх, хогийн саванд хийх, усаа татах, гараа савандаж угаах, арчих зэрэг зөв зан үйлд суралцах нөхцлийг хангах, багш туслах багш зааж зөвлөх шаардлагатай.

Суултуурын хажуу талын хананд хүүхэд барьж суух, татаж босох бариул хадах, ариун цэврийн цаасыг хүүхэд сууж байгаад авах боломжтой өндөрт, ойрхон тогтоож өгөөрэй.

Ус татах нээлхий дардаг хэлбэртэй байх, гэрлийн унтраалга хүүхдийн өндөрт тохирсон байх хэрэгтэй.

Суултуур, угаагуур, алчуурыг дарааллын дагуу байрлуулж хүүхдийг ариун цэврийн өрөөг ашиглахдаа энэ зөв дарааллыг баримталж сурахыг дэмжээрэй.



Зураг 34. Хүүхдийн өндөрт тохиороогүй угаалгуур



Зураг 35. Хүүхдийн өндөрт тохирсон намхан угаалгуур



Зураг 36. Хүүхдэд тохироогүй том хүний өндөр суултуур



Зураг 37. Хүүхдэд тохирсон намхан, хажуу талдаа бариултай суултуур



Зөвлөмж: Угаалтуурын өндөр хүүхдийн нуруунд тохирсон, цоргоны нээлхий эргүүлдэг биш сөхдөг байх нь хүүхэд өөрөө бие даан гараа угаах боломжийг бүрдүүлдэг. Мөн суултуур өндөр байвал хүүхэд суултуурнаас барьж суух болдог. Иймд намхан, хажуу ханандаа бариултай байвал хүүхэд өөрөө бие даан суултуур ашиглах боломжтой болно.

Цэцэрлэгийн ариун цэврийн байгууламж

Цэцэрлэгийн бие засах өрөө нь хүртээмжтэй, хүүхдийн хөгжилд дэмтэй, багш (туслах багш) хэрэглэхэд дөхөмтэй, цэвэрхэн, аюул осолгүй байх.

Шаардлага: Цэцэрлэгийн бие засах өрөө нь багш (туслах багш) хэрэглэхэд дөхөмтэй байх

Тайлбар: Ариун цэврийн цаасыг хөтөвчнөөс зайтай байрлуулснаар хүүхдүүд цаасандаа өөрсдөө хүрч чаддаггүй. Жорлон нь насанд хүрсэн хүний хэмжээтэй тул хүүхдэд томдоод дээр нь сууж чаддаггүй. Алчуур нь үүдний эсрэг талд байрладаг тул хүүхдүүд гараа арчихаа мартдаг гэх мэт жижиг зүйлс нь багш, туслах багшийн ажлын ачааллыг нэмэгдүүлдэг.

Зөвлөмж



Багш хүүхдэд туслах хангалттай зайтай байх
Тоноглол, хэрэглэлийн өндөр, хэмжээ нь багш хүүхдэд туслахад тохирсон байх
Ариун цэврийн өрөө нь цэвэрлэхэд хялбар байх (шал, хана, угаалтуур, суултуур)
- Угаалга, цэвэрлэгээний материал хадгалах 4 төрлийн шүүгээ. Хананд өлгөх шүүгээ байж болно. Ариутгал цэвэрлэгээний бодис хадгалах шүүгээ хүүхэд хүрэхгүй өндөрт байх
Шүүр, шалны мод, тоос сорогч хадгалах шүүгээ нарийхан өндөр хэлбэртэй байх. Том түмпэнгийн том шүүгээтэй байх. Ариун цэврийн нэмэлт бараа хадгалах шүүгээ



Хэрэгжүүлэх арга зам

Ариун цэврийн өрөөний дотоод зай талбайг багш хүүхдэд туслахад төвөггүй байхаар зөв зохион байгуулна. Бага ангийн болон 24 цагийн цэцэрлэгүүдэд хүүхэд угаах ванныг багшийн нурууны өндөрт тааруулж дээр байрлуулна.

Ингэснээр багш олон хүүхэд угаахад түүртэхгүй, нуруу өвдөхгүй байх сайн талтай Цэвэрлэгээний материал, багаж хэрэгслийг тус тусад нь шүүгээ саванд хадгалаарай. Ялангуяа хүүхдэд аюултай цэвэрлэгээний бодисыг хүүхэд хүрэхгүй өндөр шүүгээнд унаж ойчих аюултай эсвэл бохир зүйлсийг хийх тус тусдаа шүүгээтэй байх нь хүүхдэд аюулгүй, багшид ажил хийхэд илүү дөхөмтэй байх сайн талуудтай.

Сайн туршлага: Японы Хүүхдийг ивээх сан



Зураг 38. Цэвэрлэгээний хэрэгсэл, ариутгалын бодис нь хүүхдэд аюултай ил байрласан



Зураг 39. Ариутгалын бодис шүүрийг тусгай шүүгээнд хийж хүүхдэд аюулгүй болгосон



Зураг 40. Хүүхэд усанд оруулах тосгуур намхан тул багш тонгойж хүүхэд угаах болдог.



Зураг 41. Тосгуурын өндөр багшийн нурууны өндөрт таарсан байна.



Зөвлөмж: Цэцэрлэг дээр өдөр тутам хийгддэг зарим ажил нь цэцэрлэгийн багш ажилчдад ачаалал нэмж байна. Жишээ нь ариун цэврийн цаас нь хүүхэд хүрч чадахааргүй байрласан тул багш нь байнга авч өгөх болдог. Өөрөөр хэлбэл хүүхдүүд байнга багшийгаа дуудаж цаас авахуулж байна гэсэн үг. Суултуур өндөр тул хүүхэд бүрийг өргөж суулгах босгох хэрэг гардаг гэх мэт. Мөн дээр дурьдсан намхан тосгуурт хүүхэд усанд оруулахад багшийн нуруу маш их чилдэг байна. Иймд цэцэрлэгийн ариун цэврийн байгууламж нь багш ажилчдад ачаалал нэмэхээргүй байх хэрэгтэй.

Цэцэрлэгийн ариун цэврийн байгууламж

Цэцэрлэгийн бие засах өрөө нь хүртээмжтэй, хүүхдийн хөгжилд дэмтэй, багш (туслах багш) хэрэглэхэд дөхөмтэй, цэвэрхэн, аюул осолгүй байх.

Шаардлага: Цэцэрлэгийн бие засах өрөө нь цэвэрхэн, аюул осолгүй байх

Зөвлөмж



- Жижигхэн завсар, зай гаргахгүй байх, бүх шугам хоолойг ханан дотуур буюу шалан доогуур явуулах
- Цэвэрлэхэд хялбар материал, багаж төхөөрөмж хэрэглэх
- Зохих агааржуулалттай байх (ердийн болон механик агааржуулалтын систем, эсвэл салхивчтай цонх) Цонхыг сонгохдоо салхивч нь хүүхэд хүрэхээргүй дээд талдаа байрладаг цонхыг сонгоно
- Шал халтирдаггүй байх
- Цахилгааны холболтыг зохих журмын дагуу хийсэн (гар хатаагч/хэт ягаан туяаны гэрэл), унтраалга разетка хүүхдэд аюулгүй хамгаалалттай байх



Хэрэгжүүлэх арга зам

- Ариун цэврийн өрөөнд засвар хийхдээ ил явсан шугам хоолойг далдалж цэвэрлэгээ хийхэд саад болохгүй, гар хуруу гэмтээхгүй байхаар янзлах
- Өрөөний шал, хана, бусад тоноглолыг цэвэрлэхэд хялбар шаазан, хуванцар зэрэг материалаар хийгдсэн зүйлс сонгох нь зүйтэй.
- Угаалга цэвэрлэгээний бодисын нөөцтэй, төсөвтэй байх
- Цэцэрлэгийн ариун цэврийн өрөө нь зохих агааржуулалтын системтэй байхаар төлөвлөгдсөн байдаг. Гэсэн хэдий ч 2-3 жилд агааржуулалтын хоолойг шалгаж бөглөрсөн, ажиллахгүй байгаа зүйлийг засах.
- Хэрэв агааржуулалт хангалтгүй бол нэмэлт сэнс суурилуулах замаар ариун цэврийн өрөөг байнгын ажиллагаатай агааржуулалттай байлгах

Сайн туршлага Японы Хүүхдийг ивээх сан



Зураг 42. Цэвэрлэхэд хэцүү ил буй шугам хоолой



Зураг 43. Бүх шугам хоолойг далдалж, шал, ханыг цэвэрлэхэд хялбар плитагаар өнгөлсөн байдал



Зураг 44. Ариун цэврийн өрөөний багшийн хэсэг. Энд цэвэрлэгээний бодис, материал хэрэгсэл хадгалах шүүгээ, хүүхэд усанд оруулах хэсэг зэрэг багтана.



Зураг 45. Ариун цэврийн өрөөний хүүхдийн хэсэг. Энд суултуур, угаалтуур, гар хатаагч зэрэг зүйлс байрлана.

Цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийг засварлах, ашиглахад өгөх ерөнхий зөвлөмж

1. Анги танхимын зохион байгуулалтыг хянан үзэх

Ариун цэврийн байгууламж нь хүүхдийн хөгжлийн үе шатанд тохирсон байх хэрэгтэй. Тиймээс цэцэрлэгийн эрхлэгчид анги танхимын зохион байгуулалтыг урт хугацааны, алсын хараатай хянан үзэх хэрэгтэй. Хүүхдүүд цэцэрлэгээс сургуульд дэвших хүртлээ анги солидоггүй. Энэ нь дээр дурьдсанчлан хүүхдүүд өөрсдийн нас биеийн онцлогт тохироогүй суултуур тоноглолыг хэрэглэхэд хүргэж байна. Тиймээс наанадаж 2-3 настай хүүхдэд тохируулан нэг анги танхим, бие засах өрөөг тоноглохыг зөвлөж байна. Харин цэцэрлэгийн тэр анги танхимыг сонгохдоо хамгийн оновчтой байрлалтайг сонгох хэрэгтэй. Тухайлбал орж гарах хаалганд ойр, доод давхарт, хамгийн дулаахан эсвэл унтлагын өрөөтэйг бага ангиар сонгох.

2. Шинэчлэн засах анги танхимыг сонгох (заримыг нь шинэчлэн засах гэж байгаа бол)

Хэрэв зөвхөн зарим ариун цэврийн өрөөг засах гэж байгаа бөгөөд цэцэрлэгийн эрхлэгч аль ариун цэврийн өрөөг засахыг сонгох ёстой бол юуг анхаарах вэ?

Хэрэв 2-3 настай хүүхдийн ариун цэврийн өрөөг шинэчлэн засах гэж байгаа бол хамгийн дулаахан ангийг сонгоорой. Өөр өөр төрлийн ангиудыг сонгоорой. Тэгвэл дараа нь бусад анги танхимд засвар хийхэд олон янзын жишиг загвартай болсон байх болно. Цэвэр, бохир усны шугамын холболтыг анхаарах хэрэгтэй. Шугам хоолой нь дээд ба доод давхрын ариун цэврийн өрөөний хооронд холбогдож байгаа. Хэрэв зэргэлдээ эсвэл дээд доод давхрын 2 ариун цэврийн өрөөг сонговол барилгын гүйцэтгэгч компани цэвэр бохир усны хоолойг иж бүрэн солих боломжтой болно.

3. Эрсдлийг зохицуулах бэлтгэлтэй байх

Цэцэрлэг үйл ажиллагаагаа явуулж байгаа тохиолдолд барилгын ажлын явцад маш олон эрсдэл тохиолдоно. Цэцэрлэгийн эрхлэгч цэцэрлэгийн эмчтэй хамтран барилгын засварын ажил эхлэхээс өмнө эрсдлийг зохицуулах бэлтгэл хангах арга хэмжээ авах нь зүйтэй. Тэд цэцэрлэгийн ажилтнууд, барилгын ажилчид, эцэг эхчүүдэд аюулгүйн ажиллагааг танилцуулж, засвар хийхийн өмнө болон засвар хийж байх явцад тогтмол хяналт тавин ажиллах хэрэгтэй.

Зарим цэцэрлэгүүд дээр хийгдсэн засвар шинэчлэлийн ажилд цэцэрлэгийн зүгээс хэрхэн оролцсоныг доорх туршлагуудаар харууллаа.

Жишээ №1

Манай цэцэрлэг барилгынхаа байдалд үнэлгээ хийхээр хуралдсан. Бидний ерөнхий дүгнэлтээр хүүхдэд тохирсон байгууламж тоноглол байхгүйн улмаас багш нар хүүхдэд маш их туслах хэрэг гардаг байна. Тухайлбал дараах зүйлс дутагдаж байна.

Суултуур нь насанд хүрэгсдэд зориулагдсан том хэмжээтэй тул багш 2 настай хүүхдийг ийм суултуурт суухад нь туслах хэрэгтэй болдог.

Эсвэл хуванцар хөтөвчинд бие засуулаад багш нь тухай бүрт нь угаах гэж их ажил гардаг. Суултуурын усны татуурга ажиллагаагүй тул хүүхдүүд усаа татах боломжгүй. Багш нь тухай бүрт хувингаар ус хийх болдог.

Суултуур томдоод хөл нь газар хүрдэггүй учраас хүүхдүүд суултуурын ирмэг дээр гараараа тулж суудаг. Угаагуурын крантны хэлбэр хийц хүүхдэд тохиромжгүй, хүүхэд онгойлгож чаддаггүй. Угаагуурт хүүхдүүд халуун, хүйтэн усыг тохируулж хэрэглэж чаддаггүй эсвэл халуун үгүй бол хүйтэн ус хэрэглэдэг.

Хурлын дараа өөрсдийн саналыг гүйцэтгэгчид хүргүүлж дээр дурьдсан засваруудыг хийлгэсэн.

Жишээ №2

Засвар хийх үеэр манай цэцэрлэг аяга тавагны угаагуурыг арай бага үнээр засаж өгөх талаар барилгын компанитай хэлэлцэж тохирсон юм. Аяга тавагны гурван угаагуур засах нийт зардал 676300 төгрөг болсон ба цэцэрлэгийн төсвөөс гаргасан.



Зураг 46. Засвараас өмнөх аяга таваг угаах хэсэг




Зураг 47. Засварын дараах аяга таваг угаах хэсэг

Жишээ №3

Хүүхдийг ариун цэврийн өрөөнд хэрхэн зөв явахыг заах нь:

Энэ талаар бид өмнө нь хэзээ ч бодож байгаагүй учраас ихээхэн бэрхшээл үүссэн. Бид хоёр саналыг хэрэгжүүлсэн бөгөөд эхнийх нь хөдөлдөг алчуурын өлгүүр ашиглаж хүүхдүүдийн хөдөлгөөнийг тодорхойлсон. Хоёрдугаарт хөлийн мөртэй наалт ашиглаж хүүхдийн явах замыг зааж өгсөн. Мөн эрэгтэй эмэгтэй суултуурыг ялгаж өгсөн. Энэ аргууд нь үр дүнгээ өгсөн.



Зураг 48. Хөдөлгөөнт алчуурын өлгүүр



Зураг 49. Хөлийн мөртэй наалт

4. УС, ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ САНТЕХНИКИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖҮҮД

Суултуур болон шээлтүүр

Суултуурын усны хэрэглээ нь зайлах савны эзэлхүүн, хос даралттай товчлууртай эсэх мөн цэвэрлэгдэх байдлаас хамаарна. Зайлах савны эзэлхүүн нь бага байх нь ус хэмнэх сайн талтай ч цэвэрлэгдэх байдал нь мөн чухал үүрэгтэй байдаг. Дараах аргаар суултуурын усыг хэмнэж болдог байна. Керамик гадаргууг нэмэлт байдлаар өнгөлж гулсамтгай байдлыг нь нэмэгдүүлнэ

Хуйларсан урсгал үүсгэж Вакуумжуулсан соролт бий болгох Хэрэглэгчид 2 товчлуур санал болгоно. Хэрэв суултуур бага бохирдолтой бол бага усаар зайлах үүднээс нэг буюу бага хэмжээтэй товчлуурыг дарна гэх мэт



Суултуурт хэрэглэдэг ус нь гэр ахуйн усны хэрэглээний 20-70 хүртэлх хувийг эзэлдэг. Тиймээс энэ нь хамгийн их анхаарах хэсэг юм.

Бусад орнуудад усны хэрэглээг бууруулах шинэлэг санаануудыг хэрэгжүүлж байна. Жишээ нь Японд усыг хэмнэх үүднээс ариун цэврийн өрөөний гар угаагуурыг шууд суултуурын зайлах саван (бочки) дээр байрлуулж өгсөн байна.

Зураг 50. Суултуур дээр байрласан гар угаагуур

Энэ нь зарим талаараа (хүн чөлөөтэй зогсох зай хангалтгүй) дутагдалтай мэт санагдаж болох ч усны хувьд асар их хэмнэлттэй, бага бохирдолтой усыг эргүүлэн ашиглах нэг шийдэл юм.

Та бүхэнд усны хэмнэлттэй зарим бүтээгдэхүүнийг танилцуулья.

Суултуур HDC283




Зураг 51. HDC 283

Бүтээгдэхүүний нэр	Салангид зайлах сав бүхий суултуур
Бүтээгдэхүүний марк	HDC283
Бүтээгдэхүүний зориулалт	Орон сууц, олон нийтийн барилгын ариун цэврийн өрөөнд зориулсан суултуур
Үйлдвэрлэгч	Tangshan Huida Ceramic (Group) Co.,Ltd
Нийлүүлэгч	Номин стандарт ХХК

№	Үзүүлэлт	Нэгж	Утга
1	Зайлах усны зарцуулалт	л	3/6
2	Суултуурын төрөл	-	Доош угаалттай

3	Зайлах савны төрөл	-	Угсардаг салангид
4	Товчлуурын төрөл	-	Хромжуулсан, дардаг хос товчлууртай
5	Гаргалга	-	Арагшаа буюу хана руугаа
6	Үнэ (2012 оны 4-р улирал)	төг	113000


Суултуур HDC173

 <p style="text-align: right; font-size: small;">www.china.cn</p>	Бүтээгдэхүүний нэр	Нэгтгэсэн цул зайлах сав бүхий суултуур
	Бүтээгдэхүүний марк	HDC173
	Бүтээгдэхүүний зориулалт	Орон сууц, олон нийтийн барилгын ариун цэврийн өрөөнд зориулсан суултуур
	Үйлдвэрлэгч	Tangshan Huida Ceramic (Group) Co.,Ltd
	Нийлүүлэгч	Номин стандарт ХХК

Зураг 52. HDC 173

№	Үзүүлэлт	Нэгж	Утга
1	Зайлах усны зарцуулалт	л	3\6
2	Суултуурын төрөл	-	Доош угаалттай
3	Зайлах савны төрөл	-	Угсармал, салангид
4	Товчлуурын төрөл	-	Хромжуулсан, дардаг хос товчлууртай
5	Гаргалга	-	Арагшаа буюу хана руугаа
6	Үнэ (2012 оны 4-р улирал)	төг	208000

Хөтөвч HDU850

	Бүтээгдэхүүний нэр	Босоо шээлтүүр
	Бүтээгдэхүүний марк	HDU850
	Бүтээгдэхүүний зориулалт	Олон нийтийн барилгын ариун цэврийн өрөөнд зориулсан суултуур
	Үйлдвэрлэгч	Tangshan Huida Ceramic (Group) Co.,Ltd
	Нийлүүлэгч	Номин стандарт ХХК

Зураг 53. HDU 850

№	Үзүүлэлт	Нэгж	Утга
1	Зайлах усны зарцуулалт	л	0.16 – 0.3
2	Шээлтүүрийн төрөл	-	Шалан дээр суурилуулдаг
3	Зайлах савны төрөл	-	Хоолойд шууд холболттой
4	Товчлуурын төрөл	-	Автомат
5	Гаргалга	-	Доошоо
6	Үнэ (2012 оны 4-р улирал)	төг	113000

Төрөл бүрийн холигч нэмэлт тоноглолууд

Ус хангамж ариун цэврийн байгууламжийн дотор системүүдийн тоноглолын хувьд ус, эрчим хүчийг хэмнэх дараах шийдлүүд байдаг.

Цоргоор гарах усны урсгалд агаар нэмж өгөх замаар хэрэглэгчдэд ижил хэмжээний мэдрэмж, үйлчилгээг бага усны зарцуулалтаар хүргэх


Усыг шаардлагатай үед нь хялбар байдлаар нээж, хааж өгөх, автоматжуулах

Цоргоор гарах усны урсгалын хэлбэрийг өөрчлөх замаар зарцуулалтыг багасгах

Халуун усны температурыг хурдан тохируулах замаар усны зарцуулалтыг бууруулах


Усны зарцуулалтыг их бага гэсэн хэлбэрээр сонгох хувилбартай болгох зэрэг болно.

Холигч HP41601SL

 <p>Зураг 54. HP41601SL</p>	Бүтээгдэхүүний нэр	Халуун хүйтэн усны холигч
	Бүтээгдэхүүний марк	HP41601SL
	Бүтээгдэхүүний зориулалт	Ариун цэврийн өрөөнд угаагуурт ашиглах
	Үйлдвэрлэгч	Highplus International Co.,Ltd
	Нийлүүлэгч	Мөнх наран ивээл ХХК

№	Үзүүлэлт	Нэгж	Утга
1	Өнгө	-	Мөнгөлөг
2	Материал	-	Зэвэрдэггүй ган
3	Усны даралтын хязгаар	бар \ата\	1-5
4	Температур тохируулагч	-	Энгийн байрлалаа хадгалснаар дараагийн удаад усны температурыг тохируулах шаардлагагүй
5	Усыг хаах нээх	-	Нэг удаагийн даралтаар нээж хаах учраас маш хялбар хурдан хугацаанд хаана
6	Ус хэмнэлт	%	48
7	Үнэ (2012 оны 4-р улирал)	төг	280000

Холигч HP1055

 <p>Зураг 55. HP1055</p>	Бүтээгдэхүүний нэр	Тохируулгатай ус хэмнэх аератор
	Бүтээгдэхүүний марк	HP1055
	Бүтээгдэхүүний зориулалт	Бүх төрлийн холигч, цоргонд ашиглаж усны зарцуулалтыг бууруулах
	Ашиглах хүрээ	Гал зуух, ариун цэврийн өрөө
	Үйлдвэрлэгч	Highplus International Co.,Ltd
	Нийлүүлэгч	Мөнх наран ивээл ХХК

№	Үзүүлэлт	Нэгж	Утга
1	Өнгө	-	Мөнгөлөг
2	Материал	-	Хүрэл, хромон өнгөлгөө, хуванцар
3	Усны даралтын хязгаар	бар \ата\	1-5
4	Холбогдох хэлбэр	-	15\16-27 (M24x1) Эр эрээсэн холболттой
5	Ус хэмнэлт	%	30 - 85
6	Усны зарцуулалт	л\мин	6 байхаар тохируулахыг зөвлөдөг
7	Үнэ (2012 оны 4-р улирал)	төг	6500

Халуун ус бэлтгэх төхөөрөмжүүд

Эзэлхүүний цахилгаан халаагуур

Дотор тал нь зэс болон ган бүрэлттэй, бага чадлын эзэлхүүний цахилгаан халаагуур нь хуванцар дулаалгатай эзэлхүүний сав, ус халаагч цахилгаан халаагуураас бүрдэнэ. Хуурай ажиллах, хэт халалтаас хамгаалсан температур тохируулах боломжтой байна. Төрөл бүрийн багтаамжтай байх ба төгсгөлийн хэрэглэгч дээр байрлана. Хэрэглээний онцлогоос хамаарч багтаамж өөр өөр байх ба шүршүүр ваннтай нөхцөлд 80-100литр багтаамжтайг хэрэглэнэ.

Эзэлхүүний цахилгаан ус халаагч нь хурдны ус халаагчийг бодвол дулаан алдагдалтай байдгаас илүү их эрчим хүч хэрэглэдэг.

Хурдны\агшин зуурын цахилгаан ус халаагуур

Хурдны ус халаагуур нь эрчим хүчний хэрэглээний хувьд эзэлхүүнийхээс бага байдаг. Хэрэгцээтэй үед шаардлагатай халуун усыг шууд бэлтгэдгээрээ онцлог юм. Үндсэн онцлогийг дурьдвал:

Усыг шууд халаах зориулалттай

Үнэ хямд

Цахилгааны өндөр чадалтай гаралт шаардлагатай


Даралтын зөрүүг мэдрэхээс гадна усны урсгалыг мэдрч, асч унтрах зориулалттай

Гол төлөв 3-5л багтаамжтай жижиг савтай байдаг

6кВт-аас дээш чадалтай системд 380В хүчдэлээр тэжээх шаардлагатай


Температурын тохиргоо нь 35-55°C байдаг

БҮЛЭГ



**ЭРҮҮЛ АХУЙН БОЛОВСРОЛ, ЗАН ҮЙЛИЙН
ӨӨРЧЛӨЛТӨД ТАВИГДАХ ШААРДЛАГЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ**

1. ЭРҮҮЛ АХУЙН БОЛОВСРОЛ

<p>Шаардлага: Эрүүл ахуйн боловсрол нь сургалтын хөтөлбөрийн салшгүй хэсэг байх ба ариун цэврийн өрөөг хэрхэн ашиглах, гар угаах, шүд угаах, хог хаягдал зэрэг агуулгыг багтаасан байх.</p>	
<p>Тайлбар: Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчинд эрүүл ахуйн боловсрол эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулахдаа батлагдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд үндэслэн зохион байгуулна. ЕБС ийн дотуур байрны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хичээлийн бус цагаар дээрхи агуулгыг хүүхдэд дадал хэвшил болгоход чиглэгдсэн ажлуудыг зохион байгуулна.</p>	
	<p>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг нь эрүүл ахуйн сургалтыг хичээл болон хичээлийн бус цагаар зохион байгуулах төлөвлөгөөтэй байх</p>
	<p>Сургуулийн өмнөх болон бага боловсролын түвшинд эрүүл ахуйн дадал хэвшилд сургах нь илүү үр дүнтэй байдгийг анхаарч, эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо дэмжлэгтэйгээр хүүхэд бүрийг зөв дадал хэвшилд сургахад анхаараарай.</p>
	<p>Цэцэрлэг, ЕБС, дотуур байрын сурагчдыг гараа тогтмол, зөв угаах дадал, хэвшилд сургах сургалт зохион байгуулах.</p>
	<p>Гараа савандаж угаах нь халдварт өвчнөөс сэргийлэх хамгийн энгийн, үр дүнтэй арга зам гэдгийг багаас нь ойлгуулж, зөв дадал хэвшилд сургах.</p>



Хэрэгжүүлэх арга зам

Хичээлийн жилийн эхэнд тухайн насны сурагчдад хичээл болон хичээлээс гадуурхи үйл ажиллагааны хүрээнд эрүүл ахуйн сургалт зохион байгуулах төлөвлөгөөг багш, эцэг эх, сурагчдын оролцоотой боловсруулан хамтдаа хэрэгжүүлнэ.

Бага боловсролын цөм хөтөлбөрт тусгагдсан (Хүснэгт 1,2)-т заасан агуулгыг тухайн хүүхдийн насны онцлогт тохирсон арга зүйг сонгон хэрэгжүүлээрэй.

Эрүүл ахуйн боловсрол олгох зарим сэдвүүдийн агуулгыг оруулсныг сургалтандаа ашиглаарай.


ГАРЫН ЭРҮҮЛ АХУЙ

Хүний биед өвчлөл үүсгэдэг нян, вирус, шимэгчдийн 90% нь бохир гараар дамждаг байна. Мөн гарт байгаа өвчин үүсгэгчдийн 95% нь хумсанд байдаг. Гарын хумс нь хөлийн хумснаас илүү хурдан ургадаг ба түүнээс ч илүү их нянг агуулж байдаг. Иймээс гарын хумсыг долоо хоног бүр хэт лав биш богиносгох хэрэгтэй.

Гар угаах арга:

Өдөрт гараа заавал тэдэн удаа угаах ёстой гэсэн тоо байдаггүй. Гэхдээ гарыг бохирдсон тохиолдол бүрт угаах шаардлагатай. Ялангуяа бие зассаны дараа, хоол унд бэлтгэх, идэхийн өмнө, нийтийн тээврийн хэрэгслээр зорчих, тэжээвэр амьтадтай харьцах, хог хаягдалтай харьцах, өвчтэй хүнийг асрах зэрэг үйлдлүүдийн дараа гараа савандаж угааж хэвших нь чухал юм. Гарыг 20 секундын турш савандаж угааснаар нянгийн тоог багасаж халдварт өвчин дамжих эрсдлийг бууруулна. Зөвхөн усаар гараа угаах нь хангалттай биш бөгөөд ус гарын бохирдол дахь тосыг цэвэрлэж чадахгүй. Гарыг дутуу угаасныг илтгэдэг зүйл бол алчуур юм. Бохирдсон алчуураар арчих нь халдвар дамжих бас нэгэн нөхцөл болдог.

Гар угаах дарааллыг сайтар зааж сурган, хэвшил болж буй эсэхэд ажиглалт хийгээрэй.



АМНЫ ХӨНДИЙН ЭРҮҮЛ АХУЙ

Шүд болон амны хөндий эрүүл байх нь хүүхдийн өдөр тутмын тааламжтай байдлыг хадгалж, өөртөө итгэх итгэл, хоол тэжээлийг хэвийн боловсорч шингэхэд нөлөөлдөг.

Хүний шүд нь хоолыг тасдах, зулгаах, жижиглэх бутлах үүрэгтэйгээс гадна хүний хэл яриа, гоо сайхан байхад чухал нөлөөтэй. Шүдийг өдөрт хоол идсэний дараа заавал угаах хэрэгтэй. Учир нь хоолны үлдэгдэл шүдний пааланд хүчиллэг орчин бүрдүүлж шүд цоорох эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Гэхдээ боломжгүй тохиолдолд өдөрт дор хаяж 2-оос багагүй удаа угаах хэрэгтэй. 6 наснаас 14 насны хооронд хүүхдийн сүүн шүд унаж, байнгын шүдээр солигддог. 14 наснаас хойш дахин нэмж шүд ургахгүй. Шүдийг (өглөө, орой) 2 минутын туршид угаах хэрэгтэй. Шүдээ сайтар угааж шүдний өнгөрийг бүрэн арилгах нь шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх сайн арга байдаг. Шүдний өнгөр гэдэг нь цайвар шаргал өнгийн шүдний гадаргууд нягт бэхлэгдсэн давхарга бөгөөд нян болон түүний бодисын солилцооны задралын бүтээгдэхүүн юм. Энэ нь ихэвчлэн шүд буйлны уулзвар хэсэг, шүд хоорондын завсар, шүдний төрөлхийн ховил хонхороор үүсдэг.

- Орой унтахын өмнө шүдийг зайлшгүй угаах хэрэгтэй. Учир нь шөнө хүний шүлс ялгаралт буурсанаар амны хөндийг цэвэршүүлэх үйл ажиллагаа явагдахгүй, хоолны үлдэгдэл хуримтлагдах нь хялбар байдаг.

- хоол идсэний дараа шүдийг заавал угаах шаардлагатай бөгөөд хэрвээ шүд угаах боломжгүй бол бүлээн усаар зайлж хэвшээрэй. Ингэхийн тулд амандаа ус балган амны эргэн тойрны булчингуудыг идэвхитэй ажиллуулж хүчтэй хөдөлгөсний дараа усаа нулимж асгана. Энэ үйлдлийг 2-3 удаа давтан хийж, аман дах хоолны үлдэгдлийг цэвэрлэнэ.

-Шүдээ угаасны дараа зориулалтын хэл цэвэрлэгч эсвэл шүдний сойзоороо хэлнийхээ угаас үзүүр лүү чиглэлд хэлийг угаана. Хэлний үзүүрээс уг руу чиглэсэн хөдөлгөөнөөр угааж болохгүй анхаараарай.

Шүдний сойзыг сонгох тухай

Шүдний сойзыг сонгон авахдаа сойзны толгой, үс, иш гэсэн хэсгийг үндэслэн сонгоно. Шүдний сойзны толгой хэсэг нь таны үүдэн 2 шүдний хэмжээтэй адил эсвэл таны долоовор хурууны 1-р үений урттай ижил байх хэрэгтэй. Хэт том сойзоор шүд бүрийг сайн угаах боломжгүй байдгаас гадна амны хөндийн зай багатай арын шүднүүдийг бүрэн угааж чаддаггүй. Сойзны толгой жижиг байх тусам аманд чөлөөтэй хөдөлж, шүд бүрийг угаах боломжтой. Шүдний сойзны үс хатуу, зөөлөн, ердийн гэж байдаг шүдний цоорол, паалангийн гэмтэл, буйлны үрэвсэл зэргээс хамааран өөрт тохирохыг сонгоно. Үсний эгнээ 2-3 эгнээ байхад тохиромжтой. Шүдний сойзны иш гарт барихад зориулсан янз бүрийн загвартай байдгаас гадна урт байх нь араа шүднүүдийг угаахад тохиромжтой. Сойзыг гурван сар тутам солих шаардлагатай ба шүдний сойзны үс арзайсан тохиолдолд нэн даруй солино.

Сойзон дээр тавих ооны хэмжээ

Сойзон дээр оог тавихдаа өөрийн чигчий хурууны хумсны толион чинээ хэмжээтэйг тавих хэрэгтэй. Бид хэдий чинээ их оо тавина, төдий чинээ сайн гэсэн буруу ойлголттой байдаг. Хэт их оо нь аманд гааны сэнгэсэн амтыг мэдрүүлж бүрэн цэвэрлэгдсэн мэт сэтгэгдэл төрүүлэхээс гадна их хөөсөрч хурдан угаахад хүргэдэг. Иймээс шүд угаахдаа ооны хэмжээгээ анхаараарай.

Шүд хоорондын завсар цэвэрлэх утсаар сойз хүрэх боломжгүй шүдний түшилцэх гадаргууг цэвэрлэнэ. Энэ гадаргуу нь шүд цоорох өвчинд өртөмхий байдаг. Учир нь шүд хоорондын завсар хоол хүнсний үлдэгдэл удаан байснаар хүчиллэг орчинг үүсгэн шүдний пааланг гэмтээж шүд цоорно. Шүдний утас нь лавтай, лавгүй гэсэн 2 төрөл байх ба лавтай утсыг хэрэглэх бүрд шүдний түшилцэх гадаргууд зай гарах тул лавгүйг голчлон хэрэглэнэ. Шүдийг угаахаасаа өмнө утсаар цэвэрлэх нь илүү тохиромжтой байдаг.

АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ СОЁЛ

Бие засах нь хүний үндсэн хэрэгцээ бөгөөд ариун цэврийн байгууламж нь хүний эрүүл мэндэд чухал нөлөөтэй. Хүн амьдралынхаа туршид 4 жилийг бие засахад зарцуулдаг байна. Ариун цэврийн байгууламжийг дараагийн хүнд саад болохгүйгээр зөв ашиглах нь хүн бүрийн үүрэг төдийгүй соёлын нэг хэмжүүр болдог. Таны гаргасан зохисгүй үйлдлээс болж дараагийн хүний эрүүл мэнд хохирох ёсгүй. Ямар ч тохиолдолд ил задгай бие засахаас татгалзах ёстой. Учир нь ялгадсан дээр ялаа, хортон сууж, хоол хүнс, эд хогшилд өвчин үүсгэгч нянг тарааж, улмаар хэн нэгнийг өвчлүүлэн халдварт өвчин гарах шалтгаан болдог. Иймд ил задгай бие засахаас ямагт татгалзах, ариун цэврийн байгууламжийг зөв боловсон ашиглах нь өөрийгөө болон бусдыг хүндэлдэг хүн бүрийн эзэмших ёстой хэвшил юм. Сурагчдад ариун цэврийн өрөөг ашиглах дараах зөв дадлыг хэвшүүлэхэд зөвлөж туслаарай..

Гадаах жорлонгийн хувьд:

- Гишгүүр, тавцанг бохирдуулалгүй цэвэр ашиглах.
- Хэрэглэсэн цаас болон ариун цэврийн хэрэглэлээ зориулалтын хогийн саванд хаях.
- Бие зассаны дараа гараа савандаж угаах

Төвлөрсөн шугаманд холбогдсон ариун цэврийн байгууламжийн хувьд:

- Суултуур дээр сууж бие засах
- Бие зассаны дараа усаа заавал татах
- Суултуур бохирдсон бол зориулалтын сойзоор үрж угаах
- 00 цаас, нойтон салфетка, ариун цэврийн хэрэглэлээ зөвхөн хогийн сав руу хаях
- Бие зассаны дараа гараа савандаж угаах

Шээлтүүр нь хөвгүүд зогсож бие засах зориулалттай тоноглол юм.

Шээлтүүрийг ашиглахдаа:

- Шээлтүүрийн гадуур бие засаж болохгүй
- Хэрэглэсний дараа усаа татаж байх
- Шээлтүүрт хог хаягдал хийж болохгүй
- Бие зассаны дараа гараа савандаж угаах

ХОГ ХАЯГДЛЫГ БАГАСГАХ, ЗӨВ ЗАЙЛУУЛАХ

Хэрэглээний болон үйлдвэрлэл үйлчилгээний явцад үүсэн хүний хэрэгцээнд ашиглагдаад, цаашид тухайн зориулалтаар хэрэглэгдэхгүй болсон эд юмсыг хог гэнэ. Улс орон хөгжиж, хүний амьжиргааны боломж нэмэгдэх хирээр хэрэглээ ихсэж, хог хаягдлын хэмжээ ихсэж улмаар хогийг устгахад бэрхшээлтэй болж байна. Иймээс хүн бүр хог хаягдлаа зөв зайлуулах, бууруулахад хувь нэмрээ оруулах ёстой. Хог хаягдал бүхэн байгаль орчинд хортой байдаггүй, заримыг нь дахин ашиглаж, шинээр бүтээгдэхүүн хийж орлого олох боломжтой. Бидний өдөр тутмын амьдралын хэрэгцээнээс гарч байдаг хог хаягдлыг байгаль орчинд үзүүлэх хор нөлөөгөөр нь ангилж болно.

Байгальд хор хөнөөл багатай: салфетка, органик хаягдал/жимс ногооны үлдэгдэл/, сонин, шүдэнз, шилэн лонх.

Байгальд хор хөнөөл ихтэй: тамхины иш, бохь, хөнгөн цагаан лааз, гялгар уут, ус ундааны хуванцар сав
Хог хаягдлын хэмжээг бууруулахад дараах зүйлсийг хийх боломжтой.

Багасгах

Ашигладаг бараа бүтээгдэхүүнийхээ хэмжээг багасгах. Өөрөөр хэлбэл онцын шаардлагагүй зүйлсийг худалдан авахаас татгалзана гэсэн үг юм. Энэ нь биднээс гардаг хогны хэмжээг ихээр бууруулна.

Дахин ашиглах

Аль болох дахин ашиглахыг хичээх. Та өөрөө дахин хэрэглэхгүй бол өөр хэн нэгэн ашиглах боломжтой эсэхийг судлаарай:

Дахин ашиглагдах боломжтой хог хаягдал буюу “дахивар”

- Цаас сонин, сэтгүүл, дэвтэр, бичгийн цаас, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, сүү, жүүсний тетропак савалгаа
- Хуванцар төрөл бүрийн ус, ундааны хуванцар сав, кетчуп, ургамлын тос, бие угаагч шингэн, шампунь, угаалгын шингэний хуванцар сав,
- Хөнгөн цагаан, метал, зэс, гууль төрөл бүрийн хөнгөн цагаан, метал, зэс, гууль сав
- Шил хүнсний болон ундааны төрөл бүрийн шилэн сав
- Модон эдлэлийн хаягдал
- Гялгар уут, хуванцар сав баглаа боодол

Хог хаягдлын задрах хугацаа:

Салфетка – 3 сар

Органик хаягдал – 3-6 сар

Сонин – 3-12 сар

Шүдэнз – 6 сар

Тамхины иш – 1-2 жил

Бохь- 5 жил

Хөнгөн цагаан лааз – 10-100 жил

Гялгар уут – 100-1000 жил

Ус ундааны хуванцар сав – 100-1000 жил

Шилэн лонх - 4000 жил



Эрүүл ахуйн боловсрол олгож буй сайн туршлагууд:

- “Үдийн цай” хөтөлбөрийн загвар сургууль болохоор ажиллаж буй Архангай аймгийн 2 дугаар сургууль, Булган аймгийн Дашинчилэн сумын дунд сургууль, Нийслэлийн СБД-ийн 58-р сургуульд үдийн цайгаа уухаас өмнө гараа тогтмол угааж хэвших сургалтыг хоол зүйч, эмч, эрүүл мэндийн багш нарын оролцоотойгоор тасралтгүй явуулж, хэвшил болгосон байна.
- Эй Си Эф (АСФ) Монгол олон улсын байгууллага нь хүүхдийн гар угаах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор ариун цэврийн байгууламжийг сайжруулах төслийг хэрэгжүүлэн гар угаах боломжоор ханган саван байрлуулж, хэрхэн угаах талаар сургалт хийн, бие засах газарт гар угаах зааврыг байрлуулж, завсарлагаанаар ажиглалт хийж, сурагчдад тусалснаар гар угаалт эрс сайжирсан байна.
- Хан-Уул дүүргийн 34-р сургууль “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” болох зорилт тавьж, хичээлийн жилийн эхэнд эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан сургалт явуулж, гараа савандаж угаахын ач холбогдлыг ойлгуулснаар бүх сурагчдаас 1 ш саван авч бие засах газар байнга байрлуулж, тогтмол хэрэглэдэг болсон байна.
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Улсын тэргүүний 3-р цэцэрлэг Эрүүл ахуйн дадлыг хэвшүүлэхийн тулд багш нар нь эхлээд сургалтыг эцэг эхчүүдэд хийж, гар угаах дарааллын дагуу харуулж үзүүлдэг. Дараа нь хүүхдүүдийг өдөр бүр ажиглалт хийж, алдааг нь засч залруулах, магтаж урамшуулах зэргээр хүүхэд бүрийг гараа зөв угааж сургадаг байна. Ариун цэврийн бүх өрөөнд гар угаах зааврыг байрлуулж, байнга дагаж дуурайлган хийлгэх нь үр дүнтэй байдаг байна.
- Булган аймгийн 1-р сургууль нь эрүүл ахуйн дадал хэвшүүлэх зорилгоор багш бүр тусгай төлөвлөгөө боловсруулж, түүнийгээ захирлаараа батлуулан ажилладаг байна.
- Энэтхэг, Герман зэрэг орны сургуулийн дотоод журмын 50% нь эрүүл ахуйн дадал, хэвшлийг хэрэгжүүлэх заалт байдаг байна. Жишээ нь: сургуулийн ариун цэврийн байгууламжийг зөв ашиглах, зөв бие засах, гараа сайтар угааснаар халдварт өвчнөөс сэргийлэх г.м

ХҮСНЭГТ 1.


**Бага боловсролын цөм хөтөлбөрийн агуулгаар эрүүл ахуйн
мэдлэг, чадвар, дадлыг хэвшүүлэх загвар (I-III анги)**

Хичээлүүд	I анги	II анги	III анги
Ерөнхий чадвар	<p>Өдөр тутмын амьдралд мөрдөх шаардлагатай эрүүл ахуйн дэглэмийг мэддэг болох</p> <p>Гэр бүл, сургууль, орчин тойронд эрүүл ахуйн дэглэмийг мөрддөг байх</p> <ul style="list-style-type: none"> -гараа тогтмол угаах -шүдээ угааж хэвших -цэвэр ус ууж хэвших -хоггүй цэвэр амьдарч сурах 		
Хүн ба орчин	<p>Аюулгүй цэвэр орчин бүрдүүлэх санаачлага гаргах</p> <ul style="list-style-type: none"> - хогоо тусгайлсан саванд хаях, зөв бие засах 	<p>Аюулгүй цэвэр орчин бүрдүүлэхэд оролцох</p> <ul style="list-style-type: none"> - ариун цэврийн байгууламжаа зөв ашиглах, хоггүй цэвэр байж сурах 	<p>Ургамлыг арчилж, усалдгийн адил усыг бага багаар зөв уух</p>
Иргэний боловсрол (ёс суртахуун)	<p>Үдийн цайны дэг</p> <p>Бие засах үеийн дэг</p> <p>Гудамж талбай, сургууль, олон нийтийн газар хог хаяхгүй зориулалтын савыг хэрэглэж хэвшсэн эсэх</p> <ul style="list-style-type: none"> -Үдийн цай уухын өмнө гараа угаах -Цэвэр ус ууж хэвших -Бие зассаны дараа гараа тогтмол угааж хэвших -Зориулалтын саванд хог хаяж сурах, хоггүй цэвэр орчин бүрдүүлэх 		

Хүснэгт 3.

**Бага боловсролын цөм хөтөлбөрийн агуулгаар эрүүл ахуйн
мэдлэг, чадвар, дадлыг хэвшүүлэх загвар (IV-V анги)**

Хичээлүүд	IV анги	V анги
Хүн ба байгаль	<p>Амьд бие ба амьдралын орчин</p> <ul style="list-style-type: none"> -Амьд биед усны ач холбогдол, биеийн жингийн хэмжээнээс хамаарч усыг зөв уух 	<p>Усанд уусдаггүй хатуу бодисыг уснаас ялгах аргыг тодорхойлох</p> <ul style="list-style-type: none"> -Усыг цэвэршүүлэх буюу буцалгаж ууж хэвших
Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа	<p>Эрүүл мэнд</p> <ul style="list-style-type: none"> -Гараа угааж хэвших -Шүдээ цэвэр байлгах, арчлах -Ус уух нь эрүүл мэндэд ямар ач холбогдолтойг тайлбарлах 	
Иргэний боловсрол (ёс суртахуун)	<p>Үдийн цайны дэг</p> <p>Бие засах үеийн дэг</p> <p>Гудамж талбай, сургууль, олон нийтийн газар хог хаяхгүй зориулалтын савыг хэрэглэж хэвшсэн эсэх</p> <ul style="list-style-type: none"> -Үдийн цайндаа орохоос өмнө гараа угаах -Цэвэр ус ууж хэвших -Бие зассаны дараа гараа тогтмол угааж хэвших -Зориулалтын саванд хог хаяж сурах, хоггүй цэвэр орчин бүрдүүлэх 	

<p>Шаардлага: Эрүүл ахуйн боловсрол олгоход шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, материал нь хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон, хүртээмжтэй байх.</p>	
<p>Тайлбар: Эрүүл ахуйн боловсрол эзэмшүүлэхэд ашиглах гарын авлага, үзүүлэн, тараах материал нь хүүхдийн сонирхлыг татсан, эрүүл ахуйн шаардлага хангасан байхад анхаарах нь чухал юм.</p>	
<p>Зөвлөмж</p> 	<p>Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон байх</p> <p>Эрүүл мэндийн сургалтад ашиглах сургалтын хэрэглэгдэхүүн нь эрүүл ахуйн шаардлага хангасан байх.</p> <ul style="list-style-type: none"> - Зурагт үзүүлэн нь 60*40 см-аас багагүй хэмжээтэй буюу хамгийн хойно сууж байгаа хүүхдэд харагдахуйц байх - Цагаан өнгийн, шохойтой биш цаасан дээр хийх. Аль болох өнгийн цаасан дээр хийхгүй байх - Үсгийг энгийн шрифтээр бичих ба хэмжээ нь 3,5 см-аас багагүй байх <p>Эрүүл ахуйн боловсролын сургалтад мэдээлэл харилцаа, холбооны технологийг ашиглаарай.</p>



Хэрэгжүүлэх арга зам

Цэцэрлэг болон бага ангийн сурагчдын бодит үйлийн сэтгэхүй илүү хөгжиж байдаг тул аль болох бодит болон загвар үзүүлэнгүүдийг үзүүлж сургалтыг зохион байгуулах нь үр дүнтэй.

Харин дунд, ахлах ангийн сурагчдын дунд асуудал дэвшүүлсэн видео, өөрсдөө дүрийн тоглолт хийх, бага ангийн сурагчдад сургалт зохион байгуулах, уралдаан тэмцээн, аялал зэрэг тэдний өөрсдийн оролцоонд сургалтыг зохион байгуулах нь үр дүнтэй. Эрүүл ахуйн дадал төлөвшүүлэхэд тус нэмэр болох богино хэмжээний видео бичлэгүүд байдаг. Хэрэв танай сургууль дэлгэцтэй бол ийм бичлэгүүдийг хичээлийн завсарлагаа, хичээл тарсны дараа, тэмцээний үеэр ашиглаж болно.

Багш нар эрүүл мэндийн үзүүлэн материалыг зөвхөн сургалтад ашиглаад цаашид хүүхдийн байнгын хэрэглээ болгон ашиглуулдаггүй тал бий.

Ийм учраас сургалтын хэрэглэгдэхүүнийг зөвхөн сургалтад ашиглахаас гадна хүүхдийн мэдлэгийг бататгах зорилгоор үзэж, уншиж, хамтран ярилцаж, судалгаа хийхэд сургаж, ангийн номын сан, тавиур зэрэгт ил байлгана. Ялангуяа дотуур байранд заавал байлгах эрүүл мэндийн /зөвшөөрөгдсөн/ ном, гарын авлагын жагсаалтыг эмч болон мэргэжлийн хүмүүстэй хамтран гаргаж, ашиглан, тогтмол баяжуулж шинэчилж байх нь зүйтэй.

Мөн хүүхдийн сонирхлыг татсан зурагт /плакат, брошур, сэтгүүл/ мэдээллийг альбом, хавтаст хийж тавих ба мэдлэгээ ашиглан тоглох эрүүл мэндийн тоглоом (хөлөгт тоглоом, эвлүүлдэг дүрс г.м.), сурагчдын өөрсдийн хийсэн бүтээлийг байрлуулж болно.

Эрүүл ахуйн дадлыг эзэмшүүлэх хэрэглэгдэхүүнийг боловсруулахдаа заавал мэргэжлийн хүнээс зөвлөгөө авах, мэргэшүүлэх сургалтад хамрагдан мэдээллээр хангагдсаны дараа боловсруулах шаардлагатай гэдгийг анхаараарай.

Боловсрол дах мэдээлэл харилцаа холбооны технологи нь хурдан хөгжиж буй тэргүүлэх чиглэлийн нэг бөгөөд Эрүүл ахуйн боловсрол олгох сургалтад өргөнөөр ашиглах боломжтой юм.

Дараах шалгуурыг ашиглан хийж буй үзүүлэх материалаа үнэлээрэй.

Сургалтын материалыг үзүүлж байгаа арга нь үр дүнтэй, хэмнэлттэй эсэх Бусад өөр хямд аргуудыг ашиглах боломж байгаа эсэх

Сургалтын материалын агуулга сургалтын төлөвлөгөөтэй тохирч буй эсэх

Ашиглаж байгаа мэдээлэл үнэн бодитой, шинжлэх ухааны үндэслэлтэй эсэх

Мэдээлэл хуучирсан эсэх

График схем зураглал нь үйл ажиллагааг үнэн зөв үзүүлж байгаа эсэх

Сургалтын материалын үзүүлж байгаа дараалал үнэн зөв эсэх

Үг өгүүлбэр болон мэдээллийг өөрчлөх боломжтой эсэх

Дэлгэц хэтэрхий дүүрсэн эсэх

Дэлгэцэн дээрх мэдээлэл унших боломжтой байгаа эсэх

Хэрэглэгч дэлгэцийг удирдах боломжтой эсэх

Сурагчдын идэвхтэй оролцоог хангаж буй эсэх

Асуулт, хариултыг оновчтой сонгосон эсэх

Багшгүйгээр сурагчид ажиллах боломжтой эсэх

Үзүүлэн бэлтгэхдээ агуулгын талаас дараах зөвлөгөөг анхаараарай.

Өөрийн танилцуулгын хамгийн чухал мэдээллийг тодорхойлох

Нэг слайдад 6-аас илүүгүй тэмдэглэсэн зүйлчлэл оруулах

Тэмдэглэсэн зүйлчлэл нь богино бөгөөд бүрэн дуусаагүй өгүүлбэр байх

Багш үзүүлэн бэлтгэхдээ нэг загварыг тууштай баримтлах нь эмх цэгцтэй харагдуулахаас гадна ойлгоход дөхөмтэй болгодог. Үүний тулд:

Харагдах байдлыг сайжруулахын тулд мөрийг тэгшлэх

Слайд бүрийн хөл толгойн хэсэг болон графикууд ижил зайтай байрлуулах

Слайдын дэвсгэр өнгө ба текстийн өнгө ялгагдахаар байх, олон өнгө сонгохгүй байх

Шаардлагагүй мэдээлэл, графикийг оруулахгүй байхад анхаараарай.




Сайн туршлага:

Эй Си Эф (ACF) Монгол олон улсын байгууллагаас гаргасан үзүүлэн нь эрүүл ахуйн сургалтад зориулагдсан цогц үзүүлэн юм. Өөрөөр хэлбэл үзүүлэн таниулах материал, гарын авлага нь ямар ч сургалтад ашиглаж болохуйц боловсронгуй хийгдсэн, сургалтад ашигласнаар сурагчдын зөв дадал хэвшихэд үр дүнгээ өгч буй нь туршилтаар батлагдсан юм. Энэхүү үзүүлэнгүүд зөөвөрлөж авч явахад боломжтой, тусгай цүнхэнд байрлуулсан багц үзүүлэн юм. Мөн гар угаах тухай дууны CD нь цэцэрлэгийн хүүхдүүд, бага ангийн сурагчид дагаж дуулж, гараа угааж хэвшихэд ач холбогдолтой. Хүүхдүүд схемийн дагуу хоорондоо харилцан ярьж, эвлүүлдэг зурагт үзүүлэнтэй. Жишээ нь: - “Гар угаах” сургалтын зурагт үзүүлэн 60*80 см хэмжээтэй, тод зурагтай, үзүүлэнгийн гадна талаар гялгар /ламинатор/ материалаар бүрсэн, олон дахин ашиглахад зориулагдсан. Хүүхдийн чөлөөт цагаар сонирхон унших эрүүл мэндийн материалыг дотуур байранд байрлуулах нь үр дүнтэй байдаг байна.

АДРА Монгол олон улсын байгууллагын тамхины эсрэг сурталчилгааны материал, видео бичлэг гэх мэтийг боловсруулан сурагчдад тамхины хор хөнөөлийг сурталчилсан.

Баянгол дүүргийн 93-р цэцэрлэг нь “Эрүүл мэндийг дэмжих байгууллага” болох хөдөлгөөнд идэвхтэй оролцож, хамт олон бүх багш нараар сургалт, сурталчилгааны материал /үзүүлэн, зөвлөмж, гарын авлага/-ыг цэцэрлэгийн мэргэжлийн эмчийн тусламжтайгаар бэлтгэж, сургалтын арвин хэрэглэгдэхүүнтэй болсон.

<p>Шаардлага: Сургууль (дотуур байр) бүр ус, ариун цэвэр, эрүүл ахуйн асуудлыг давхар хариуцсан ажилтантай байх</p>	
<p>Тайлбар: Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт ус, ариун цэвэр, эрүүл ахуйн асуудлыг энэ чиглэлийн мэдлэг, туршлагатай, эсвэл энэ чиглэлээр ажиллах сонирхолтой аль нэг ажилтанд давхар хариуцуулж, ажлын байрны тодорхойлолтод нь тусган, боломжтой нэмэлт, дэмжлэг урамшуулал үзүүлж, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах нь үр дүнтэй.</p> <p>БСШУЯ-наас ус ариун цэвэр эрүүл ахуйд тавигдах норм шаардлагыг хэрэгжүүлэх орон нутгийн сургагч багш нарыг бэлтгэсэн. Аймгаас зохион байгуулах сургалтуудад дээрх ажилтныг хамруулах нь зүйтэй.</p>	
<p>Зөвлөмж</p> 	<ul style="list-style-type: none"> • Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн олонхид нь эмч ажилладаг тул эмчтэй сургуулийн хувьд энэ асуудлыг эмчид хариуцуулаарай. • Эмч ажилладаггүй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хувьд эрүүл мэндийн бэлтгэгдсэн багш болон өөрийн сонирхлоор ажиллах багшийг сонгож ажиллуулаарай.



Хэрэгжүүлэх арга зам

Тухайн хичээлийн жилийн эхэнд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн эмчийн зүгээс байгууллагынхаа ус, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл байдалд үнэлгээ хийн, жилийн ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх нь зүйтэй.

Төлөвлөгөөг боловсруулахдаа сурагчид, багш, эцэг эх, олон нийтийн оролцоог ханган, хэрэгжүүлэхдээ мөн хамтрах нь илүү үр дүнтэй болно.

Цэцэрлэгийн багш нар ажлын байраа орхиж, сургалтад суух боломж хамгийн багатай байдаг. Ийм учраас багш нарыг сургалтад хамруулахаас илүү эмч, арга зүйчдийг сургалтад хамруулан тэд нараар дамжуулан ажлын байран дээр нь чадавхжуулах сургалтыг зохион байгуулах хэрэгтэй.

Цэцэрлэг, сургуулийн эмч нар ус, ариун цэвэр, эрүүл ахуйн чиглэлээр багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж болно.

Эрүүл мэндийн асуудал хариуцсан ажилтан нь ялангуяа дотуур байрны охид хөвгүүдэд зөвлөгөө өгдөг, охидын сарын тэмдэг ирэх үед ариун цэврийг хэрхэн сахих зөвлөмж, дэмжлэг үзүүлдэг байх хэрэгтэй.

Дотуур байрны хүүхдүүд тулгамдсан асуудлаа асуух, зөвлөгөө авах хүсэлтэй байдаг тул тэдэнд зориулж, жендер, нөхөн үржихүйн асуудал, охид хөвгүүдийн нөхөн үржихүйн асуудал, бие махбодын өөрчлөлтийн талаар ялангуяа охид, хөвгүүд гэж ялган зөвлөгөө өгөх тусгай өрөө байх шаардлагатай. Хэрэв өрөө хангалтгүй бол эмчийн өрөөнд тусгай хаалттай булан байгуулж болно.

Эмчгүй сургуулийн хувьд биологи, эрүүл мэндийн багш, эсвэл энэ чиглэлээр ажтлах сонирхолтой багшийг сонгон ажиллуулах нь зүйтэй.

Багшийн ажлыг үнэлж дүгнэх журамд сурагчдын эрүүл мэндийн асуудлыг тусгайлан үзүүлэлт болгон оруулсан учраас энэ чиглэлээр бүх багш нартай байгуулах гэрээнд тусган хэрэгжилтийг дүгнэж ажиллах боломжтой юм. Мөн эцэг эх, сум, орон нутгийн захиргааны байгууллагын хамтын оролцоог заавар хангаж хамтран ажиллавал илүү үр дүнг авчрах болно.



Сайн туршлага:

Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 23-р сургууль нь төсөл хөтөлбөрт хамрагдан эрүүл мэндийг дэмжих зорилгоор сургуулийн 2 нийгмийн ажилтан, биологи-эрүүл мэндийн багш, бага ангийн секцийн ахлагч, эмчээ жилийн турш сургалтад хамруулж, сургагч багш гэрчилгээтэй болгосон.

БГД-ийн 94-р цэцэрлэгийн эмч эрүүл ахуйн асуудлыг сурталчлах, хүүхэд бүрийг гараа угаах, шүдээ цэвэрлэхэд анхаарч, өглөө бүр эцэг эхчүүдэд зөвлөмж өгч, хүүхдийн хандлагын өөрчлөлтийг тэмдэглэл хөтлөн ажигладаг байна.

Налайх дүүргийн 109 дүгээр сургуулийн бага ангийн багш нар сургалтад сайн хамрагдан, эцэг эхчүүд, сурагчдад гар угаах, зөв хооллох чиглэлээр сургалт явуулдаг орон тооны бус зөвлөлтэй болсон байна.

Шаардлага:

- Эрүүл мэнд болон ус, ариун цэвэр, эрүүл ахуйн клубуудыг сургууль дээр байгуулж, идэвхтэй ажиллуулах.
- Ариун цэвэр, эрүүл ахуйн чиглэлээр хичээлээс гадуурх үйл ажиллагаа зохион байгуулах.
- Эцэг эх, асран хамгаалагчдад ариун цэвэр, эрүүл ахуйн чиглэлээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж, хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулдаг байх.

Тайлбар: Эрүүл мэндийн болон ус, ариун цэвэр, эрүүл ахуйн зан үйлийг өөрчлөх, сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг эрчимтэй, хүртээмжтэй хийхийн тулд сурагчдын ороцооны байгууллага, клуб байгуулж түүгээр дамжуулах нь хамгийн үр дүнтэй байдаг.

Зөвлөмж



Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг өөрсдийнх нь сонирхол, хүсэлтийг харгалзан эрүүл мэндийн болон ус, ариун цэвэр, эрүүл ахуйн клубуудыг байгуулж, үйл ажиллагааг дэмжин ажиллах нь хүүхдэд оролцонгоо, хийнгээ суралцах боломжийг олгон тэд хамтдаа хөгждөг тул сургууль бүр анхаарч ажиллаарай.

Энэ талаар хавсралт 2-д байгаа Эрүүл мэндийн клубын үйл ажиллагааны тухай зөвлөмжийг уншиж судлан, хэрэгжүүлээрэй.

Ус, ариун цэвэр, эрүүл ахуйтай холбоотой өдрүүдээр тусгай хөтөлбөрийн дагуу олон арга хэмжээ зохион байгуулж, тэмдэглээрэй. Жишээ болгон гар угаах дэлхийн өдрийг (Жил бүрийн 10 сарын 15) тэмдэглэх хувилбарыг оруулав.

Гар Угаах Өдөр 10 сарын 15

Жил бүрийн 10 сарын 15 - “Дэлхийн Гар Угаах Өдөр” бол дэлхийн олон сая хүмүүсийг савангаар гараа угаах явдлыг хөхүүлэн дэмжиж, татан оролцуулахад чиглэгдсэн компани үйл ажиллагааг явуулдаг тэмдэглэлт өдөр юм. Энэ өдрийн гол үзэл санаа нь гараа савандаж угааснаар өвчнөөс сэргийлэх чухал алхам болдог гэдгийг мэдүүлэхэд чиглэгддэг.

НҮБ-ын Ерөнхий Ассемблей 2008 оныг “Олон улсын Ариун цэврийн жил” болгож байгаатай холбогдуулан жил бүрийн 10-р сарын 15-ны өдрийг “Дэлхийн гар угаах өдөр” хэмээн тунхаглаж дэлхий даяар эрүүл ахуйн дадлыг сайжруулахыг уриалсан.

Сургуулийн зүгээс хийж болох зүйлс

- Дэлхийн Гар Угаах Өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх аливаа арга хэмжээг зохион байгуулах;
- Сургууль дээр хүүхдүүд гараа савандаж угаах нөхцөлийг бүрдүүлэх;
- Гараа савандаж угаах болон эрүүл ахуйн сургалт сурталчилгааг явуулах;
- Улсын хэмжээнд сургуулийн ус, ариун цэвэр, эрүүл ахуйн асуудал болон гараа савандаж угаахыг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн нөхцөл бололцоог сайжруулахын төлөө ажиллах;

Эцэг эхчүүдийг татан оролцуулах чиглэлээр

Дэлхийн Гар Угаах Өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнүүдэд хүүхдээ оролцоход нь туслах;

- Хүүхдийнхээ сурч байгаа газрын ус ариун цэвэр, эрүүл ахуйн аливаа асуудлыг сайжруулахад анхаарал хандуулж оролцдог байх;
- Сургууль дээрээ олж мэдсэн мэдлэг хандлагыг өөрийн гэр орондоо хэвшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх (бие засах газрынхаа ойролцоо гараа савандаж угаах нөхцөл бүрдсэн эсэхийг нягтлах);

Ямар үйл ажиллагаа зохион байгуулж болох вэ?

Өдөрлөг, арга хэмжээг эхлүүлэх

Засаг захиргааны байгууллага, мэргэжилтэн, сургууль хүүхдийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран зохион байгуулах, Гар угаах өдрийн арга хэмжээнүүдийн нээлт хийж олон нийтийн анхаарлыг татах баннер зурагт хуудас зэрэг биет зүйлсээр Гар Угаах Өдрийн уур амьсгалыг бүрдүүлнэ.

Хичээл, сургалт явуулах

Бохир гарын уршиг, гар угаахын ач холбогдол зэргийг хүүхдүүдэд заах бөгөөд бодит туршилт, баримтат кино, биеэр үлгэрлэн үзүүлэх, хамгийн муу ба сайн туршлагыг таниулах олон арга хэлбэрийг ашиглаж болно. Гараа савангаар зөв угаах дарааллыг эзэмшүүлж өвчнөөс сэргийлэх арга замыг хүмүүсийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан телевиз радио хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан зааж болох юм. (Жишээ нь хүүхдийн нэвтрүүлэгт гар угаах дарааллыг дуугаар дамжуулан заах гэх мэт)

Сургууль дээр зохиогдох уралдаан

Зан төлвийг өөрчилж, зөв дадлыг эзэмшүүлэх зорилготой уралдаан тэмцээнүүдийг сургууль дээр зохион байгуулж болно. Үүнд:

- Гар угаах дууны тэмцээн
- Уралдаант тоглоом
- Гар зураг, зурагт хуудас гаргах уралдаан
- Эссэ бичлэг, шүлэг, жүжигчилсэн тоглолтын уралдаан
- Сургуульдаа савангаар гараа угаах бололцоог хангуулах хөдөлгөөн өргүүлэх

Олны танил хүмүүсээс гараа савандаж угаахыг уриалах илч томилох

Олимпийн аварга, дуучин, спорт урлагийн одод, нийгмийн зүтгэлтэн зэрэг хүмүүсийн хайр хүндэтгэлийг хүлээсэн, олны танил хүмүүсийг нийгмийн сайн сайхны төлөө үйлст татан оролцуулдаг жишгийн дагуу тэдгээрээс хэн нэгийг савандаж гараа угааж байх зан байдлыг төлөвшүүлэхэд хүмүүст нөлөөлөх илчээр томилж болно. Жишээ нь хамгийн их итгэл бишрэлийг төрүүлж байгаа спортын од гараа савандаж угааж заншсанаар өвчин эмгэгээс холуур байж спортын өндөр амжилт гаргахад түлхэц өгсөн гэсэн санаагаар гараа савандаж угааж байгаа зурагт хуудас, реклам цацагдах нь олон нийтэд онцгой нөлөө үзүүлдэг байна.

Фото зургийн уралдаан

Хүмүүс савангаар гараа угааж байгааг харуулсан фото зургийн уралдаан зарлах нь бас нэг төрлийн үр дүнтэй мэдлэг мэдээллийг өсгөх арга хэмжээ болдог.



Сайн туршлага:

Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 37-р сургууль нь сурагчдын клуб байгуулахад онцгой анхаарч, гишүүн сурагчдыг дүүргийн Эрүүл мэндийн нэгдэлтэй холбон байнгын сургалтад хамруулж, сургалт зохион байгуулахад нь урамшуулж, бүх сурагчдыг хамарсан сэдэвт сар бүрээр уралдаан тэмцээн зохион байгуулдаг туршлагатай.

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын сургууль нь “Сурагч багш” нэг өдрийг зохион байгуулж, эрүүл мэндийн клубын хүүхдүүдээр хичээл заалгуулж, асууж ярилцах зүйл байвал эмчтэйгээ уулзуулан зөвлөгөө авахуулдаг байна.

Эй Си Эф (АСФ) олон улсын байгууллага нь “гар угаах” өдрийг тохиолдуулан сурагчдын дунд гар зургийн, “усны өдрийг” тохиолдуулан бичил төслийн уралдааныг сурагчдын дунд зохион байгуулахад нь сургуулиуд сурагчдаа хамруулан оролцуулж, дэмжлэг авдаг. Гарын дүрсээр янз бүрийн зураг зурж, бодол санаагаа илэрхийлж болно. Цэцэрлэгүүдийн дунд зохиосон зургийн уралдааныг Налайх дүүрэг, Эй Си Эф Монгол олон улсын байгууллагатай хамтран жил бүр зохион байгуулж, хүүхдийг урамшуулдаг байна.

Хүснэгт 4. Тэмдэглэлт өдрүүд

сар	
3-р сар	3-р сарын 22 Усны өдөр
5-р сар	5-р сарын 31 Тамхины эсрэг тэмцэх өдөр
9-р сар	Эрүүл шүдний өдөрлөг
10-р сар	10-р сарын 15 Гар угаах өдөр
11-р сар	11-р сарын 19 Дэлхийн 00-ийн өдөр
12-р сар	12-р сарын 1 ДОХ-той тэмцэх өдөр

Шаардлага: Сурагчдын мэдлэг, хандлага, зан үйлийн өөрчлөлтийг хянаж үнэлэх дотоод хяналтын тогтолцоотой байх.

Тайлбар: Эрүүл мэндийн болон эрүүл ахуйн талаарх мэдлэг, чадвар, хандлага, зан үйлийн өөрчлөлтийг тогтмол ажиглах, хянах, үнэлгээ дүгнэлт хийх нь сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг сайжруулах, эрүүл орчин бүрдүүлэх, эрүүл мэндийг дэмжихэд түлхэц болдог.

Зөвлөмж



Дараах зан үйлийг дадал, хэвшил болж буйг хянах, үнэлэх дотоодын тогтолцоотой байх

- ил задгай бие засахгүй байх
- жорлон, шээлтүүрийг зөв ашиглах
- гараа савандаж угааж буй байдал
- усыг зөв уух, хэрэглэх
- шүдээ тогтмол угааж, цэвэрлэж сурах
- хоггүй, цэвэр орчин бүрдүүлэх зэрэг зан үйл хэрхэн хэвшиж буйд тогтмол хяналт тавих, үнэлгээ хийх хэрэгтэй.

-Хянах, үнэлэх аргуудыг ашиглах

Ажиглах арга

Итгэлцэл бий болгох:

Асуумж, ярилцлагаар үнэлэх:

Мэдлэг, хандлага, дадлын судалгаа:

Хяналт үнэлгээг хэн хийж болох вэ?

Дараах байгууллагууд хяналт, үнэлгээг хийх. Үүнд:

- Орон тооны бус зөвлөл
- Сургууль, цэцэрлэгийн зөвлөл
- Сургууль, цэцэрлэгийн эмч, багш, ажилчид
- Сургууль, цэцэрлэгийн сурагчид
- Сурагчдын клубын гишүүд



Хэрэгжүүлэх арга зам

- Сургууль, цэцэрлэгийн орон тооны бус зөвлөл, эцэг эхийн зөвлөл, сурагчийн зөвлөл, ариун цэврийн зөвлөл гэх мэт дотоодын байгууллагуудаар хянаж, үнэлүүлэх
- Тогтмол хянах ажлын графиктай байх
- Хяналт, үнэлгээний дүнг багш, эцэг эх, удирдлагуудад сард /ачаалал ихтэй үед улиралд/ нэг удаа тайлагнаж байх
- Хүүхдийн эрүүл ахуйн зан үйлийн өөрчлөлтийг ажиглахын тулд юуны өмнө сургууль, цэцэрлэг нь хүүхдийн эрүүл ахуйн зан үйлд өөрчлөлт оруулах тэр орчинг бүрдүүлэх чиглэлээр орон нутгийн дэмжлэг, эцэг эхийн оролцоо, хувийн хэвшлийн байгууллагын хүч, төсөл хөтөлбөрүүдэд хандаж орчныг бүрдүүлэх талаар ажиллахын зэрэгцээ хөрөнгө мөнгө бага шаардах, өөрсдийн хүч бололцоо хүрэх ажлуудыг хойш тавилгүйгээр санаачлан хийж эхлээрэй. Үүний тулд гарааны үнэлгээгээ хийх нь зүйтэй.
- Хүүхдийн байгууллагын болон эцэг эх, багш нарын зөвлөл тогтмол, графикийн дагуу ажиглах

Ажиглалтаа тэмдэглэх

- Эрүүл ахуйн судалгаа хийх талаар тайбарласнаар итгэлцэл бий болж оролцогч үнэн

- бодит мэдээлэл өгөх болно. Ингэснээр эрүүл ахуйн дадлыг үнэлэх боломжтой.
- Сайн бэлтгэж, боловсруулсан асуултаар эрүүл ахуйн мэдлэг, чадвар, дадлын ярилцлага, асуумж авна.
 - Хүн амын эрүүл ахуйн дадал, зан үйлийг хувьчилсан ярилцлагын аргаар илрүүлж, зорилтот бүлгийн хэрэгцээг тодорхойлдог. Энэхүү судалгааг явуулснаар хүүхдийн дундах эрүүл ахуйн буруу дадал хэвшлийн шалтгааныг мэдэж нөлөөлж буй хүчин зүйлийг илрүүлж болдог. Ингэснээрээ эрүүл ахуйн ямар мэдээлэл хүргэх, буруу дадлыг өөрчлөх ямар арга замууд байгааг тодорхойлж, ямар арга хэмжээ зохиохыг төлөвлөнө.
 - Үдийн цай хөтөлбөрөөр сурагчдын гар угаах, шүдээ цэвэрлэх, хоггүй цэвэр орчин бүрдүүлэхэд сургуулийн орон тооны зөвлөлөөр хяналт тавиулах.
 - Эцэг эхчүүд өөрийн хүүхдийнхээ сургууль, цэцэрлэгээс олж авсан мэдлэгээ хэрхэн хэрэгжүүлж буйд үнэлгээ өгдөг учраас сургууль, цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан өдөр тутмын гар угаах, зөв хооллох, шүдээ цэвэрлэх зэрэг зан үйлд хяналт тавиулах.
 - Сургууль, цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөл нь ямар нэг үйл ажиллагааг зохион байгуулах санаачлага сайтай байдаг учраас энэ боломжоо ашиглан тэмдэглэлт өдрүүдээр сургууль, цэцэрлэг дээр ирж хүүхдийн зан үйлийн өөрчлөлтөд хяналт тавих өдөр болгох.
 - Нийт хүүхдийн эрүүл ахуйн дадалд бүгд жигд шаардлага, хяналт тавьж ажиллах нь сургуулийн эмч, багш, ажилчдын ажлын нэг үзүүлэлт болсноор эрүүл мэндээ хамгаалахад чухал алхам болно.
 - Сургууль, цэцэрлэг дээр хүүхдүүд бие биенийхээ гараа савандаж угаах, ариун цэврийн байгууламжаа зөв ашиглах, шүдээ угаах, хогоо хогийн саванд хийх, ус тогтмол уух зэрэгт хяналт тавьж, клубын идэвхтэй үйл ажиллагаагаар үнэлгээ хийвэл үр дүнтэй.



Сайн туршлага:

Японы сургуулийн багш нар хичээлийн жилийн эхнээс хүүхэд бүрийн зан үйлд ажиглалт хийж, өөрчлөлтийг дүгнэн түүнийг тусгай дэвтэрт тэмдэглэдэг байна.

Эй Си Эй (АСҒ) Монгол олон улсын байгууллага нь сургуулийн хүүхдийн зан үйлийн судалгааг хэд хэдэн аргаар сургуулиуд дээр хийж, Судалгааныхаа аргачлал асуумжийг гарын авлага болгон гаргасан байна.

(Сурагчдын мэдлэг, хандлага, зан үйлийн өөрчлөлтөнд үнэлгээ хийх арга зүй, асуумжийг энэхүү гарын авлагын Хавсралт-3 аас ашиглана уу)

Шаардлага: Сургуулийн дотуур байрын нэмэлт шаардлага

- Жендерийн болон нөхөн үржихүйн асуудал нь хичээлээс гадуурхи сургалтын хэсэг байх.
- Хүүхдэд эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа явуулах болон үйлчилгээ үзүүлэх өрөөтэй байх.
- Сургалтад хамрагдсан ажилтан өсвөр насны охид, хөвгүүдэд бие бялдрын өсөлт хөгжил, бие махбодийн өөрчлөлтийн талаар зөвлөгөө өгдөг байх.
- Охид сарын тэмдгийн хуанли хөтлөх, ариун цэврийг сахих талаар зөвлөж, дэмждэг байх.

Тайлбар: Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдарч буй сурагчдыг багаас нь эрүүл ахуйн зөв дадал, хэвшилд сургахад анхаарах нь туйлын чухал юм. 12 жилийн турш жилийн 270 хоног дотуур байранд амьдарч сурч буй сурагчдын хувьд сургуулийн удирдлага, багш, байрын багшийн оролцоо, дэмжлэгтэйгээр энэ чиглэлийн мэдлэг, мэдээлэл, дадал хэвшилтэй болно.

Зөвлөмж



- Дотуур байрын багшийг хүүхдийн хөгжлийн онцлог, гар, шүд угаах болон ариун цэврийн байгууламжийг ашиглах, нөхөн үржихүйн эрүүл мэнд, охид хөвгүүдийн хувийн эрүүл ахуйн талаарх сургалтад хамруулаарай.
- Хүүхдэд эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа явуулах болон үйлчилгээ үзүүлэх өрөөтэй байгуулж, тогтмол ажиллуулахад анхаарч, бүх талын дэмжлэг үзүүлэх
- Охид сарын тэмдгийн хуанли хөтлөх, ариун цэврийг сахих талаар зөвлөж, дэмжих



Хэрэгжүүлэх арга зам

Норм, шаардлагыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гаргаж буй энэхүү гарын авлагын агуулгаар цэцэрлэг, сургуулийн нийт багш, ажилтныг оролцуулан сургалт зохион байгуулж, хүүхдэд эзэмшүүлэх дадал хэвшлийн талаар ажилтан бүр мэдэж, тэдэнд зааж зөвлөж байх талаар үүрэг даалгавар өгч, үр дүнг тооцож ажиллаарай. Мөн анги удирдсан багш нар эцэг эхийн хурлын үеэр өгдөг сургалт мэдээллийн хэсгийг энэ чиглэл рүү анхаарч, эцэг эх, асран хамгаалагч нар хүүхэддээ өөрийн биеэр үлгэрлэхийн чухлыг ойлгуулж, тэдэнд зааж өгвөл үр дүнтэй байх болно.

Ерөнхий боловсролын сургууль, дотуур байранд эрүүл мэндийн сургалтын өрөөг байгуулна. Энэ танхимд сургуулийн эмч юм уу, эсвэл ус, ариун цэвэр эрүүл ахуйн боловсрол хариуцсан ажилтныг тодорхой хуваарийн дагуу сурагчдад, ялангуяа өсвөр насны охид, хөвгүүдэд бие бялдрын өсөлт хөгжил, бие махбодийн өөрчлөлтийн талаар мэдээлэл, сургалт явуулах боломжийг бүрдүүлж ажиллавал үр дүнтэй юм.

Эрүүл мэндийн сургалтын өрөөг байгуулахдаа дараах зүйлсийг анхаараарай.

- Зай талбайн хувьд бүлгээр болон ганцаарчлан сургалт явуулах, зөвлөгөө өгөх боломжтой байх
- Самбар, ширээ сандалтай байх
- Хэрэгцээт ном товхимол, гарын авлагаар хангах
- Мэдээллийн самбар(байнга шинэчилж байх боломжтой байдлаар хийсэн)
- Сургалтын техник хэрэгсэл, телевиз, компьютер(сургалтын ямар ч арга хэрэгслийг ашиглах боломжтой)

- Бичиг хэрэгсэлийн материал (бичгийн цаас, шохой, самбарын үзэг, өнгийн харандаа г.м.)
- Ус буцалгагч, цайны хэрэгсэл(нөхөрсөг уур амьсгал бүрдүүлэх, алжаал тайлах)
- Эмнэлгийн анхан шатны тусламжийн хэрэгсэлтэй цүнх
- Охидын ариун цэврийн хэрэгсэл

Дотуур байрын охидод сургалт явуулахдаа дараах зөвлөмжийг ашиглаарай.

Сарын тэмдэг гэж юу вэ?

Шилжилтийн нас гэдэг нь 10-19 насны хооронд явагддаг. Энэ үед бэлгийн дааврын нөлөөгөөр хөх ургах, ташаа өргөсөх, суга умдагны үс ургах зэрэг бие махбодийн болон сэтгэл зүйн олон өөрчлөлт гардгийн нэг нь охидод анхны сарын тэмдэг ирэх үзэгдэл юм.

Тодорхой хугацааны мөчлөгтэйгээр умайн салст давхарга ховхрон үтрээгээр дамжин гадагшлах үзэгдлийг сарын тэмдэг ирэх гэнэ.

Хэрвээ сарын тэмдгийн талаар мэддэггүй бол анхны сарын тэмдэг ирэхэд өсвөр насны охидууд айж сандрах, ичих, балмагдах, түүнийгээ нуух тохиолдол гардаг. Охидод анхны сарын тэмдэг яг хэзээ, ямар үед ирэхийг хэн ч хэлж мэдэхгүй. Тэднийг унтаж байхад, эсвэл сэрүүн байхад, магадгүй гэртээ эсвэл сургууль дээрээ байхад ч тохиолдож болно.

Мөн сарын тэмдэг ирэх үед охидууд маань хүмүүс мэдчих вий, эвгүй үнэр гарах вий, хувцас маань цус болчих вий гэсэн айдастай байдаг. Энэ үед хэрхэн биеэ авч явах талаар ээж эгч, найз нөхөд, багш гээд өөрийн дотны хэн нэгэнтэй ярилцах, ном сонин уншиж зөв мэдээлэл мэдлэгтэй байх нь эдгээр асуудлыг эерэгээр шийдэхэд туслана.

Сарын тэмдэг ирэх нь охидын бие махбодид тодорхой мөчлөгтэй явагддаг нарийн үйл явцын гаднах илрэл бөгөөд охид биологийн хувьд хүүхэд төрүүлэх чадвартай болсныг илтгэнэ. Энэ үеэс эхлэн охид

- Сарын тэмдэгтэй холбоотой асуудлуудыг даван туулах
- Урьд өмнө хийж байгаагүй шинэ хэвшил, ариун цэвэр сахих
- Нөхөн үржихүйн талаар зөв ойлголт мэдлэгтэй байх зэрэг хувь хүний амьдралдаа хэвшүүлэх цоо шинэ дадал хэвшлийг төлөвлүүлж эхлэх хариуцлагатай үе эхэлдэгийг анхаарах хэрэгтэй.

•

Сарын тэмдэг ирсэн үед мөрдөх эрүүл ахуйн зөвлөмж

Анхны сарын тэмдэг ирснээс хойш 1-2 жилийн хугацаанд сарын тэмдгийн мөчлөгийн хугацаа тогтмол биш байдаг нь хэвийн үзэгдэл юм. Сарын тэмдэг ирсэн үеэс охид бүр хуанли хөтөлж сурах нь сарын тэмдгийн мөчлөгөө тогтоон, жирэмслэлтээс сэргийлэхэд тустай. Түүнчлэн дараагийн сарын тэмдэг ирэх өдрийг баримжаалж байвал ариун цэврийн хэрэглэлээ цүнхэндээ бэлэн авч явах боломжтой болж улмаар эвгүй байдалд орохоос сэргийлж чадна гэсэн үг юм.

Сарын тэмдгийн үед нэг тал нь ус нэвтрүүлдэггүй, үтрээнээс гарах цусыг шингээх зориулалтай, хүний биед харшил үүсгэхгүй, хөвөн зөөлөн материалаар хийгдсэн тусгай ариун цэврийн хэрэглэлийг хэрэглэвэл зохимжтой. Сарын тэмдгийн үед гарч байгаа цусны хэмжээ, үргэлжлэх хугацаанаас хамаарч ариун цэврийн хэрэглэлийн төрөл, нимгэн зузааныг тохируулна.

Цус хир гарч байгаагаас шалтгаалан өдөрт хэд хэдэн удаа солих шаардлагатай байдаг. Цус нь нян үржих таатай нөхцөл болох мөн эвгүй үнэр гарах учраас ариун цэврийн хэрэглэлийг наад зах нь 3-4 цаг тутам солиорой. Хэрвээ дотуур хувцсан дээр цусны толбо үүссэн бол хүйтэн усаар савандаж угаагаарай.

Хэрэглэсэн ариун цэврийн хэрэглэлээ жорлонгийн суултуурын хоолой руу битгий хаяарай. Цаасанд боож хогийн сав руу хийгээрэй. Ахуйн гаралтай хог хаягдлын тухайлбал хүүхдийн живхний хөрсөн дэх задрал 100 жилээр хэмжигддэг учраас та модон жорлонгийн нүхэнд хэрэглэсэн ариун цэврийн хэрэглэлээ хийлгүй хогийн саванд боож хаяарай. Ариун цэврийн хэрэглэлээ сольсон тохиолдол бүрийн дараа гараа угаахаа бүү мартаарай. Сарын тэмдгийн үед бэлгийн ариун цэврийг сайтар сахих нь чухал. Илүү ойр ойрхон шүршүүрт орох ба өдөртөө 2-оос багагүй удаа гадна бэлэг эрхтнээ бүлээн усаар урдаас хойш чиглэлтэй угааж байх хэрэгтэй

Анхны сарын тэмдэг ирж буй охидод доорх зөвлөгөөг өгөөрэй.

- Битгий айж сандраарай. Энэ бол эмэгтэй хүн бүрт тохиолддог хэвийн үзэгдэл бөгөөд чиний амьдралын туршид ирэх олон сарын тэмдгийн зөвхөн эхнийх нь юм шүү.
- Сарын тэмдгийн талаар ээж, эгч болон эмэгтэй найз, багш нартайгаа ярилцаж зөвлөгөө аваарай
- Хэрвээ сургууль дээрээ байвал эмэгтэй багш, найздаа хэлж тусламж хүсээрэй.
- Өөрөөрөө бахархаарай. Сарын тэмдэг ирэх нь чамайг эрүүл өсөж торниж, эмэгтэй хүн болж байгааг чинь илтгэж байна.

Сарын тэмдэг ирэх үед хувийн ариун цэвэр сахиагүйгээс үүсэх эрсдэл

Сарын тэмдэг ирэх нь өвчин биш, эмэгтэй хүн бүрт тохиолддог, хэвийн үзэгдэл. Ийм учраас сарын тэмдэг ирсэн өдрүүдэд ямар нэгэн онцгой дэглэм сахих шаардлагагүй, өдөр тутмын амьдралын дэглэмээ хэвээр үргэлжлүүлж болно. Сарын тэмдэг ирсэн үед умайн хүзүү нээгдэн, умайн салст давхарга ховхрон гарч байгаа тул салстын бүрэн бүтэн байдал алдагдсан, өгсөх замаар нян орох боломжтойгоос гадна үтрээнээс гарч буй цус нь нян үржих таатай нөхцөл болдог. Ийм учраас сарын тэмдэг ирсэн үед хувийн ариун цэврийг сайтар сахих нь чухал. Хэдийгээр сарын тэмдэг ирэх нь өвчин биш хэдий ч хувийн ариун цэврийг сахиагүйгээс өвчин үүсч болно.

Тухайлбал:

- Бие зассаны дараа бэлэг эрхтэнийг хойноос урагш чиглэлд арчих нь гэдэсний савханцар зэрэг хошног орчмын нянг үтрээнд оруулж үрэвсэл үүсгэнэ.
- Үтрээний орчин өөрчлөгдсөнөөс үтрээний мөөгөнцөр үүсч болно.
- Тампоныг солилгүй удсанаас нян үржиж хордлого дайрлагын хам шинж үүсч амь насанд аюул учрах эрсдэлтэй.
- Сарын тэмдгийн үед хамгаалалтгүй бэлгийн хавьталд орох нь ХДХВ, Гепатитийн В вирусийн халдвар авах эрсдэлийг нэмэгдүүлнэ. Учир нь үрийн шингэн, үтрээний шүүрэл зэрэг биеийн бусад шингэнтэй харьцуулбал цусанд ХДХВ, ГВВ их хэмжээгээр агуулагддаг байна.

БҮЛЭГ

IV



**ГАЛ ТОГОО БОЛОН ХООЛ ХҮНС БОЛОВСРУУЛАХАД
ТАВИГДАХ ШААРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ**

Шаардлага: Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн хүлээн авах хэсэг, төмс, хүнсний ногооны агуулах, хуурай хүнсний агуулах, хөргөгч, хөлдөөгчний өрөө /агуулах/-тэй байна.

Тайлбар: Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын агуулахыг төрөлжүүлэх нь хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах шимт бодис, чийгшлийг хадгалах зорилготой.

Зөвлөмж



- Хүнсний түүхий эд хүлээн авах хэсэгтэй байна.
- Төмс, хүнсний ногооны агуулахтай байна.
- Хуурай хүнсний агуулахтай байна.
- Хөргөгч, хөлдөөгчний өрөөтэй байна.
- Дээрх агуулахын өрөөнд агааржуулалтын системийг байршуулж болно.
- Хүлээж авах хэсэг дээр бүтээгдэхүүнийг шалгаж байгаа нь:



Хэрэгжүүлэх арга зам

- Энэ хэсэг нь зөвхөн хүнсний бүтээгдэхүүн оруулах зориулалттайгаар барилга байгууламжийн ард байрлах хаалганы орох хэсэгт байрлана. Зориулалтын гал тогоотой газарт энэ хэсэг байгаа тул үүнийг зориулалтаар нь ашиглах, байхгүй тохиолдолд энэхүү хэсгийг агуулахад ойрхон байхаар зохицуулах.
- Төмс, хүнсний ногоог хуурай хүнсний өрөөнд хадгалж болохгүй. Иймээс төмс, хүнсний ногоо татан авах графикийг зохицуулах замаар шийдвэрлэх ба цементэн шалтай, мод, сеткен тавиур байрлуулсан, агаарын температур 0 0C-ын хэмтэй байна. Энэ өрөөнд заавал температур хэмжигчийг байрлуулаарай.
- Угааж цэвэрлэхэд хялбар шал, ханатай, шаталсан тавиур байрлуулсан, агаарын температур +4.50C-+210C хэмийн хооронд хэлбэлзэх ба заавал температур хэмжигчийг байрлуулаарай. Хүнсний бүтээгдэхүүний тавиур нь шалнаас 15.5-20.5 см, хананаас 15.5 см-ийн зайд байрлах бөгөөд мод, нержин материалаар хийгдсэн байж болно. Өрөөний зай талбайд тохируулан хэдэн ч шаталсан тавиурыг хийж болно. Мөн гурил, будаа, элсэн чихэр зэрэг хуурай хүнсийг хадгалах сав нь зориулалтын тэмдэг тэмдэглэгээтэй байна.
- Хөргөгч хөлдөөгчийг жимс, жимсгэнэ, түргэн гэмтэх хүнсний бүтээгдэхүүн, мах, сүү цагаан идээний гэсэн байдлаар ангилна. Дундаа тасалгаатай хөргөгч, хөлдөөгчний тасалгааг ангилан нэг талд нь сүү, цагаан идээ, нөгөө талд нь жимс, жимсгэнийг хадгалж болно. 4 хаалгатай шкафан хөргөгчтэй бол хаалга тус бүрийг ангилан, температурыг тохируулан хэрэглэнэ.
- Агуулахын агааржуулалтын систем нь уур гаргагч тоног төхөөрөмжийн агааржуулалтын системээс тусдаа тохируулгатай байна.



Зураг 1 Бэлтгэлийн өрөө
(Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 58-р сургууль)

Шаардлага: Бэлтгэлийн өрөө /хэсэг/, халуун хоол боловсруулах өрөө /хэсэг/, гурилан бүтээгдэхүүнээр үйлчилдэг бол нарийн боовны өрөө /хэсэг/, халуун хоол олгох хэсэгтэй, технологийн урсгал дамжлагыг баримталсан зориулалтын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх бөгөөд багаж хэрэгсэл, сав суулгыг зориулалтын угаалгын шингэнээр угааж ариутгана.

Тайлбар: Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын хоол боловсруулах хэсэг нь технологийн урсгал шугам, горимыг чанд баримтлах, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сав суулгыг зориулалтын угаалгын шингэнээр угааж ариутгах нь хоолноос шалтгаалсан хордлого, эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэгддэг.

Хоол хүнсийг бэлтгэх боловсруулах явцдаа бээлий өмсөж хэвшээрэй



Зураг 2 Хоол хүнсий бээлий

Зөвлөмж



Зураг 3 Хоолны дээж авсан байдал.

(Булган аймгийн Дашинчилэн сумын сургууль)

-Хүчин чадалдаа хүрэлцэхүйц бүрэн ажиллагаатай зориулалтын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.



Хэрэгжүүлэх арга зам

- Бээлийг хэрэглэхийн өмнө бүрэн бүтэн байдлыг шалгана. Хэрэглэж байгаа бээлийг ариун цэврийн шаардлага хангасан нөхцөлд /бохирдохоос хамгаална/ хадгална.
- Бээлийний материал нь хүнстэй харьцахад тохиромжтой, аюулгүй, чанартай байх ба бээлийг бохирдох бүрд сольж байх шаардлагатай.
- Бээлий хэрэглэснээр ажилчдыг гар угаахаас бүр мөсөн чөлөөлж байгаа хэрэг биш бөгөөд хүнстэй харьцагсдыг эрүүл ахуйн шаардлагын дагуу хоол, хүнсий бүтээгдэхүүнтэй зөв харьцах боломжийг бүрдүүлнэ.
- Цоорхой бээлий хэрэглэхийг хориглоно.
- Бэлтгэлийн өрөө /хэсэг/ нь түүхий хүнсий бүтээгдэхүүнийг шинж чанар, төрөл зүйлээр ангилан /махны, ногооны, гурилны гэх мэтээр/ бэлтгэх юм. Бэлтгэлийн хэсэгт бүхий л сав суулга, хутга хэрэглэгдэхүүнийг өнгөөр болон нэр төрлөөр ангилан хэрэглэх нь зүйтэй. Үүнд мах, ногооны хутга, мах, ногооны машин, мах ногооны ширээ, сав, суулга гэх мэт.
- Халуун хоол боловсруулах өрөө /хэсэг/ нь гал тогооны хамгийн чухал хэсэг юм. Энэ

хэсэг бэлтгэлд хийгдсэн хүнсний бүтээгдэхүүн жинхэнэ хоол болон гардаг учир маш нарийн зохион байгуулалт, дараалалтай байх ёстой. Үүнийг технологийн урсгал шугам гэнэ.

- Технологийн урсгал шугам нь өөр хоорондоо огтлолцохгүй байх тойрог урсгалаар явагдах бөгөөд хэсгийн болон өрөөний зохион байгуулалттай байсан ч урсгал шугам давхцахгүй, огтлолцохгүй байх ёстой.
- Хүнсний бүтээгдэхүүнийг бэлтгэх, чанах, халаах, хөргөх, хөлдөөж хадгалах зориулалтаар ашиглах тоног төхөөрөмж нь шаардлагатай хэмд аль болох түргэн хүргэх, хэмээ тогтвортой барих, дулааны хэмийг хянах тохируулгатай, хийц бүтэц нь хүнсний аюулгүй байдлын шаардлагад нийцсэн, зориулалтын байвал зохино.

Цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх дараалал:

Үе шат	Үйлдэл
I дараалал	Цэвэрлэх: Том хэмжээтэй хоолны үлдэгдэл цэвэрлэх
II дараалал	Нүдэнд ил харагдах бохирдлыг хусах, арилгах
III дараалал	Эхний угаагуурт угаана. +43°с ба түүнээс дээш хэмийн халуун бүлээн усаар сойз, үрэгч, угаагч бодис ашиглан угаана.
IV дараалал	Хоёрдахь угаагуурт угаана. Химийн болон халууны халдваргүйтгэл хийнэ.
V дараалал	Гуравдугаар угаагуурт угаана. Цэвэр усаар сайтар зайлж угаана.
VI дараалал	Хатааж, хадгална.




Зөвлөмж: Гал тогоонд байгаа хэрэгслүүдийг эхний ээлжинд ангилан хэрэглээрэй




Зураг 4 Хоолны сав суулга хэрэгсэл

Зураг 5 Технологийн урсгал шугам (Нэг урсгалтай)




Зураг 6 Технологийн урсгал шугам (Хоёр урсгалтай)




Халуун хоол боловсруулах өрөө /хэсэг/- нд технологийн урсгал шугам зөв баримталсан байх. /Зураг 5,6 харна уу/

Зураг 7



Зураг 8



Шаардлага: Ажилчид хувцас солих тусдаа өрөө, ариун цэврийн болон шүршүүрийн өрөөтэй байна.	
Тайлбар: Хоолны газрын ажилчид нь бусад ажилчдаас тусдаа хувцас солих өрөө, ариун цэврийн болон шүршүүрийн өрөөтэй байх нь эрүүл ахуйн халдвар хамгаалалыг хэрэгжүүлэх чухал шийдэл юм.	
 <p>Зөвлөмж</p>	Ажилчид хувцас солих тусдаа өрөө, ариун цэврийн болон шүршүүрийн өрөөтэй байна




Хэрэгжүүлэх арга зам

Хоолны газрын ажилчдын хувцас солих, усанд орох, амрах өрөө нь хүрэлцэхүйц хэмжээтэй байх бөгөөд хаалга үүд нь үйлдвэрлэл явуулдаг цех, тасаг руу онгойдоггүй, агаарын урсгал нь шууд нэвтрэхээргүй байхаар зохион байгуулагдсан байна.

-Ажилчдын хувцас солих өрөө нь хувцасны шкаф /гадуур болон ажлын хувцас хийх зориулалт бүхий 3-н тасалгаатай эсвэл 2 хаалгатай байна/ , сандал болон ширээ /хувцас индүүдэх/, толь зэргийг байрлуулсан байна.

-Бие засах газар нь: Битүү ханатай, хаалга нь өндөр, нээж, хаахад хялбар хийцтэй, зориулалтын угаалтуур, хогийн сав, халдваргүйтгэлийн бодис, саван, нэг удаагийн цаасан алчуур, халуун, хүйтэн устай, халдваргүйтгэлийн бодис, уусмал, гар арчих, хатаах, иж бүрдлүүдээр хангагдсан байна. Бие засах газарт орсны дараа гараа тогтмол угааж, халдваргүйжүүлж байхыг анхааруулсан санамж байрлуулсан байна. Хаалганы гадна хормогч өлгөх бүхий өлгүүр байрлуулна.

-Шүршүүрийн өрөө нь усанд орох зориулалт бүхий босоо шүршүүрийг байрлуулсан, угааж цэвэрлэхэд хялбар, агааржуулалтын системтэй байна

Шаардлага: Гал тогооны өрөөний шал , хана, таазыг ус нэвтэрдэггүй, бат бөх, тэгш гөлгөр гадаргуутай, өнгө үзэмж сайтай, цэвэрлэхэд хялбар, сайн чанарын материалаар хийх	
Тайлбар: Барилгын дотоод бүтэц, тоноглол нь бохирдолтын эрсдэлийг багасгах, сэргийлэх, засвар үйлчилгээ, цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийхэд хялбар, тохиромжтой, хүнстэй хүрэлцэх эд зүйлс, аливаа гадаргуу нь зориулалтын материалаар хийгдсэн, байрны дулааны хэм, чийглэг болон бусад хүчин зүйлсийг хянаж тохируулга хийх боломжтойгоор тоноглогдон, төхөөрөмжлөгдсөн улмаар хортон шавьж, мэрэгчид үл нэвтрэх, үүрлэн орогнох, үржихээс сэргийлэгдсэн байна..	
 <p>Зөвлөмж</p>	Гал тогооны өрөөний шал , хана, таазыг ус нэвтэрдэггүй, бат бөх, тэгш гөлгөр гадаргуутай, өнгө үзэмж сайтай, цэвэрлэхэд хялбар, сайн чанарын материалаар хийсэн байх



Хэрэгжүүлэх арга зам

Барилга байгууламж нь хортон шавьж, амьтан орж үүрлэх боломжгүй, утаа, тоос, шороо зэрэг орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, эсвэл бохирдуулахгүй байх нөхцлийг хангасан хийц загвартай байна. Хүнсний үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар өөрчлөн засварласан барилга байгууламж нь бүтэц зохион байгуулалт, хийц нь эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

-Шал: ус,чийгэнд тэсвэртэй, ус нэвтэрч шингэдэггүй, угааж халдваргүйжүүлэхэд хялбар, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй, хальтирч гулсахгүй материалаар зай завсаргүй, нягт хийгдсэн байна. Ус ихтэй газарт шалны аль нэг талыг хэвгий хийж, бохир ус урсаж бохирын системд ороход зориулагдсан ховил цооногтой байна.

-Хана: усанд тэсвэртэй, ус чийг шингээдэггүй, угааж цэвэрлэхэд тохиромжтой, материалаар хийх ба цайвар цагаан өнгийн будгаар будаж өнгөлсөн, шавьж, мэрэгч нэвтэрч, үржихээс хамгаалагдсан байна. Ханын өндөр нь үйлдвэрийн үйл ажиллагаанд тохирсон, зай завсаргүй, тэгш гөлгөр байна.

- Тааз: Тоос шороо, уур үл хуримтлагдах, хуурч унагаахгүйгээр өнгөлөгдсөн, шууд буюу шууд бус замаар хүнс ба түүхий эдийг бохирдуулахааргүй, хөгц, мөөгөнцөр үүсэхээргүй байх, угааж цэвэрлэх нөхцлийг бүрдүүлсэн байна.


-Цонх, салхивч: тоос шороо, бохирдлыг зайлуулах боломжтой, шавьж мэрэгч нэвтрэхээс хамгаалагдсан тортой, зай, завсаргүй хаагддаг, угааж цэвэрлэхэд хялбар, түгжээтэй байна. Цонхны дотор талын тавцанг тавиурын зориулалтаар ашиглахаас сэргийлж налуу хийнэ. Эсвэл ховил гаргана.

-Хаалга: гадаргуу нь гөлгөр, тэгш, чийг татдаггүй, ямар нэгэн зүйл нэвтрэхгүй, цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх боломжтой, түгжээтэй байна. Шаардлагатай газарт өөрөө /завсаргүй/ хаагддаг хаалгатай байна.

- Хүнс бэлтгэх, боловсруулах, боож савлах цех хэсэг / газар /-үүдийн хана, шал, таазны хоорондох булангууд мохоо байх бөгөөд сайн бэхлэгдсэн байна.

Шаардлага: Гал тогооны өрөө тасалгаанд агааржуулагч, тоног төхөөрөмж бүрд агаар сэлгэлтийн систем байрлуулах бөгөөд гал унтраах хэрэгслүүдийг нүдэнд ил харагдах газарт байрлуулах.

Тайлбар: Агаар сэлгэлтийн төхөөрөмж нь илүүдэл дулаан, уур чийг, тоос шороо хуримтлагдах, тархахаас урьдчилан сэргийлж, ажлын байрын эрүүл ахуйн нөхцлийг хангана.

 <p>Зөвлөмж</p>	<p>Гал тогооны өрөө тасалгаанд агааржуулагч, тоног төхөөрөмж бүрд агаар сэлгэлтийн систем байрлуулах бөгөөд гал унтраах хэрэгслүүдийг нүдэнд ил харагдах газарт байрлуулах.</p> <p>-Агааржуулалтын механик системийг үйлдвэрлэлийн байрны эзэлхүүн, хүчин чадал, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шаардлагатай агаар сэлгэлтийг тооцсоны үндсэн дээр зохих хүчин чадалтай агаар сэлгэлтийн төхөөрөмжийг шаардлагатай хэсгүүдэд байршуулна.</p> <p>Агааржуулалтын систем нь агаарын урсгал цэвэр хэсгээс бохирдолттой хэсэг рүү байх чиглэлтэйгээр тоноглогдсон байна.</p>
---	--



Хэрэгжүүлэх арга зам

- Гал тогооны цонх, салхивч нь бохир цугларахааргүй, онгорхой үед шавж, хорхой орохоос сэргийлсэн хамгаалалтын тортой байх бөгөөд салгаж авч цэвэрлэхэд хялбар байдлаар хийгдсэн байна. Цонхны дотор талын тавцанг тавиур байдлаар ашиглаж болохгүй. Гал тогоо нь хүчин чадалдаа тохируулан агаар сэлгэлтийн төхөөрөмжийг суурилуулна. Агааржуулалтын хоолой нь зэвэрдэггүй материалаар хийгдсэн, авч цэвэрлэхэд хялбар, хамгаалалтын тортой байна. Дулааны боловсруулалтын явцад үүсэх уур, утааны чанах дээд хэсэг буюу таазанд сорж зайлуулах төхөөрөмж хэрэгслийг байрлуулах ба байнга цэвэрлэж байна. Мөн ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцлийг “Ажлын байрны орчин, Эрүүл ахуйн шаардлага MNS 4994-2000” стандартын дагуу бүрдүүлнэ.



Зураг 9 Гал тогооны агааржуулалтын систем

Шаардлага: Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэсэг нь сайжруулсан усан хангамжтай, бохир ус зайлуулах цооногтой байх бөгөөд гадна жорлон, хог хаягдлын цэг, бохирын эх үүсвэрээс хол байгуулах

Шаардлага: Хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэх ундны цэвэр ус нь стандартын шаардлага хангасан, гүний болон тээвэрлэн зөөвөрлөж ирсэн усыг стандартад нийцүүлэн шүүлтүүрт шүүсний дараа хоол хүнсэнд хэрэглэх.

Тайлбар: Аюулгүй ундны усыг хоол хүнсэндээ хэрэглэх нь бие махбодын дархлаа хийгээд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ. Хэрвээ хоол үйлдвэрлэл үйлчилгээний хэсэг нь сайжруулсан усан хангамж буюу гүний худагтай тохиолдолд бохир ус зайлуулах цооног, болон жорлон, хог хаягдалын цэг, бохирын эх үүсвэрээс хол байрласан байна.

Зөвлөмж



Хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэх ундны цэвэр ус нь стандартын шаардлага хангасан, гүний болон тээвэрлэн зөөвөрлөж ирсэн усыг стандартад нийцүүлэн шүүлтүүрт шүүсний дараа хоол хүнсэнд хэрэглэх.



Хэрэгжүүлэх арга зам

- Цэцэрлэг, сургууль, дотуур байрын усан хангамж нь шаардлагатай даралт болон температурыг бүрдүүлэх боломж бүхий усан хангамжийн хангалттай эх үүсвэртэй байх бөгөөд усыг хадгалах, түгээх үед бохирдохоос хамгаалах бүх нөхцөл бололцоогоор бүрэн хангагдсан байна. Ундны усны дээжийг хамгийн багадаа нэг жилд хоёр удаа зайлшгүй шинжлүүлнэ. Гүний худаг болон зөөврийн ус хэрэглэдэг бол төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсоноос илүү олон давтамжтайгаар усны шинжилгээ хийлгэх шаардлагатай байдаг.

-Зөөврийн усан хангамжтай бол усыг бохирдохоос сэргийлж тагтай саваар зөөвөрлөх, ус хадгалах савыг нарны гэрэл тусахгүй сэрүүн газар байрлуулах, угааж цэвэрлэхэд хялбар зэвэрдэггүй, ус бохирдохоос хамгаалсан тусгай цорготой байх, хэрэв цоргогүй бол ус хутгах шанага нь тусдаа байх бөгөөд өлгөж хатаана.

-Ундны усыг 72 цагаас дээш хугацаагаар хадгалж болохгүй. Учир нь өвчин үүсгэх нян үржих аюултай байдаг.

Гүний худагтай бол ус хадгалах савыг хэрэглэхгүй байх.

Зураг 10



Олон жил болсон цэвэрлээгүй төмөр савыг ундны ус зөөвөрлөхөд ашиглахгүй байх

Зураг 11



Ундны усны шаардлагад нийцэхгүй байгаа тохиолдолд шүүлтүүр хэрэглэх
Булган аймгийн Дашинчилэн сумын сургуулийн гал тогооны ундны ус хадгалах сав.
Шүүлтүүрийн системийн хамт (зураг 12, 13)



Зураг 12



Зураг 13

Шаардлага: Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчдад гар бохирдох бүрт, хүүхдүүдэд хооллохын өмнө гар угаах, ариутгах орчин нөхцөлийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн бүрдүүлэх.

Тайлбар: Өвчин үүсгэгч бичил биетнүүд бохирдсон гараар л хамгийн их дамждаг учир гараа бохирдох бүрт нь угааж хэвших хэрэгтэй.

Зөвлөмж



Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчдад гар бохирдох бүрт, хүүхдүүдэд хооллохын өмнө гар угаах, ариутгах орчин нөхцөлийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн бүрдүүлэх.



Хэрэгжүүлэх арга зам

- Хоол хүнстэй харьцахын өмнө, хоол бэлтгэх явцад, бие зассаны дараа гараа заавал угаана.

Хоол үйлдвэрлэх хэсэгт хөл ажиллагаатай гар угаагуурыг суурилууснаар ажилчид гараа угаасны дараа цэвэр гараа цоргонд хүргэх шаардлагагүй болно.

-Хүүхдүүдийг хоолохын өмнө гарыг заавал угааж хэвшүүлэх хэрэгтэй.

-Хэрэв ангид хоолоо түгээдэг бол гарыг сайтар угаалган, малгай, хормогч өмсөнө.

-Гарыг бохирдох бүрт халуун бүлээн усаар, савандаж, 20 секундээс багагүй хугацаанд угаана.



Зураг 14

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 58-р сургууль, Архангай аймгийн 2-р сургууль, Булган аймгийн Дашинчилэн сумын сургуулийн гал тогооны ажилчдын гар угаагуур.



Зураг 15

Энгийн гар угаагууртай бол крантыг бохир гараар нээсэн тохиолдолд цэвэр гараар хаахгүй байхыг анхаараарай.

Шаардлага: Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын зөвшөөрөл бүхий худалдаа, үйлчилгээний байгуулагатай гэрээ хийж сав баглаа боодол дээрх үйлвэрлэгчийн нэр хаяг, үйлдвэрлэсэн он сар өдөр цаг, хадгалах хугацаа, нөхцөл зэргийг шалган авч байх.

Тайлбар: Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг барилга байгууламжийн төв хаалгаар /хүн ордог хаалга/ бус хүлээн авах зориулалт бүхий арын хаалгаар хүлээн авна.

Зөвлөмж



Хүнсний түүхий эд, шалган авч байх.



Хэрэгжүүлэх арга зам

- Тээвэрлэж ирсэн тээврийн хэрэгслийг зориулалт, цэвэр байдал, өөр хоорондоо хүнсний бүтээгдэхүүнийг бохирдохоос хамгаалж тусгаарласан эсэхийг сайтар хянах.

Түүхий эд бүтээгдэхүүнийг тээвэрлэн ирсэн ажилтан хувийн хамгаалах хувцас өмссөн эсэхийг бас хараарай /хормогч, малгай, бээлий/

Түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэн ирсэн уут, сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал, цэвэр байдал хангасан эсэхийг хянах.

Хүнсний бүтээгдэхүүний шошгоноос дараах мэдээллийг авна.

- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нэр
- Үйлдвэрлэгчийн нэр хаяг
- Хэмжээ, тоо ширхэг, бүтээгдэхүүний цувралын дугаар
- Үйлдвэрлэсэн он, сар, өдөр
- Хадгалах хугацаа, эсвэл хэрэглэж дуусах хугацаа
- Хадгалах нөхцөл
- Тэжээллэг чанар, орц, найрлага
- Хэрэглэх арга
- Гаж нөлөө, хориглох заалт
- Зураасан код зэргийг нь сайтар харна.

Эрүүл ахуйн шинжилгээний бичиг дагалдан ирэх ёстойг мартаж болохгүй. / лабораторийн шинжилгээ, гарал үүслийн гэрчилгээ/

- Хадгалах хугацаа нь хүнсний бүтээгдэхүүний шинж чанараас хамаарч харилцан адилгүй байна.
- Хадгалах горим мөн хүнсний бүтээгдэхүүний шинж чанараас хамаарч өөр өөр байна. Сүүг хөргөгчинд, махыг хөлдөөгчинд хадгална.
- Зураасан кодоор тухайн бүтээгдэхүүнийг аль улсад үйлдвэрлэсэн болохыг мэдэх боломжтой байдаг. Зураасан код нь 13 оронтой бөгөөд эхний 2-3 оронтой тоо нь үйлдвэрлэсэн улсын код, дараагийн 4-5 оронтой тоо нь үйлдвэрлэгчийн код, дараагийн 5 оронтой тоо нь бүтээгдэхүүний код, сүүлийн 1 оронтой тоо нь хяналтын код байдаг.

Жишээ: Та бүхэн түүхий эд, бүтээгдэхүүн хүлээн авах хуудсыг байгууллагын онцлогт тохируулан хэрэглэх боломжтой тул хүнсний бүтээгдэхүүний төрлөөр ангилан ашиглаарай.

Бичиг баримт

- Мал эмнэлгийн шинжилгээний бичиг
- Гарал үүслийн бичиг
- Мэргэжлийн хяналтын лабораторийн шинжилгээний бичиг
- Үйлдвэрлэсэн огноо, тамга тэмдэг

Төлөв байдал
<ul style="list-style-type: none"> ○ Тусгаарласан, уут саванд хийсэн ○ Гараар хүрэхэд хэт хатуу эсвэл хэт зөөлөн ○ Харахад салсархаг, наалдамхай эсвэл хатсан ○ Өнгө: үхрийн мах тод улаан, гахайн мах цайвар ягаан ○ Цэвэр хуурай, хагараагүй ○ Сав суулга, баглаа боодол бүрэн бүтэн, цэвэр ○ Тээвэрлэж ирсэн тээврийн хэрэгсэл цэвэр ○ Бүтээгдэхүүний хэлбэр /дарагдаагүй, гэмтээгүй/
Температур
<ul style="list-style-type: none"> ○ Шинэ мах: +5°с ба түүнээс доош хэмтэй ○ Хөлдүү мах: Температур үзэх боломжгүй хөлдүү ○ Тээвэрлэж ирсэн тээшний хэсгийн температур хадгалах өрөөний температуртай ойролцоо
Муудсан эсэх
<ul style="list-style-type: none"> ○ Өнгө өөрчлөгдөж бор ногоон, час улаан болсон ○ Хар, цагаан толбо, хонхорхой үүссэн ○ Хагарсан бохирдсон, хар толбо үүссэн ○ Муудсан үнэртэй ○ Гашилсан төлөвтэй ○ Сав баглаа боодол гэмтсэн, хагарсан, асгарсан ○ Хөгцөрсөн эсэх, хөгцөрч муудсан үнэр байгаа эсэх

Шаардлага: Хүүхдийн аманд орж байгаа бүхий л хоол хүнснээс дээж авах(чихэр, боов, хавчуургатай печень, хоол, шүүс, ундаа, цай)

Зөвлөмж



Хоол хүнснээс дээж авах
Хоолны дээжний хэмжээ ямар байх вэ?
Хоолны дээжийг хадгалах, устгах



Хэрэгжүүлэх арга зам

Бэлтгэсэн хүнсний бүтээгдэхүүнийг горим буюу технологийн картанд заасны дагуу хоол болгон гаргах бөгөөд хоол тус бүрээс дээж авах бөгөөд хүүхдийн аманд орж байгаа бүхий л хоол хүнснээс дээж авна /чихэр, боов, хавчуургатай печень, хоол, шүүс, ундаа, цай/. Хоолны дээж нь 250-500гр хүртэл байна. Ширхэгийн бүтээгдэхүүн бол хүүхдэд өгч буй хэмжээгээр дээжийг авч 48-72 цаг хадгалан устгана

Шаардлага: Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчид ажлын дүрэмт хувцас(өмсгөл, малгай, хормогч, ажлын гутал өмсөж гарын алчууртай) өмсөж, бөгж, бугуйвч, цаг зүүгээгүй, хумс ургуулууагүй, хумсны будаггүй, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд жилд хоёр удаа хамрагдах ба хэрэв халдварт өвчний нян тээгч илэрсэн тохиолдолд эрүүлжүүлэх арга хэмжээ авах, өвчин илэрвэл заавал эмчлүүлэх.

Тайлбар: Гал тогоонд ажиллах тогооч нар гүйцэтгэх үүргээсээ хамаарч өөр өөрийн ажил үүргийн хувиартай байх хэдий ч эрүүл ахуйн мэдлэгтэй байх ёстой. Хувийн ариун цэврийн зарчмыг сайтар баримтлаагүйгээс олон хүүхдийн эрүүл мэнд, амь насанд хохирол учруулна гэдгийг сайтар ухамсарлан, хувийн ариун цэврээ дээд зэргээр сахин ажиллах хэрэгтэй.

Зөвлөмж



Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчид ажлын дүрэмт хувцас (өмсгөл, малгай, хормогч, ажлын гутал өмсөж гарын алчууртай)-аа бүрэн өмсөж, бөгж, бугуйвч, цаг зүүгээгүй, хумс ургуулаагүй, хумсны будаггүй, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд жилд хоёр удаа хамрагдах ба хэрэв халдварт өвчний нян тээгч илэрсэн тохиолдолд эрүүлжүүлэх арга хэмжээ авах, өвчтэй бол эмчлүүлэх



Хэрэгжүүлэх арга зам

- Ажилчид биед тохирсон 2-оос доошгүй ээлжийн хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлтэй байна. Үүнд: өмд, цамц, хормогч, үс далдлах зориулалтын малгай, алчуур, бээлий, амны хаалт, шаахай /улавч/ багтана. Эдгээрийг зөвхөн гал тогооны хоол үйлдвэрлэх хэсэгт өмсөх бөгөөд өдөр бүр цэвэр хувцсыг сольж өмсөж хэвших хэрэгтэй. Хувцас хэрэгсэлийг гэртээ авч явахыг хориглоно. Хувцсыг өдөр бүр угааж, халдваргүйжүүлнэ.

Гал тогооны ажилтнууд нь эмчийн үзлэгт 6 сар тутамд буюу нэг жилд 2 удаа хамрагдах ёстой. Мөн бие засах, гадагш гарах зэрэгт тайлж байх нь эрүүл ахуйн зөв дадал хэвшил юм. Эрүүл мэндийн үзлэгийг урьдчилсан болон хугацаат гэсэн төрлөөр зохион байгуулж ажилтан бүрийг 100% хамруулах шаардлагатай. Нэмэлтээр ямар нэг халдварт өвчинөөр өвчилсөн болон өвчтэй хүн асарсан тохиолдолд урьдчилан сэргийлэх үзлэгт заавал хамрагдана.

-Хэрвээ та өвдсөн, ханиалгах, гэдэс гүйлгэх, бөөлжих, халуурах мөн ил шарх, сорвитой бол эмчид яаралтай үзүүлж, хоол хүнстэй харьцахгүй байх нь хэрэгтэй.

-Та яаралтай эмчид үзүүлэх болон урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсанаар бусдад хоол хүнсээр дамжих өвчин дамжуулахаас сэргийлнэ.

Шаардлага: Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэсэн багаж хэрэгсэл, сав суулгыг зориулалтын угаалгын шингэнээр угааж, ариутгах.

Зөвлөмж



-Гурван дамжлагатай угаалтуурын доод хэсэгт тос баригчийг байрлуулах шаардлагатай.



Зураг 16

Угаагуурын доор тос баригчийг суурьлуулсан байдал.



Хэрэгжүүлэх арга зам

Ажлын өдрийн төгсгөлд хүнстэй хүрэлцдэг гадаргуу болон бүх тоног төхөөрөмжийг цэвэрлэн халдваргүйжүүлснээр өвчин үүсгэгч нян үржих, хоол хүнс бохирдохоос сэргийлнэ. Хоол хүнсийг бохирдохоос сэргийлэхийн тулд бүх тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг байнга тогтмол угааж цэвэрлэн халдваргүйтгэл хийнэ. Цэвэрлэгээ халдваргүйтгэл хийсэн тухайгаа ажилтан тэмдэглэл хөтөлнө. Халуун усаар ариутгал халдваргүйтгэл хийх арга нь хүнсний цехүүдэд түгээмэл хэрэглэнэ. Машин болон эд анги нь салдаг ангиуд болон тоног төхөөрөмжийн жижиг хэсгүүдийг +80°C-дээш хэм бүхий халуун усанд тодорхой хугацаанд байлгана.

- Ариутгал /халдваргүйтгэл /-ын үр дүн нь анхны угаалга, цэвэрлэгээг бүрэн, гүйцэд хийсэн эсэх, хэрэглэж буй бодисын уусмалын концентраци, найруулалт, чанар, түүний хадгалалтаас шалтгаална. Ялангуяа хлор агуулсан бодис, уусмал хэрэглэдэг газрууд тухайн бодис, уусмалын идэвхтэй “хлор”-ын хэмжээг тодорхой хугацаанд шинжлүүлж байх шаардлагатай.

- Тос баригч нь хоолны үлдэгдэл болон тосыг өөрт хурааж угаагуурын шугам хоолой бөглөрөхөөс сэргийлэх нэн чухал ач холбогдолтой юм.

Шаардлага: Мэргэжлийн байгууллагаар улирал тутам хортон шавьж, мэрэгчийн устгал, халдваргүйжүүлэлтийн ариутгал хийлгэх

Зөвлөмж




- Барилга байгууламжийн хана, шал, таазны материал, тоног төхөөрөмжийн хүнстэй хүрэлцэх гадаргуу, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний онцлог зэргээс хамааран нян, вирусыг үхүүлэх, үржлийг нь зогсоох үйлчилгээ, тухайн бодисуудад тэсвэрлэх /чанар/ чадвар зэргийг харгалзан ариутгал, халдваргүйтгэлийн бодис, уусмал, ариутгах, халдваргүйжүүлэх аргыг зөв сонгоно.



Хэрэгжүүлэх арга зам

- Ариутгал /халдваргүйтгэл /-ын үр дүн нь анхны угаалга, цэвэрлэгээг бүрэн, гүйцэд хийсэн эсэх, хэрэглэж буй бодисын уусмалын концентраци, найруулалт, чанар, түүний хадгалалтаас шалтгаална.

Ялангуяа хлор агуулсан бодис, уусмал хэрэглэдэг газрууд тухайн бодис, уусмалын идэвхтэй “хлор”-ын хэмжээг тодорхой хугацаанд шинжлүүлж байх шаардлагатай.

Шаардлага: Хог хаягдлыг шинж чанараар нь зориулалтын таглаатай саванд ангилан цуглуулж, хогийн цооног, хог цуглуулах цэгт хаяна.	
Тайлбар: Ариун цэврийн шаардлага хангасан “цэгт” хог, хаягдлыг түр хадгалах, ангилан ялгах, цуглуулах бөгөөд тогтмол хугацаанд зайлуулна. Хог хаягдлыг цуглуулах, зайлуулах /байгууламж/ цэгийг ноёлох салхины дор, хүнсний үйлдвэр, үйлчилгээний газраас 30 метрээс доошгүй зайтай газарт сонгон байршуулна.	
Зөвлөмж 	Хог хаягдлыг шинж чанараар нь зориулалтын таглаатай саванд ангилан цуглуулж, хогийн цооног, хог цуглуулах цэгт хаяна.



Хэрэгжүүлэх арга зам

Хогийн цэгийн талбай, эргэн тойрныг цементлэсэн /асьфалдсан/ байна.






-Цементлэгдээгүй хөрстэй цэгүүдэд бол жил бүрийн 4-р сард багтаан хөрсийг нь 25-30 см-ийн гүнтэй сийрэгжүүлэн ухаж 25 хувиас доошгүй идэвхтэй гипохлорид кальци эсвэл хлорын шохойг хуурайгаар нь жигд тараан цацаж шороогоор сийрэгхэн булна. Энэ нь өвөл ичсэн ялаа, шавьжны авгалдайн өсөлтийг зогсоох хамгийн энгийн арга бөгөөд цаашид 7 хоногт 2-оос доошгүй удаа дээрх бодисуудын аль нэгийг хогийн цэгийн хөрс, талбай, сав, хэрэгсэлд жигд тараан цацна. Ялаа, шавьжны тархалт /үржил/ ихэсдэг 7-9 сард эрх бүхий байгууллагаас зөвшөөрөгдсөн бодис, уусмалыг хэрэглэх зааврын дагуу хогийн савны дотор, гадна хэсгийг шүрших замаар тураг ялаатай тэмцэнэ.

Хог, хаягдлыг ачуулж зайлуулсны дараа байгууламжийн дотор, гадна тал, сав, төхөөрөмж зэргийг сайтар цэвэрлэж, зөвшөөрөгдсөн бодис, уусмалаар нийт талбайг хамруулан халдваргүйжүүлнэ.

Мөн хоол хүнсний хаягдалыг бордоо болгон ашиглаж болно. Энэ нь байгаль орчин хийгээд эдийн засгийн ашиг тустай юм.

100 хүүхдэд үйлчлэх гал тогооны тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийн жагсаалтын мэдээлэл

/доорхи жагсаалт нь батлагдсан норм, шаардлага бус хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт байвал зохих тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн танилцуулга гэдгийг анхаараарай/

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо хэмжээ	Овор хэмжээ, мм	Багтаамж	Хүчдэл/ чадал	Зураг	Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн зориулалт, онцлог
A	B	C	D	F	L	N	
Хуурай хүнсний агуулах							
1	Шаталсан тавиур	2	1460*710*1800				Хуурай хүнсний бүтээгдэхүүн буюу лаазалсан, савласан бүтээгдэхүүнийг өрж тавихад зориулагдсан. Арчиж цэвэрлэхэд хялбар, зэвэрдэггүй нерж гадаргуутай.
2	Ачаа зөөх тэргэнцэр	1	900*592*860	300 кг			Гаднаас оруулж буй бараа материалыг зөөхөд ашиглах зориулалттай.
3	Электрон жин	1	260*287*137	30 кг	220 В		Гаднаас татан авч байгаа болон гал тогоонд өгч байгаа бүтээгдэхүүнийг жинлэх зориулалттай.
4	Гурил, будааны хутгуур	1	65*110*220, 110*180*360, 90*140*320, 135*205*400				Зориулалтын цэвэр саванд байгаа гурил, будаа, элсэн чихрийг гал тогоонд өгөхөөр жинлэхэд хутгаж авах зориулалттай.
5	Гурил, будаа, элсэн чихэр хийх хуванцар сав	6	384*360				Хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй аюулгүй байдлыг хангах үүднээс шуудайнд савласан гурил, будаа, элсэн чихрийг энэхүү хуванцар саванд хийж түр хугацаанд хадгална
A	B	C	D	F	L	N	
Хөргүүртэй агуулах							









6	Хөргөгч /1,2,4,6 хаалгатай/	1	1900*800*1830	523 л	220 В/ 60 Hz		Хөргөгч, хөлдөөгчийг нэг дор хослуулан хэрэглэх боломжтой. Хөргөгч нь +7°C ~ -3°C хүртэл хөргөнө. Хөлдөөгч нь -3°C ~ -24°C хүртэл хөлдөөх давуу талтай
	Хөлдөөгч /1,2,4,6 хаалгатай/			1120 л			
7	Термометр	2	85*95		220 В		Хөргөгчний хэмийг хянах зориулалттай электрон хэмжүүр
Мах бэлтгэлийн өрөө /хэсэг/							
8	Ажлын ширээ	1	1200*600*920	60 кг			Мах бэлтгэлийн ширээ нь зэвэрдэггүй ган төмөр буюу нерж материалаар хийгдсэн, угааж цэвэрлэхэд хялбар. Бат бөх тулгуур сайтай
9	Махны машин	1	515*300*490	300 кг/ц	380 В		Цагт 300 кг мах машиндах хүчин чадалтай, 2 төрлийн шүүртэй. Бат бөх суурьтай. Зэвэрдэггүй ган төмөр материалаар хийгдсэн
	A	B	C	D	F	L	N
10	Электрон жин	1	260*287*137	50 кг			Гаднаас ирсэн мах, махан бүтээгдэхүүнийг жинлэж хүлээн авах мөн дараагийн өдрийн хоолонд хэрэглэх махыг бэлтгэж хүлээлгэн өгөхдөө жинлэх зориулалттай
11	Гар угаалтуур /энгийн, хөл/	1	550*400*850				Гар угаалтуурын усыг гоожуулахдаа гараар биш харин хөлөөрөө крантыг удирдах гишгүүртэй нь энэхүү гар угаалтуурын онцлог оршино
12	Мах хэрчих вандан мод	1	600*400*18				Мах бэлтгэх өрөөний ажлын ширээн дээр хэрэглэнэ.

13	Хутга	1	235*2				Мах бэлтгэхэд хэрэглэнэ.
14	Сойтог	1	15.24*6.34				Мах бэлтгэлийн ширээг цэвэрлэх зориулалттай
15	Хормогч	1	640*860	M			Мах бэлтгэх үед ажлын хувцас бохирдохоос сэргийлсэн хулдаасан хормогч нь угааж цэвэрлэхэд хялбар байх
16	Хогийн сав	1	320*450*980	100 л			Хог хаягдалыг ялгаж хаях зориулалт бүхий 3 өнгийн хогийн сав
	A	B	C	D	F	L	N
Ногоо бэлтгэлийн өрөө /хэсэг/							
17	Ажлын ширээ	1	1200*600*920	60 кг			Ногоо бэлтгэлийн ширээ нь зэвэрдэггүй ган төмөр буюу нерж материалаар хийгдсэн учир угааж цэвэрлэхэд хялбар. Бат бөх тулгуур сайтай
18	2 дамжлага бүхий угаалгын ванн	1	1200*600*800				Хальсалсан ногоог угаахад хэрэглэнэ
19	Ногоо цэвэрлэгч	1		15л	220В		Төмс, лууванг усан орчинд хальслах зориулалттай. Цагт 30 кг ногоо цэвэрлэх хүчин чадалтай байх.
20	Төмс хальслагч	1	140				Цахилгаан төмс хальслагчаас үлдэгдэл хальс эсвэл бага хэмжээний төмс, лууван гэх мэт ногоог гар аргаар хальслахад хэрэглэнэ.

21	Ногоо хэрчигч	1	571*305*570		220В		7 төрлийн ир дагалдана. Төмс, хүнсний ногоог олон төрлийн хэлбэртэй хэрчинэ.
22	Байцаа хэрчигч	1	430*430*520	21.5 кг/ц	220В		Цаг болон хүний хүчийг хэмнэх давуу талтай.
23	Электрон жин	1	260*287*137	30 кг			Гаднаас ирсэн хүнсний ногоог жинлэж хүлээн авах мөн дараагийн өдрийн хоолонд хэрэглэх ногоог бэлтгэж хүлээлгэн өгөхдөө жинлэх зориулалттай
	A	B	C	D	F	L	N
24	Гар угаалтуур /энгийн, хөл/	1	550*400*850				Гар угаалтуурын усыг гоожуулахдаа гараар биш харин хөлөөрөө крантыг удирдах гишгүүртэй нь энэхүү гар угаалтуурын онцлог оршино
25	Ногоо хэрчих вандан мод	1	600*400*18				Ногоо бэлтгэх өрөөний ажлын ширээн дээр хэрэглэнэ
26	Хутга	1	235*2				Ногоо бэлтгэх буюу хэрчихэд хэрэглэнэ
27	Сойтог	1	15.24*6.34				Ногоо бэлтгэлийн ширээг цэвэрлэх зориулалттай
28	Хормогч /бэлтгэл хийх үед өмсөх хормогч халуун хоол хүүх үед өмсөх хормогч өөр өөр өнгө байна/	1	640*860	M			Ногоо хальслах / цэвэрлэх/ үед ажлын хувцас бохирдохоос сэргийлсэн хулдаасан хормогч нь угааж цэвэрлэхэд хялбар







29	Хогийн сав	1	320*450*980	100			Ногооны хог хаягдалыг ялгаж хаях зориулалт бүхий 3 өнгийн хогийн сав
	A	B	C	D	F	L	N
Халуун хоол боловсруулах өрөө /хэсэг/							
30	1-р хоолны тогоо	1	840*970*1110	60 л	380 В		Шөлтэй хоол бэлтгэх зориулалттай. Бүрэн автомат асаах, унтраах товчлууртай. Шингэн юүлэх том кранттай, давхар цамцтай, цамцанд зөвхөн ус хийдэг. Зэвэрдэггүй ган төмөр материалаар хийгдсэн
31	2-р хоолны тогоо	1	1475*905*850	70 л	380 В		Хуурга, хачир бэлтгэх зориулалттай. Цэвэрлэгээний дараа бохир ус зайлуулахаар хөдөлгөх /хазайлгах/ боломжтой. Наалддаггүй ширмэн материалаар хийгдсэн
32	Цахилгаан зуух	1	950*840*850	4 ширэмтэй	380 В		Цахилгаан зуух нь 4 ширэмтэй, шарах шүүгээтэй, зэвэрдэггүй материалаар хийгдсэн
33	Уурын жигнүүр	1	670*590*808	12 листтэй	380 В		Уурын жигнүүрийн лист болон их бие нь зэвэрдэггүй ган төмөр материалаар хийгдсэн . Угааж цэвэрлэхэд хялбар
34	Шарах шүүгээ	1	1620*880*1580	9 листтэй	380 В		Шарах шүүгээний лист болон их бие нь зэвэрдэггүй ган төмөр материалаар хийгдсэн. Угааж цэвэрлэхэд хялбар
35	Будаа агшаагч	2	4800* 3730	4 кг	220 В/ 60 Hz		Будаа агшаах сав нь зэвэрдэггүй, түлэгдэж наалдахгүй материалаар хийгдсэн. Угааж цэвэрлэхэд хялбар

	A	B	C	D	F	L	N
36	Ус буцалгагч / цэвэршүүлэгч/	1	255*482*1150/1500	90 л/ц	220 В		Ус цэвэршүүлэгч нь гүний болон төвийн шугамд шууд холбогдсон байна. Мөн цахилгаанд залгаж халуун ус гаргах боломжтой.
37	Хөргөгч	1	1260*850*1830	1045 л	220 В		Хөргөгч нь +7°C ~ -3°C хүртэл хөргөнө. Хананы наана цаанаас нь онгойдог өөрөөр хэлбэл хоёр талаас нь онгойно. 1 талдаа 4 хаалгатай нийт 8 хаалгатай. Температур тохируулагчтай
38	Термометр	1	85*95		220 В		Хөргөгчний хэмийг хянах зориулалттай электрон хэмжүүр
39	Гурил зуурагч	1	870*440*925	20 кг	220В		Гурил зуурах цахилгаан машин нь цаг хугацаа, хүн хүчийг хэмнэх ач холбогдолтой
40	Тэргэнцэр	2	ш = 630				Савтай хоолонд хэрэглэгдэх түүхий эд, бэлэн болсон халуун хоол, зөөвөрлөхөд ашиглах зориулалттай тэргэнцэр
41	Ажлын ширээ	1	1200*600*920	60 кг			Хүйтэн зууш, хачир, халуун хоол бэлтгэлийн ширээ нь зэвэрдэггүй ган төмөр буюу нерж материалаар хийгдсэн учир угааж цэвэрлэхэд хялбар. Бат бөх тулгуур сайтай
	A	B	C	D	F	L	N

42	Гар угаалтуур /энгийн, хөл/	1	550*400*850				Гар угаалтуурын усыг гоожуулахдаа гараар биш харин хөлөөрөө крантыг удирдах гишгүүртэй нь энэхүү гар угаалтуурын онцлог оршино
43	Гар ариутгагч /бэлэн болсон хоол, хүнстэй харилцах учир/	1	220*200*380				Эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах үүднээс ажилд оролцохдоо заавал гар ариутгагчаар гараа ариутгана
44	Давс хэмжигч	1					Хоолны давсны хэмжээг тодорхойлох зорулалттай
45	Хоолны дээж хадгалах сав	3	270*180*550, 850*850*400				Хоолны дээж хадгалах зориулалтын таглаатай сав нь хоолны дээжид бохир орохоос сэргийлнэ
46	Дээжний хөргөгч	1	655*800*1900	530 л	220 В/ 60 Hz		Хоолны дээж хадгалах зориулалттай хөргөгч нь шилэн хаалгатай, 3 тавиуртай
47	Дээжний сав ариутгагч	1	610*480*1300		220 В/ 60 Hz		Хоолны дээж хадгалах савыг тусгай ариутгах шүүгээнд хийж ариутгана
	A	B	C	D	F	L	N
48	Хутга	2	235*2				Хүйтэн зууш, хачир, халуун хоол бэлтгэх тогоочийн хэрэглээнд зориулагдсан
49	Вандан мод	1	600*400*18				Хүйтэн зууш, хачир, халуун хоол бэлтгэх тогоочийн хэрэглээнд зориулагдсан

50	Хоол бэлтгэлийн сав	2	260*150	3 л		Зэвэрдэггүй материалаар хийгдсэн. Угааж цэвэрлэхэд хялбар	
51	Хоол бэлтгэлийн сав	2	340*190	5 л			
52	Хоол бэлтгэлийн сав	2	410*210	10 л			
53	Хоол бэлтгэлийн дэлбэгэр сав / төмпэн/	2	ш = 290	5 л		Зэвэрдэггүй материалаар хийгдсэн. Угааж цэвэрлэхэд хялбар	
54	Хоол бэлтгэлийн дэлбэгэр сав / төмпэн/	2	ш = 465	10 л			
	A	B	C	D	F	L	N
55	Хавчаар	2					Зэвэрдэггүй материалаар хийгдсэн. Угааж цэвэрлэхэд хялбар
56	Ган шанага	1					
57	Ган шанага	1		3 л			
58	Шүүрэн шанага	1					

59	Модон хутгуур	1	333, 298, 322, 322				Угааж цэвэрлэхэд хялбар
60	Төмөр хутгуур	1	100*210				Зэвэрдэггүй материалаар хийгдсэн. Угааж цэвэрлэхэд хялбар
61	Төмөр хутгуур /сэт/	1	90*265, 130*265, 150*265				
	A	B	C	D	F	L	N
62	Хоолны аяга	150	54	ш= 117			Амархан хагардаггүй, угааж цэвэрлэхэд хялбар байх. Нөөцтэй бэлтгэх хэрэгтэй.
63	Цайны аяга	150	86	ш= 74			
64	Хоолны халбага	150					Зэвэрдэггүй материалаар хийгдсэн. Угааж цэвэрлэхэд хялбар, гарт барихад эвтэйхэн хүнд хөнгөн нь тохирсон байх. Нөөцтэй бэлтгэх.
65	Сэрээ	150	209				

66	Комплекс хоолны поднус	150	390*308*25				Зэвэрдэггүй материалаар хийгдсэн. Угааж цэвэрлэхэд хялбар байх. Нөөцтэй бэлтгэх.
	A	B	C	D	F	L	
Угаалгын өрөө /хэсэг/							
67	Ажлын ширээ (Аяга таваг ангилах, цэвэр аяга таваг тавих)	1	900*600*800, 900*700*800				Хоолны үлдэгдэл ялгах зориулалттай. Зэвэрдэггүй ган төмөр материалаар хийгдсэн. Бат бөх суурь сайтай
68	3 дамжлагат угаалгын ванн	1	1200*600*800				3 дамжлагат угаалгын ванн нь сав хэрэгсэл угаах зориулалттай бөгөөд цахилгаан доголдсон үед /аяга, таваг угаагч машин ажиллах боломжгүй/ аяга таваг угаах боломжтой. Зэвэрдэггүй ган төмөр материалаар хийгдсэн. Бат бөх суурь сайтай
69	Аяга, таваг угаагч машин	1	650*700*1340/1750	99ш	220 В		Цаг болон хүний хүчийг хэмнэх давуу талтай. Аяга, таваг угаах технологи, норм, стандартын дагуу угаана
70	Хормогч	1	640*860				Аяга, таваг, сав хэрэгсэл угаах үед ажлын хувцас бохирдохоос сэргийлсэн хулдаасан хормогч нь угааж цэвэрлэхэд хялбар
71	Сав, суулга тавих зориулалт бүхий шатаалсан тавиур	1	1460*710*1800				Угааж цэвэрлэсэн сав хэрэгслийг өрж тавихад зориулагдсан. Зэвэрдэггүй материалаар хийгдсэн. Бат бөх суурь сайтай

	A	B	C	D	F	L	N
72	Аяга таваг ариутгагч	1	1050*480*1300		220 В/ 60 Hz		Угаасан аяга, таваг болон бусад хэрэглэлийг ариутгах төхөөрөмж
73	Хутга, вандан ариутгах шүүгээ	1	1110*490*1300		220 В/ 60 Hz		Хэрэглэж дуусаад угааж цэвэрлэсэн хутга, вандан модыг зориулалтын ариутгах шүүгээнд хийж ариутгана
74	Хогийн сав	1	320*450*980	100			Хог хаягдлыг ялгаж хаях зориулалт бүхий 3 өнгийн хогийн сав
75	Шал угаагч	1		5л			Үйлдвэрлэл, үйлчилгээний хэсэгт чийгтэй цэвэрлэгээ хийх зориулалттай дугуйтай хувин. Ажилтны хөдөлмөрийг хөвчилнө
76	Бээлий	1	385*120				Шал угаах цэвэрлэхэд хэрэглэнэ
	A	B	C	D	F	L	N
Ажилчдын хувцас солих өрөө /хэсэг/							
77	Ажилчдын хувцасны шүүгээ	4	457*915*1830				Ажлын хувцас хадгалах буюу ажилтны хувийн эд зүйл хадгалах шүүгээ

78	Сандал ширээ /Сэт/	1		4 суудалтай		Ажилчдын амрах өрөөнд зориулагдсан ширээ сандал	
79	Халад ариутгах шүүгээ /хормогч ариутгаж болно/	1	1500*600*1900		220 В		Ажил дууссаны дараа ажлын хувцсыг ариутгах, сайтар угааж цэвэрлэх хэрэгтэй. Энэ нь хувцасны гадаргууд наалдсан бохирдлыг цэвэрлэх, нянг устгах зориулалттай.
80	Хормогч ариутгах шүүгээ /халад ариутгаж болно/	1	700*600*1900		220 В/ 60 Hz		Ажил дууссаны дараа ажлын хормогчийг ариутгах, сайтар угааж цэвэрлэх хэрэгтэй. Энэ нь хормогчны гадаргууд наалдсан бохирдлыг цэвэрлэх, нянг устгах зориулалттай.
81	Ажлын гутал ариутгах шүүгээ	1	700*600*1900	10 ш	221 В/ 60 Hz		Ажил дууссаны дараа ажлын гутлыг ариутгах, сайтар угааж цэвэрлэх хэрэгтэй. Энэ нь гутлын ул болон гадаргууд наалдсан бохирдлыг цэвэрлэх, нянг устгах зориулалттай.

БҮЛЭГ

V



**ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТЭД ТАВИГДАХ
НОРМ ШААРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ**

Сургууль, цэцэрлэг нь өдөр тутмын үйл ажиллагааны явцад бий болгосон хог хаягдлаа зохицуулах үүрэгтэй. Хог хаягдлыг зүй зохистой хадгалж, зайлуулаагүйгээс үүдэлтэйгээр хөрс, ус, агаар бохирдож, халдварт өвчин гарах нөхцлийг бүрдүүлж, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөргөөр нөлөөлдөг.

Шаардлага: Ариун цэврийн өрөө бүрт тагтай хогийн сав байрлуулах

Тайлбар: Хэрэглэсэн 00-н цаас, ариун цэврийн хэрэгсэл болон бусад хаягдал нь орчин тойронд эвгүй үнэр тархах, нян бактери үржих, халдвар тархаах аюултай тул ариун цэврийн өрөөнд байх хогийн савыг заавал тагтай байлгана.

Зөвлөмж



- Суултуур бүрийн дэргэд тагтай хогийн сав байрлуулах
- Гар угаагуурын хажууд таглаатай хогийн сав байрлуулах



Хэрэгжүүлэх арга зам

- Хогийн савны таг хөлөөр дарж онгойдог байх нь гараар халдвар дамжих эрсдлийг бууруулах сайн талтай
- Гар угаагуурын хажууд байрлуулах хогийн сав нь хэмжээ томтой байх(20-25л)
- Ариун цэврийн өрөөнөөс гарсан хог хаягдалыг (00 цаас, ариун цэврийн хэрэглэл) амыг нь сайтар боож битүүмжлэн сургууль цэцэрлэгийнхээ хог хадаглах түр цэгт зайлуулна.
- Хогийн савыг доторх хогийг нь суллах бүрт сайтар угааж халдваргүйжүүлнэ.

Шаардлага: Сургууль бүр хатуу хог хаягдлыг цуглуулж хаях хогийн цэгтэй байх

Тайлбар: Аливаа аж ахуйн нэгж, байгууллага нь өөрсдийн үүсгэсэн хог хаягдлаа түр цэгт хадгалж, хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, тусгай эрх авсан иргэн аж, ахуйн байгууллагатай гэрээ байгуулан зайлуулах ёстой. Хогийн цэгийг зөв байгуулж ашиглах нь хог хаягдлын хэмжээг бууруулах, хүний эрүүл, аюулгүй, цэвэр орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд маш чухал нөлөөтэй юм

Зөвлөмж



- Хог хаягдлыг анхдагч эх үүсвэр дээр нь буюу сургууль, цэцэрлэг, дотуур байранд дараах төрлүүдээр ангилж хог хаягдлын түр цэгт хадгална.
 1. Дахин ашиглах боломжтой хог хаягдал Үүнд: шил лааз, хуванцар
 2. Түргэн муудах хүнсний үлдэгдэл Үүнд: гал тогоо, хүнсний мухлагаас гарах хаягдал
 3. Энгийн хог хаягдал Үүнд: цаас, хичээлийн хэрэгсэл, ариун цэврийн өрөөнөөс гарах хаягдал зэрэг багтана.
- хог хаягдлыг зориулалтын уут саванд хийж, амсрыг битүүмжлэх
- Аюултай хог хаягдлыг зайлуулах хууль, дүрмийг мөрдөх.
- Аюултай хог хаягдал гэж хүн амьтан, ургамлыг өвчлүүлэх, гэмтээх, тэдгээрийн үр удамд хор хөнөөл учруулах болон байгаль орчны хэвийн төлөв байдалд сөрөг нөлөөтэй хортой, идэмхий, исэлдүүлэгч, шатамхай, дэлбэрэх аюултай, цацраг идэвхт, халдвартай шинж чанартай хатуу шингэн,хийн хэлбэрийн хог хаягдал юм.



Хэрэгжүүлэх арга зам

Хог хаягдал нь бүрмөсөн устаж алга болох боломжгүй хэдий ч зөв менежментийг нэвтрүүлсэнээр хогийн цэгрүү очих хэмжээг бууруулах боломжтой.

Үүнд:

Багасгах: онц шаардлагагүй болон нэг удаагийн бүтээгдэхүүнээс татгалзах.

Дахин ашиглах: Бүтээгдэхүүнийг өмнө нь ашиглаж байсан болон огт өөр зориулалтаар ашиглаж болно.

Сургууль, цэцэрлэг, дотуур байранд дараах төрлийн хог хаягдлыг ангилан хаях савыг байрлуулна.

Анги танхим болон коридор, нийтийн танхимд

1. Энгийн хог хаягдал хаях сав
2. Дахин ашиглах хог хаягдлын сав



Цайны газар, дотуур байр


1. Энгийн хог хаягдлын сав
2. Дахин ашиглах хог хаягдлын сав
3. Түргэн муудах хүнсний бүтээгдэхүүний сав
- Хогоо ангилан ялгах талаар сурагчид, багш ажилтан эцэг эхэд мэдээлэл өгөх, сургалт явуулах

Сурагчдад хог хаях хэмжээгээ багасгахыг уриалаж доорх зөвлөгөөг өгөөрэй.

- Нэг удаагийн болон бага савлагаатай бүтээгдэхүүн худалдан авахаас татгалзах
- Аль болох баглаа боодолгүй бүтээгдэхүүн худалдан авах.
- Эрчим хүчийг хэмнэдэг гэрэл чийдэн, цахилгаан бараа худалдан авах
- Даавуун тор ашиглах
- Эвдэрсэн зүйлээ засаж ашиглах
- Лааз лонхтой уух зүйл худалдан авахаас татгалзаж өөрийн уух ус цайг саванд хийж авч явж хэвших
- Хаягдал цаасыг дахин ашиглах

Аюултай хог хаягдлыг зөвхөн аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж эсхүл тогтоосон тусгай цэгт хүргүүлэх.

Аюултай хог хаягдал гэдэгт: зай, компьютер, электроникийн эд анги, мөнгөн ус агуулсан гэрэлтүүлэг, химийн бодис, эм, тариа, эмнэлгийн хог хаягдал, хортой бодисын баглаа боодол, нефть бүтээгдэхүүний хаягдал зэрэг орно.

Шаардлага: Сургуулийн хогийн цооног, хог цуглуулах цэг нь сургуулиас болон усны эх үүсвэрээс 100 метр, барилга байгууламжаас 30 метрээс доошгүй зайд байрлах ба хана, хашаагаар тусгаарлагдсан битүүмжлэл сайтай хаалттай байх	
Тайлбар: Хог хаягдал нь хөрс ус агаарыг бохирдуулж халдварт өвчин гарах нөхцлийг бүрдүүлж байдаг тул тархахгүй байхаар тусгаарлан битүүмжлэх ёстой.	
 <p>Зөвлөмж</p>	<ul style="list-style-type: none"> - Салхины чиглэлийн доод талд хогийн цэгийг байгуулна - Хогийн цэг нь усны эх үүсвэрээс 100 метрийн зайд байна. - Хогийн цэг нь барилга байгууламжаас 30 метрээс доошгүй зайд байрлана - Хогийн цэгийг хана хашаагаар тусгаарлах бөгөөд битүүмжлэл сайтай, хаалттай байна. - Хог хаягдлын цэгийг 3 тасалгаатай хийнэ. Үүнд: түргэн муудах, дахин ашиглах, бусад энгийн хог хаягдал - Талбайн хөрсийг тэгшлэн нягтруулж, цементэлсэн байх - Тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэх замтай байх - Түр цэгт хадгалж байгаа хог хаягдлыг батлагдсан хуваарийн дагуу хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллагад хүлээлгэж өгнө.



Хэрэгжүүлэх арга зам

1. Ангилан ялгасан 3 өөр төрлийн хогийг онцлогоос нь хамааран өөр өөр хугацаанд зайлуулж байна.

Түргэн муудах хүнсний бүтээгдэхүүний хогийг 3-7 хоног тутам ачуулж байна.

Ачилт бүрийн дараа гадаах хогийн цэг, дотор хогийн савнуудыг 0.5%-ийн хлорамины уусмалаар халдваргүйжүүлнэ. Хогийн цэгт шавьж, хулгана мэрэгч үүрлэж халдварт өвчин дамжихаас сэргийлж устгалын ажил хийж байх.

Дахин ашиглах хог хаягдлыг орон нутгийн хоёрдогч түүхий эд авах цэгт нийлүүлж байх. Боломжтой бол ийм төрлийн байгууллагатай гэрээ хийн тогтмол(сард 2 удаа г.м.) ачуулж байх.

Энгийн хог хаягдлыг орон нутгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, эрх бүхий байгууллагатай гэрээ хийн зайлуулж байх

Шаардлага: Хэсгийн цэвэрлэх байгууламжтай тохиолдолд цэвэрлэгдсэн ус нь үндэсний стандартын шаардлагад нийцсэн байх
Тайлбар: Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS4943:2011
Шаардлага: Бохирын цооногтой бол холбогдох дүрэм журамд заасны дагуу бохир усыг соруулан зайлуулах
Тайлбар: Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага MNS5924:2008

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1

**УС, АРИУН ЦЭВЭР, ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР
АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГУУД**

УС АРИУН ЦЭВЭР ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГУУД БОЛОН МЭДЭЭЛЭЛ АВЧ БОЛОХ ЭХ СУРВАЛЖУУД

Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагууд:

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮҮХДИЙН САН (НҮБХС)

Утас: 312183
Веб хуудас: www.un-mongolia.mn

Тэтгэлэг, төсөл, тусламжийн төрөл:

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан нь хүүхдийн төлөө байгууллага бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын бусад байгууллага, Монгол улсын засгийн газар болон Төрийн бус байгууллагуудтай хамтран эрүүл мэнд, хоол тэжээл, суурь боловсрол, ус, ариун цэвэр, эрүүл ахуй, хүүхэд хамгааллын асуудлаар ажилладаг.

ДЭЛХИЙН ЗӨН МОНГОЛ

Утас: 70155323, 70155322
Веб хуудас: www.worldvisionmongolia.org

Тэтгэлэг, төсөл, тусламжийн төрөл:

Нийгмийн тулгамдсан асуудлууд тэр дундаа эмзэг давхаргын хүүхдүүдийн эрүүл мэнд, тэдний сурч боловсрох, хөгжих асуудал, хүн амын цэвэр усны хангамж, орчны эрүүл ахуй, өрхийн эдийн засгийн чадавхийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зэрэгт урт богино хугацааны төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

ЯПОНЫ ЭСЯ-НЫ ӨВСНИЙ ҮНДЭС ХӨТӨЛБӨР

Утас: 320777, 313332
Веб хуудас: www.mn.emb-japan.go.jp

Тэтгэлэг, төсөл, тусламжийн төрөл:

Тухайн бичих төсөл нь олон түмнийг хамарсан тохиолдолд Өвсний үндэс хөтөлбөрийн хүрээнд санхүүжигдэх эрхтэй болно. Гэхдээ дараах салбаруудад онцгой анхаарал хандуулдаг. Үүнд:

- Эрүүлийг хамгаалах
- Ерөнхий боловсрол (ЕБС-ийн байрыг засварлах ба тоног төхөөрөмж нийлүүлэх)
- Ядуурлыг бууруулах
- Олон нийтийн аж байдал
- Байгаль орчин зэрэг болно

ЯПОНЫ ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САН

Утас: 329371, 29365

Веб хуудас: www.savethechildren.mnТэтгэлэг, төсөл, тусламжийн төрөл:

Сургуулийн өмнөх боловсрол

Анхан шатны боловсрол

Хүүхэд хамгаалал

ОЛОН УЛСЫН УЛААН ЗАГАЛМАЙ, УЛААН ХАВИРГАН САР ХӨДӨЛГӨӨН

Утас: 312720, 321684

Веб хуудас: www.ifrc.orgТэтгэлэг, төсөл, тусламжийн төрөл:

Энэ хөдөлгөөн нь дараах чиглэлүүдээр дэмжлэг үзүүлдэг.

- Гамшгийн менежмент
- Эрүүл мэнд ба нийгмийн халамж
- Мэдээ ба түгээлт
- Байгууллагын хөгжил

ГЕРМАНЫ ЭЛЧИН САЙДЫН ЯАМ

Утас: 323325, 323915

Веб хуудас: germanemb_ulanbator@mongol.netТэтгэлэг, төсөл, тусламжийн төрөл:

Ядуурлыг бууруулахтай холбогдолтой төслийн саналуудыг дэмжинэ. Үүнд:

Нийгмийн эмзэг бүлэг (хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өнчин хүүхэд гэх мэт)

Сургуулийн өмнөх боловсрол

Гар урлалын үйлдвэрлэл

Мэдээлэл авч болох байгууллагуудын хаяг:**Akvopedia Аквопедиа**

Web site: www.akvo.org/wiki/index.php/Main_Page

Аквопедиа нь хэн ч хянан засварлаж болох ус, ариун цэврийн нээлттэй эх үүсвэр юм. Аквопедиагийн зорилго нь ухаалаг бөгөөд хямд төсөр техникийн шийдэл болон үр дүнтэй арга замын талаарх мэдлэгээ солилцох замаар ус, ариун цэврийн нөхцөлийг сайжруулах явдал юм.

International Water and Sanitation Centre (IRC)**Олон Улсын Ус ба Ариун Цэврийн Төв**

Web site: www.irc.nl

IRC нь хөгжиж буй оронд сайжруулсан бага өртөгтэй усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн талаарх мэдлэгийн зөрүүг арилгаж, хамтрагч байгууллагуудтай хамтарсан сургалт явуулдаг. IRC олон нийтэд мэдээллийн банк болон олон талын хэрэгслүүдийг хүргэдэг. Тэд ус, ариун цэврийн 100 гаруй баримт бичгүүдээр хангахаас гадна асуулт, хариултын үйлчилгээ үзүүлдэг.

Swiss Agency for Development and Cooperation (SDC)**Хөгжил, хамтын ажиллагааны Швейцарын Агентлаг**

Web site: www.poverty.ch/safe-water.html

SDC-ийн 2008 оны Аюулгүй Усны Тогтолцоог Зах зээлд Нэвтрүүлэх нь гарчигтай баримт бичиг нь хэрэглэгч, түгээгч, үйлдвэрлэгч, борлуулагчдаас эхлээд хэрэглэгч дээрх цэвэршүүлэх төхөөрөмжийг зах зээлд нийлүүлэх сорилтууд хүртэлх олон янзын салбарт хосгүй ойлголтыг өгдөг. Үүнд зах зээлийн 5 P-ийн талаар өгүүлнэ: Product (Бүтээгдэхүүн), Price (Үнэ), Place (Байр), Promotion (Дэмжлэг) and People (Хүмүүс). Мөн түүнчлэн энэхүү баримт бичиг нь Мянганы Хөгжлийн Зорилтод хүрэх шаардлагатай түвшингүүдэд өрхийн түвшинд усыг цэвэршүүлэх түгээлтийг өсгөх зах зээл болон нийгмийн зах зээлийн холимог стратегийг дэвшүүлдэг.

United Nations Children’s Fund (UNICEF) – Web site: www.unicef.org/wes/**Нэгдсэн Үндэстний Байгууллын Хүүхдийн Сан (НҮБХС)**

Web site: www.unicef.org/wes/files/Scaling_up_HWTS_Jan_25th_with_comments.pdf

НҮБХС нь сургууль, олон нийтийн газрын усан хангамж, ариун цэврийн байгууламжийг сайжруулж, аюулгүй эрүүл ахуйн дадлуудыг дэмжихийн тулд дэлхийн 90 улс оронд үйл ажиллагаа явуулдаг. Онцгой байдалд НҮБХС усан хангамж тасалдах, өвчин эмгэг заналхийлээд буй олон нийт болон улс үндэстнүүдийг шуурхай аврах ажиллагаа явуулдаг.

WATER AID

Web site: www.wateraid.org

1981 онд байгуулагдсан дэлхий даяар усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, энэ чиглэлд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр ажилладаг Олон Улсын байгууллага юм

United States Agency for International Development (USAID)**АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг**

Web site: www.ehproject.org/

Эрүүл ахуйг сайжруулах төсөл нь USAID-ийн санхүүжүүлсэн гурван гол эрүүл ахуйн дадал болох гараа савандаж угаах, ялгадсын аюулгүй зайлуулалт ба өрхийн ундны усны аюулгүй хадгалалт ба цэвэршүүлэлтийг дэмжих замаар суулгалт өвчнийг бууруулж, хүүхдийн амьдрах чадварыг сайжруулахыг эрэлхийлсэн 6 жилийн (2004–2010) хөтөлбөр байв. Үүнээс хойш төслөөс боловсруулсан эх сурвалжуудыг хуваалцах зорилгоор цахим хуудас ажиллуулдаг.

Water and Sanitation Program (WSP)**Ус, Ариун Цэврийн Хөтөлбөр (УАЦХ)**

Web site: www.wsp.org

УАЦХ нь Дэлхийн Банкаар удирдуулсан олон хандивлагчийн хамтын ажиллагаа юм. Сайжруулсан усан хангамж ба ариун цэврийн үйлчилгээний тогтвортой хүртээмжийн удаашралтай өсөлтөд туслах зорилготой. УАЦХ нь Африк, Зүүн Хойд Ази, Латин Америк ба Карибийн орнууд болон Вашингтонд байрлах бүсийн суурин төлөөлөгчийн газраар дамжуулан 25 улс орны орон нутгийн болон үндэсний түвшинд үйлчлүүлэгч засаг захиргаа руу шууд чиглэж ажилладаг. УАЦХ нь 5 сэдэв рүү чиглэгддэг: “салбарыг санхүүжүүлэх”, “хөдөөгийн усан хангамж, ариун цэвэр”, “стратегийн харилцаа”, “ариун цэвэр, эрүүл ахуй” ба “хот суурийн газрын усан хангамж, ариун цэвэр”. УАЦХ захиалгын дагуу сонин хэвлэл, мэдээллээр хангадаг.

World Health Organization (WHO)**Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)**

Web site: www.who.int/household_water/en/

ДЭМБ нь эрүүл мэндийн ачаалал өндөр, ялгаатай интервенц хийгддэг, өнөөгийн мэдлэг сул газруудад ус, ариун цэвэр ба эрүүл ахуйн асуудлаар ажилладаг. ДЭМБ нь цахим сүлжээгээр авч болох өрхийн түвшинд ус цэвэршүүлэх, аюулгүй хадгалахтай холбоотой хэд хэдэн баримт бичгүүдийг боловсруулсан. Мөн түүнчлэн ДЭМБ ус, ариун цэвэр ба эрүүл мэндийн listserv-ийн захиалгад зохицуулалт хийдэг.

WSSCC

Web site: www.wsscc.org

Усан хангамж, орчны ариун цэврийн хамтарсан зөвлөл нь буурай орнуудын ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах чиглэлээр ажилладаг мэргэжлийн байгууллагуудын хамтарсан зөвлөл юм.

WASH ACTION OF MONGOLIA

Монголын Ус Ариун Цэвэр Эрүүл Ахуйн дэвшлийн төв ТББ

Web site: www.washaction.mn

Facebook хаяг: [facebook.com/washactionmongolia](https://www.facebook.com/washactionmongolia)

Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй орон нутгийн усан хангамж, ариун цэвэр эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах чиглэлээр ажилладаг Монголын мэргэжлийн төрийн бус байгууллага юм.

Ус, ариун цэвэр, эрүүл ахуйтай холбоотой тэмдэглэлт өдрүүдийг зохион байгуулах талаар мэдээлэл авч болох эх сурвалжууд:

www.globalhandwashing.org	Гар угаах дэлхийн өдөр (Жил бүрийн 10 сарын 15)
www.unwater.org/worldtoiletday	Дэлхийн 00-н өдөр (Жил бүрийн 11 сарын 19)
www.unwater.org/worldwaterday	Дэлхийн усны өдөр (жил бүрийн 3 сарын 22)
www.menstrualhygieneday.org	Сарын тэмдгийн эрүүл ахуйг дэмжих өдөр (5 сарын 28)
www.facebook.com/	Дэлхийн усны өдөр
www.facebook.com/	Дэлхийн гар угаах өдөр Монголд
www.facebook.com/	Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн сүлжээ

ХАВСРАЛТ 2

ЭРҮҮЛ МЭНДИЙН КЛУБЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЭРҮҮЛ МЭНДИЙН КЛУБ

Эй Си Эф Монгол олон улсын байгууллага нь 2008 оноос хойш олон нийт, хүүхэд багачуудад ус, ариун цэвэр, эрүүл ахуйн талаар боловсрол эзэмшүүлэх, эрүүл ахуйн зөв дадал хэвшилд суралцуулах зорилгоор төрөл бүрийн үйл ажиллагаа явуулсны нэг нь ерөнхий боловсролын сургуульд суурилсан эрүүл мэндийн клубын үйл ажиллагаа юм. Энэ үйл ажиллагаанаас туршлага болгон хүргэж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН КЛУБ ГЭЖ ЮУ ВЭ?

Эрүүл мэндийн клуб нь сурагчдад ус, ариун цэвэр, эрүүл ахуйн талаар ойлголт мэдлэг эзэмшүүлдэг, сургалт зохион байгуулдаг, эрүүл ахуйн зөв дадалд суралцахад дэмжлэг үзүүлдэг, өөрийн сурсан зүйлээ бусдад хуваалцах сонирхолтой, сайн дурын үндсэн дээр нэгдсэн хүүхдүүдийн бүлэг юм. Энэ бүлэг нь хүүхдийн оролцоон дээр тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд сурагчид болон олон нийтэд хувийн болон орчны “ЭРҮҮЛ АХУЙН” талаарх мэдээлэл түгээж, зөв дадал хэвшилтэй болоход нь нөлөөлж үйл ажиллагаагаа чиглүүлдэг. Үе тэнгийн болон клубын сурагчид бие биедээ нөлөөлснөөр нийт сурагчдын ус, ариун цэвэр, эрүүл ахуйн талаарх мэдлэг нэмэгдэж, биеэ зөв боловсон авч явах болон эрүүл амьдрах соёлд суралцдаг.

ЭРҮҮЛ МЭНДИЙН КЛУБ БАЙГУУЛАХ ҮЕ ШАТУУД

ЗАР БАЙРШУУЛАХ

Эрүүл мэндийн клуб байгуулах ажил нь сурагчдад зар хүргэхээс эхэлнэ. Зарыг санаачлагч сурагч бичгэн болон видео хэлбэрээр, сургуулийн вэб сайт болон электрон шуудан, /e-mail, facebook, youtube, twitter, /электрон хуудас нийтлэх, мэдээллийн самбар дээр байршуулах, үзэлээр зарлах гэх мэт мэдээлэл хүрч болох бүх аргыг ашиглан сургуулийн нийт сурагчдад ил тод, хүртээмжтэйгээр хүргэх хэрэгтэй. Эрүүл мэндийн клуб нь сайн дурын байгууллага учраас сурагчдын хүсэл сонирхол дээр тулгуурлах нь зүйтэй бөгөөд зарын дагуу эрүүл мэндийн клубт элсэхийг хүссэн сурагч өргөдлийн маягт (167-р хуудас) бөглөнө.

Анхаарах зүйл:

Багшаар дамжуулж зар түгээх нь цөөхөн хүүхдэд хүрэх, зөвхөн тэргүүний (лидер) сурагчид сонгогдох зэрэг сөрөг талтай. Иймд энэ аргыг дангаар хэрэглэхээс аль болох зайлсхийх хэрэгтэй.

Өнөөгийн нөхцөлд туршлагаас ажиглахад хүүхдээс санаачлага гарахаас илүүтэйгээр багш, удирдлагын зүгээс санаачилж бүлэг үүсгэх асуудал түгээмэл байдаг тул аль болох сурагчдаар өөрсдөөр нь санаачлуулж бүлэг байгуулж, харин багш бүлэг үүсэхэд хүүхдүүдийг идэвхжүүлж, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

СОНГОН ШАЛГАРУУЛАХ БАГ БАЙГУУЛАХ

Сонгон шалгаруулах баг нь санаачлагч сурагч болон хүүхдийн оролцооны байгууллагын гишүүдийн (сурагчдын зөвлөл, өсвөрийн цагдаа бүлгэм... гэх мэт) төлөөллөөс бүрдсэн 3-5 хүүхдийн бүрэлдэхүүнтэй байна. Энэ баг нь ЭМК-т элсэх сурагчдыг сонгох, хамтран ажиллах баг бүрдүүлэх зорилготой.

Анхаарах зүйл:

Сонгон шалгаруулах багийн гишүүд өөрсдийн үйл ажиллагаагаа илүү сайн, бусдад хүртээмжтэй, өргөн хүрээгээр явуулахын тулд асуудалд нухацтай хандаж найз нөхдөө түлхүү хамруулахаас татгалзах хэрэгтэй.

Хүсэлт гаргасан сурагчдын материалтай танилцаж, сонгон шалгаруулалт хийх

Клубын гишүүдийг сонгохдоо дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

Сайн дурын үндсэн дээр хүсэлт гаргасан эсэх

Бусдад нөлөөлөх, өөрийн сурсан зүйлээ бусадтай хуваалцах сонирхолтой эсэх

Хүүхдийн оролцооны байгууллагад гишүүнчлэлтэй эсэх

Төгсөх болон бага ангийн сурагч эсэх /эрүүл мэндийн клуб нь дан төгсөх болон бага ангийн сурагчаас бүрдэх нь зохимжгүй/ Хүйсийн харьцааг харгалзаж үзэх /жендерийн мэдрэмжтэй байх/

ТУРШЛАГА: Эрүүл мэндийн клубтээ сургуулийнхаа эрүүл ахуйн буруу дадал хэвшилтэй зарим сурагчдыг сонгон гишүүнээр элсүүлж, тэднийг эрүүл ахуйн зөв дадал хэвшилд суралцуулах замаар бусдад нөлөөлдөг. *106-р сургуулийн захирал...*

АНХААРАХ ЗҮЙЛ:

Эрүүл мэндийн клубт гишүүн элсүүлэхдээ өөрийн хүслээр биш, хэн нэгний зөвлөснөөр орсон, нийгмийн идэвх оролцоо муу эсвэл тэргүүний сурлагатай хүүхдүүдийг хамруулсан бол тэд аливаад хойрго хандах, таслах, бусдыг дэмжихгүй байх зэргээс болж клубын үйл ажиллагаа идэвхгүй зогсонги байдалд ордог. Мөн клубын гишүүд зарим тохиолдолд уртасгасан цагаар ажиллах хэрэгцээ шаардлага тулгардаг учраас хүүхдүүдийн аюулгүй байдалд анхаарах хэрэгтэй.

Эхний шатанд шалгарсан сурагчдыг ярилцлаганд оруулснаар сонгон шалгаруулалтын үе шат дуусгавар болно.

Энэ шатанд анхааралгүй орхиж болохгүй нэг зүйл бол эцэг эхийн дэмжлэг юм. Ихэнх хүүхдүүд эцэг эхдээ хэлээгүй, тодорхой мэдээлэл өгөөгүйн улмаас гэр орныхон нь дургүйцэж зарим нь хүүхдээ “худлаа хэлж гадуур сэлгүүцлээ”- гэж үздэгээс болж эцэг эх, хүүхдийн хооронд зөрчил үүсч улмаар хүүхэд клубээс гарах тохиолдол гардаг.

ТООНЫ ХУВЬД:

Эрүүл мэндийн клуб нь хэдэн ч гишүүнтэй байж болох боловч хэт олон, хэт цөөн байх нь удирдан, зохион байгуулах болон үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулдаг. Иймээс учраас ойролцоогоор 10-15 хүүхдийн (анги бүлгийн тооноос хамаарна) гишүүнчлэлтэй байх нь хамгийн зохимжтой байдаг. Гэхдээ сурагчид явц дундаа янз бүрийн шалтгааны улмаас клубээс гарах тохиолдол байдаг учраас нөөцийн судалгаатай байх нь зүйтэй.

НАСНЫ ХУВЬД:

5-11-р ангийн сурагчид байвал илүү тохиромжтой. Төгсөх ангийн сурагчид хичээлийн ачаалал их, чөлөөт цаг багатайгаас тэр бүр клубын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож чаддаггүй. Бага ангийн сурагчдын тухайд бусдад нөлөөлөх чадвар харьцангуй бага гэдгийг харгалзан үзэх хэрэгтэй.

БАГ БҮРДҮҮЛЭЛТИЙН ХУВЬД:

Эрүүл мэндийн клубт өөр өөр ангийн сурагчдыг хамруулбал үйл ажиллагааны цар хүрээ томорч, хүртээмж сайжирч, олон ургальч үзэл давамгайлах зэрэг сайн талтай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН КЛУБЫН ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:**А. ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Эрүүл мэндийн клубыг гишүүд өөрсдийн хүслээр яаж ч зохион байгуулж болно. Гэхдээ клуб нь

Нэр, уриа, логотой байх,

Клуб өөрийн гэсэн нэр, логотой байх нь албан ёсных болохыг илтгэнэ.

Таних тэмдэг бүхий хувцастай байх,

Энэ нь клубын гишүүд хийж байгаа ажил болон өөрөөрөө бахархах сэтгэл төрүүлдэг сайн талтай. Мөн өсвөр насныхан үе тэнгийнхнээсээ онцгойрох дуртай байдаг бөгөөд клуб өөрийн гэсэн таних тэмдэг бүхий хувцастай байх нь тэдний “онцгойрох” гэсэн хүслийг биелүүлж өгдөг.

Зорилгоо тодорхойлж, үйл ажиллагаагаа сар болон жилээр төлөвлөсөн (*хавсралт 2*) байх,

Багийн ахлагч болон зөвлөн чиглүүлэх багштай байх,

Клубын гишүүдийн баримтлах дүрэм, журамтай байх,

Үйл ажиллагааны үндсэн зорилгоо тодорхойлж, түүнээсээ хазайхгүй байх

Эрүүл мэндийн клубын үндсэн зорилго бол сургуулийн нийт сурагчдыг эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болоход нь дэмжин туслах юм. Гэвч зарим сургуулиудын хувьд энэхүү зорилгоосоо хазайж сурагчдын ариун цэвэр шалгах, өөр үйл ажиллагаанд татагдан орох гэх мэтчилэн эмчийн туслах байдлаар ажиллаж байгаа үзэгдэл ажиглагддаг.

Клубын тогтвортой байдлыг хангах үүднээс гишүүдийг чадавхжуулах хэрэгтэй.

Клубын гишүүд шилжилт хөдөлгөөнд орсон тохиолдолд нөөцийн судалгаанаас нэмж гишүүнчлэл хийх

Б. ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Клуб нь гишүүдийн дундаас сонгогдсон ахлагчтай байхаас гадна санхүү, мэдээлэл сурталчилгаа хариуцсан гэх мэт олон асуудал хариуцсан гишүүнтэй байх нь зүйтэй бөгөөд клубын гишүүдийн саналаар томилогдоно.

Ахлагч: Клуб нь ахлагч болон зөвлөн чиглүүлэх багштай байх бөгөөд ахлагчаа гишүүд өөрсдөө сонгоно. Клубын ахлагч нь гишүүдээ удирдан үйл ажиллагааг зохион байгуулах, сургуулийн удирдлага, багш нартай клубээ төлөөлж харилцах, хагас ба жилийн эцсийн тайлан гаргах, тайлагнах зэрэг үүрэг гүйцэтгэнэ.

Санхүү хариуцагч: Клубын үйл ажиллагаанд шаардлагатай байгаа хөрөнгийг тооцоолж, клубын гишүүдээр хэлэлцүүлэх, хөрөнгө босгох /сан байгуулах/ арга замыг хайх, захиран зарцуулах, гишүүддээ орлого зарлагаа тайлагнах үүрэг гүйцэтгэнэ.

Мэдээлэл сурталчилгаа хариуцсан гишүүн: Сургуулийн удирдлага, багш, ажилчид, сурагчдыг клубын үйл ажиллагааны талаарх мэдээллээр тасралтгүй хангах, гаргасан амжилтаа сурталчлах, мэдээлэх үүрэг хүлээнэ.

АНХААРАХ ЗҮЙЛ:

Клубын гишүүдийн санаачлагаар өөр үүрэг хариуцсан гишүүдтэй байж болно.

Эрүүл мэндийн клубын үндсэн зорилго бол сургуулийн нийт сурагчдыг эрүүл ахуйн зөв

дадал хэвшилтэй болоход нь дэмжин туслах юм. Гэвч зарим сургуулиудын хувьд энэхүү зорилгоосоо хазайж сурагчдын ариун цэвэр шалгах, өөр үйл ажиллагаанд татагдан орох гэх мэтчилэн эмчийн туслах байдлаар ажиллаж байгаа үзэгдэл ажиглагддаг.

Клубын тогтвортой байдлыг хангах үүднээс гишүүдийг чадавхжуулах,

Клубын гишүүд шилжилт хөдөлгөөнд орсон тохиолдолд нөөцийн судалгаанаас нэмж гишүүнчлэл хийх хэрэгтэй.

КЛУБЫН УДИРДЛАГА

Энэ нь хүүхдийн оролцооны байгууллага учраас хүүхдүүд өөрсдөө ахлагчаа сонгоно. Клуб үйл ажиллагаагаа дэмжүүлэх зорилгоор багш, эмч, захирал, нийгмийн ажилтан, эцэг эхийн зөвлөл гэх мэт хүмүүстэй байнга холбоотой байж тэднээс дэмжлэг авах зайлшгүй шаардлагатай. Багш клубын гишүүдийг арга зүй болон хичээл заах нөхцөл боломжоор хангадаг бол эмч эрүүл мэнд талаасаа зөвлөн туслах үүрэг гүйцэтгэдэг. Клубын үйл ажиллагааг чиглүүлж байгаа эмч, багш хоёр гар нийлж сургалт сурталчилгаагаар сайн хийж чадвал клубын үйл ажиллагаа олонд танигдаж, хүүхдүүдэд эерэгээр нөлөөлдөг.

ЭРҮҮЛ МЭНДИЙН КЛУБЫН ГИШҮҮДИЙГ ХЭРХЭН БЭЛТГЭХ ВЭ?

Эрүүл мэндийн клубын гишүүдийг сонгон шалгаруулж дууссаны дараа гишүүдээ “Эрүүл мэнд, Хүрээлэн буй орчны эрүүл ахуй” гарын авлагын (хавсралт 3) дагуу сургалтад хамруулна. Ингэснээр клубын гишүүд ус, ариун цэвэр, эрүүл ахуйн үе тэнгийн сургагч багш болно. Сургалтын үр дүнд үе тэнгийн сургагч буюу эрүүл мэндийн клубын гишүүд ус, ариун цэвэр, эрүүл ахуйн талаар боловсрол эзэмшихээс гадна доорх ур чадвартай болдог. Үүнд:

Харилцаа

Өөртөө итгэх итгэл

Багаар ажиллах

Үүрэг, хариуцлага хүлээх

Бусдыг хүндэтгэх

Эрүүл орчин бүрдүүлэх

Багшлах ур чадвар

Эдгээр чадваруудыг гишүүдэд бүрэн эзэмшүүлэхэд цаг хугацаа, ур чадвар их шаардагддаг. Тиймээс гишүүдэд богино хугацаанд дээрх ур чадваруудыг эзэмшүүлэх шаардлагатай бөгөөд зарим уламжлалт аргуудыг ашиглах нь зүйтэй. Үүнээс дурьдвал:

ТУРШЛАГА ХУРИМТЛУУЛАХ

Гишүүдийг хоёр хоёроор нь баг болгон хувааж, багууд бие биедээ хичээл заах. Олон хүүхдийн өмнө анх удаа гарч байгаа ямар ч хүүхэд сандардаг. Гишүүд багт хуваагдаж бие биедээ хичээлээ зааснаар тэрхүү “сандрах” мэдрэмжээ хэрхэн даван туулах, зохицуулах арга барилыг эзэмшинэ.

Мэдлэг түгээх сургалтыг бага ангиас эхлэх - Ахлах ангийнхан доод ангийнхаа сурагчдыг хичээл заахад үл тоомсорлодог тул гишүүдийн өөртөө итгэх итгэл буурах, хичээл заахаас шантарч зугатаах, клубээс гарах зэрэг сөрөг үр дагавар ихтэй байдаг бол бага ангид хичээл заах нь эсрэгээрээ гишүүн сурагчдын өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, ярианы чадварыг дээшлүүлэх, анги зохион байгуулах чадварыг нэмэгдүүлэх, туршлага хуримтлуулах зэрэг сайн талтай.

Багт хуваах – Эрүүл мэндийн клубын гишүүдийг цөөн хүнтэй багуудад хувааж

мэдлэг түгээлгэх ба багууд хичээлээ заасны дараа алдаа оноо, ололт амжилтаа харилцан ярилцаж байвал багийн гишүүдийн хамтын ажиллагаа болон заах арга барил хурдан сайжирч багаар ажиллах чадвар дээшилнэ. Гэхдээ багийн гишүүдийг хооронд нь байнга сольж байх хэрэгтэй.

Туршлага солилцох – Эрүүл мэндийн клубүүдийн хооронд уулзалт зохион, тулгарч буй бэрхшээл, түүнийг даван туулсан арга замуудын талаар харилцан туршлага солилцох зэрэг болно.

Гишүүдийг чадавхжуулахгүйгээр шууд үйл ажиллагаанд хамруулвал эрүүл мэндийн клубын гишүүдийн өмнө

Сандрах, гацах, үгээ мартах

Биеэ барих,

Өөртөө итгэх итгэл нь буурах,

Нэр хүндэд нь сөргөөр нөлөөлөх зэрэг хүндрэлүүд тулгардаг.

Эдгээр хүндрэлүүдээс болж хүүхэд сэтгэлээр унаж, өөрийгөө голж, идэвх оролцоо нь буурч, өөртөө итгэх итгэлээ алдана. Иймд гишүүдийнхээ нэр хүндийг хамгаалах ажлыг зохион байгуулж байх хэрэгтэй.

Эрүүл мэндийн клубт хамрагдсан сурагчид

Хувь хүний хувьд хөгжсөн,

Нийгмийн идэвх оролцоо нэмэгдсэн,

Хувь хүний чадваруудад суралцсан (ярианы, багаар ажиллах, удирдан зохион байгуулах, өөртөө итгэлтэй болох гэх мэт...),

Нээлттэй, нэр хүндтэй болсон,

Багшлах ур чадвараас суралцсан,

Эрүүл ахуйн талаар гүнзгий мэдлэгтэй болж бусад сурагчдад үлгэр дуурайлал үзүүлдэг болсон,

Эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болсон гэж сургуулиудын захирал, эмч, эрүүл мэндийн багш нар нь үнэлжээ.

Эй Си Эф Монгол ОУБ-н 2012-2014 онд СХД-н ерөнхий боловсролын 14 сургуульд хэрэгжүүлсэн “Ус, ариун цэвэр, эрүүл ахуй”-н төслийн чанарын судалгаа

ЭМК-Н ГИШҮҮДИЙГ ХЭРХЭН ИДЭВХЖҮҮЛЭХ ВЭ?

Хүүхэд сониуч учраас нэг төрлийн үйл ажиллагаанаас амархан уйддаг. Тиймээс зөвхөн “ эрүүл ахуйн мэдлэг түгээх” үйл ажиллагаанаас гадна ЭМК-н гишүүдийг идэвхжүүлэх үйл ажиллагааг чиглүүлэгч багш, эмч, клубын ахлагч нар хийх хэрэгтэй байдаг. Үүнд:

Сайшаал, магтаал

Сайшаал магтаалд дургүй хүн гэж үгүй. Мэдлэг түгээж, чадваржуулах үйл ажиллагаа явуулж байх эхний үед сурагчид алдаа гаргах нь их байдаг ба тэр үед аль болох буруутгах, загнахаас зайлсхийх хэрэгтэй.

Чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх

Сагсан бөмбөг тоглох, музей үзэх, хог хаягдал ашиглан бүтээл хийж, түүгээрээ үзэсгэлэн гаргах, зарж борлуулах гэх мэт чөлөөт цагийн арга хэмжээг авч байх нь гишүүдийг идэвхжүүлэхэд чухал нөлөөтэй. Мөн хичээлээ хамтарч давтах цагийг клубын үйл ажиллагааны төгсгөлд багтааж өгвөл хүүхдүүд төдийгүй эцэг эхчүүд дуртай байдаг.

Клубын гишүүдийн эцэг эхчүүдийн өдөрлөг зохиох

Хүүхэд аливаа сайн дурын үйл ажиллагаанд тууштай хамрагдах эсэх нь эцэг эхийн хандлагаас ихээхэн хамаардаг. Иймд тэдний дэмжлэгийг авахын тулд эцэг эхийн өдөрлөг зохион байгуулж хүүхдийнх нь хийж буй ажил, нийгэмд гүйцэтгэж буй үүргийг тодорхой тайлбарлаж, хийсэн зүйлсээр нь фото болон видео үзэсгэлэн гаргаж харуулбал тэд хүүхдийнхээ нөөц боломж, авьяас чадварыг үнэлж, хандлага нь өөрчлөгдөн, эцэг эх хүүхдийн харилцаа, хамтын ажиллагаа, харилцан ойлголцол сайжирна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН КЛУБИЙН СУРАГЧДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

Сурагчдын ус, ариун цэвэр, эрүүл ахуйн талаарх ойлголт мэдлэг нэмэгдэнэ
 Сурагчид эрүүл ахуйн зөв дадал хэвшилд суралцана,
 Ус болон хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалах үзэл төлөвшинө,
 Сурагчдыг хүрээлэн буй орчны тулгамдсан асуудлуудыг тодорхойлж шийдвэрлэж сурахад нь туслана
 Сурагчид эрүүл мэндийн хичээлээр олж авсан мэдлэгээ бататган, гүнзгийрүүлнэ
 Сурагчдын болон сургуулийн ариун цэвэр сайжирч, хотын болон ахуйн соёлд суралцана,
 Сургуулийн болон гэр бүлийн орчин дахь халдварт өвчний гаралт буурна.
 Гэр бүлийн түвшинд ус, ариун цэвэр, эрүүл ахуйн талаарх зан үйлд өөрчлөлт орно.
 Эцэг эх болон бусдад нөлөөлөх нөлөөлөл нэмэгдэнэ.
 Эрүүл мэндийг дэмжигч, идэвхтэй санаачлагч, үлгэр жишээч болно.

ЭРҮҮЛ МЭНДИЙН КЛУБЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эй Си Эф Монгол ОУБ нь 2008 оноос хойш олон нийт, хүүхэд багачуудад ус, ариун цэвэр, эрүүл ахуйн талаар боловсрол олгох, эрүүл ахуйн зөв дадал хэвшилд суралцуулах зорилгоор төрөл бүрийн үйл ажиллагаа явуулсны нэг хэсэг нь ерөнхий боловсролын сургууль дээр суурилсан эрүүл мэндийн клубын үйл ажиллагаа юм. Энэ үйл ажиллагаанаас туршлага болгон хүргэж байна.

Эрүүл мэндийн клубын үйл ажиллагаа нь 2 хэсгээс бүрдэнэ.

Сурагчдад ус, ариун цэвэр, эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болоход дэмжлэг үзүүлэх

А. СУРГАЛТЫН ЗОРИЛГО: “Ус, ариун цэвэр орчны эрүүл ахуй”-н талаар мэдлэг чадварыг эзэмшүүлж, зөв дадлыг хэвшүүлэх

Эрүүл мэндийн клуб нь хүүхдийн оролцоон дээр суурилсан хүүхдээс хүүхдэд аргачлалыг ашиглан ус, ариун цэвэр, эрүүл ахуйн сургалтыг үе тэнгийнхэндээ түгээдэг. Энэ аргачлалын давуу тал нь хүүхэд хүүхдийнхээ заасан зүйлийг илүү ойр тусган авч, ойлгож хүлээж авдагт оршино.

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР: Эрүүл ахуйн сургалтын агуулгад дараах сэдвүүд

Сэдэв	Бүлэг	Ур чадвар
Гар угаалт	Гар угаахын ач холбогдол	Гар угаах тохиолдлуудыг танин мэдэх, Гар угаах зөв дарааллыг сурах Гараа савандаж угаахын ач холбогдлыг тайлбарлах Гар нүүрийн алчуурын талаар мэдлэгтэй болох
	Гараа зайлшгүй угаах тохиолдолууд	
	Гарыг дарааллаар угаахын ач холбогдол	
Халдварт өвчнөөс сэргийлэх	Халдварт өвчин гарах шалтгаан	Халдварт өвчин түүний дамжих замуудын талаар мэдлэгтэй болох Халдварт өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлж арга замуудыг сурах Эрүүл ахуйн буруу дадлаа өөрчлөх энгийн аргуудад суралцах
	Халдварт өвчнөөс сэргийлэх аргууд	
	Зөв дадлыг хэвшүүлье	
	Цагаан хорхойтох	
Ундны усны зөв хэрэглээ	Ус хэрхэн бохирддог вэ?	Ус бохирдох нөхцөлүүд, усны саванд тавигдах эрүүл ахуйн шаардлагыг мэдсэнээр ус бохирдохоос сэргийлэх аргуудад суралцаж, шаардлага хангасан сав хэрэглэдэг болох
	Усны савны эрүүл ахуй	
Хүрээлэн буй орчны эрүүл ахуй	Усны ач холбогдол	Усны ач холбогдол, ус хомсдох шалтгаануудыг мэдсэнээр усаа зохистой хэрэглэж сурах Хүрээлэн буй орчныг бохирдуулагч хүчин зүйлс, тэдгээрийн хор уршиг, хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдлэгтэй болох Эрүүл ахуйн шаардлага хангасан орчинг бүрдүүлж сурах
	Усны хэрэглээ	
	Байгаль дахь усны эргэлтийн ач холбогдол	
	Усны зохистой хэрэглээ	
	Усны эргэлт түүний өөрчлөлт	
	Хог хаягдал	
	Ариун цэврийн байгууламж	

Сургалт нь дараах байдлаар зохион байгуулагдаж болно.

Сургалтыг эрүүл мэндийн хичээл болон хичээлээс гадуурх цагаар хэсэг бүлэг хүүхдүүдийг эсвэл анги ангиар нь хамруулах байдлаар зохион байгуулж болно.

Эрүүл мэндийн клубын гишүүд “Ус, ариун цэвэр, эрүүл ахуй”-н сургалтанд хамрагдаж үе тэнгийн сургагч болно.

Ус, ариун цэвэр, эрүүл ахуйтай холбоотой зөв мэдээлэл олж боловсруулах, мэдээллийг түгээх замаар сургалтыг явуулж болно. Энэ шатанд сургуулийнхаа эрүүл мэнд, биологийн багш, эмчээс зөвлөгөө авч болно.

Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн сургалтаа сургуулийнхаа нийт сурагчдад түгээнэ. Сургалтыг тодорхой давтамжтайгаар /улиралд 1 удаа/ явуулах нь зүйтэй.

СУРГАЛТААС ГАРСАН ҮР ДҮН

Мэдлэг

Гараа зөв дарааллын дагуу угаахын ач холбогдол,
Усны савны ариун цэвэр, тавигдах шаардлага, бохирдох нөхцөлүүдийн талаар,
Хог хаягдлын төрөл, байгальд задрах хугацаа, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл,
Хүрээлэн буй орчныг бохирдуулагч хүчин зүйлс, тэдгээрээс хэрхэн урьдчилан
сэргийлэх талаар ойлголт мэдлэгтэй болсон.

Чадвар

Халдварт өвчин дамжих замууд, шалтгааныг ойлгож, өөрийгөө болон бусдыг
халдвараас урьдчилан сэргийлэх аргуудад суралцсан,
Ариун цэврийн байгууламжаа сайжруулах арга замуудаас сурсан байна.

В. СУРАГЧДАД ЭРҮҮЛ АХУЙН ЗӨВ ДАДАЛ ТӨЛӨВШҮҮЛЭХ

Дан ганц мэдлэгтэй байснаар дадал суудаггүй тул эрүүл мэндийн клуб нь сурагчдын
зан үйлийг хөгжүүлэх үйл ажиллагааг өөр хэлбэрээр зохион байгуулах шаардлагатай
байдаг.

Дадал төлөвшүүлэх аргууд

Их завсарлагаанаар эрүүл мэндийн клубын гишүүд сургуулийн ариун цэврийн
байгууламжинд жижүүр хийж, гараа угаагаагүй болон дутуу угаасан сурагчдын гарыг
дахин угаалгах, крантаа хаагаагүй тохиолдолд шаардлага тавих,

Анги бүр, ариун цэврийн байгууламж бүрт гар угаах дараалал, усны зохистой
хэрэглээ болон хог хаягдал, ариун цэврийн байгууламж ашиглалтын талаар мэдээлэл
бүхий сурталчилгааны материал хадах

Ажиглалт судалгаа хийж, буруу дадалтай хүүхдүүдийг эрүүл мэндийн клубын үйл
ажиллагаанд татан оролцуулах гэх мэт.

Үр дүн.

Гараа дарааллын дагуу, бохирдсон тохиолдол бүрт савандаж угааж хэвшсэн.

Усны ач холбогдлыг ойлгож, усаа цэвэр байлгаж, ариг гамтай, зүй зохистой хэрэглэж
сурсан

Усны саванд тавигдах шаардлагуудыг мэдсэнээр зориулалтын савыг сонгох болсон.

Сурагчид хогоо ил задгай хаядаг буруу зуршлаасаа салж сургуулийн орчин хоггүй
болсон байна.

2. Төрөл бүрийн уралдаан тэмцээн, ухуулга сурталчилгааны ажил зохион байгуулах

Сурагчдын дунд төрөл бүрийн уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулах нь нэг
талаас сурагчдын эрүүл мэндийн клубээр дамжуулан эзэмшсэн мэдлэгийг бататгах,
дадал хэвшил болгох нөгөө талаас үйл ажиллагаагаа сургуулийн удирдлага, багш
ажилчид, сурагчдад таниулах аргуудын нэг юм. Гэхдээ үйл ажиллагааны арга хэлбэр
нь уламжлалт, түгээмэл бус шинэлэг байх тусам олон нийт клубын үйл ажиллагааг илүү
сонирхож, хүлээн авна. Тухайлбал:

“Гар ба ганган дүрс”- Оролцогчид гуаш ашиглан гар дээрээ зурна. Сонирхолтой
боловч цөөн тооны зургийн авьяастай хүүхдүүд хамардаг сул талтай

“Гарын хээ-гайхамшигт бүтээл”- Оролцогчид усан будаг, гуаш гэх мэт зургийн хэрэгсэл
ашиглан ватум цаасан дээр хурууныхаа хээгээ дарж бүтээлээ хийнэ. Бүх насныхан
хамрагдах боломжтой

Багт наадам – Эрүүл мэндийн клубын гишүүд тусгай баг өмсөн сургуулийнхаа сурагчид болон эцэг эхчүүдэд эрүүл ахуйн мэдээлэл өгч, сурталчилгааны материал тараах

“Ус бидний амьдралд”- Сурагчид өөрийн гар утас, Irod, зургийн аппарат зэргийг ашиглан фото зураг авч, видео бичлэг хийж оролцох гэх мэт төрөл бүрийн уралдаан тэмцээнийг зохион байгуулж болох боловч клуб нь өөрийн гэсэн хөрөнгө мөнгөгүйн улмаас шагналын асуудлыг шийдвэрлэхэд бэрхшээлтэй байдаг.

Иймд үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөхдөө төсөв санхүүгийн асуудлаа шийдвэрлэсэн байх ёстой. Хог хаягдал ашиглан бүтээл хийж борлуулах, хаягдал цаас, шил цуглуулж тушаах, гишүүнчлэлийн татвар, тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагуудад хандах зэргээр санхүүгийн асуудлаа шийдвэрлэж болно. Мөн тэмдэглэлт өдрүүдийн (Гар угаах дэлхийн өдөр, ОО-н дэлхийн өдөр, Усны дэлхийн өдөр... гэх мэт) хүрээнд төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагууд хамтран жил бүр олон нийтийн дунд тодорхой үйл ажиллагаануудыг зохион байгуулдаг бөгөөд хүссэн албан байгууллага, хүүхдийн оролцооны байгууллага хамтран оролцох боломжтой.

КЛУБЫН ӨРӨӨ

Ерөнхий боловсролын ихэнх сургуулиуд анги танхимын хүрэлцээ муутайгаас хүүхдийн оролцооны байгууллагуудад зориулсан өрөө гаргах боломжгүй байдаг. Энэ байдал нь хүүхдийн оролцооны байгууллагын үйл ажиллагаа тогтвортой явагдахад саад учруулдаг. Иймээс эрүүл мэндийн клубыг өрөө танхимаар хангах нь клубын цаашдын тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлдэг.

Ирээдүй цогцолборын 2-р бага сургуулийн эрүүл мэндийн клуб тогтмол нэг өдөрт (тухайлбал 4 дэх өдөр бүр) сургуулийн номын санд цугларч сурагчдад сургалт зохион байгуулах болон мэдлэг түгээх үйл ажиллагаандаа бэлтгэдэг.

СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн сургалтын хэрэглэгдэхүүнүүд нь орчин үеийн цахилгаан техник, тоног төхөөрөмж ашигладаггүй, гарын доорх материалыг ашиглан хүссэн хүн бүр зурж, хийх боломжтой байдгаараа хүртээмжтэй, бусад сургалтын хэрэглэгдэхүүнээс онцлог юм. Энэ утгаараа монгол орны хаана ч ажиллаж байгаа багш, эрүүл мэндийн клубын гишүүн өөрөө хийгээд, гэртээ байдаг зүйлсийг ашиглан сургалт явуулах боломжтой. Тухайлбал:

Тухайлбал:

	Багц материал	Туслах хэрэглэгдэхүүн
1	“Эрүүл мэнд, хүрээлэн буй орчны эрүүл ахуй” гар ын авлага	Дэлхийн газрын зураг эсвэл дэлхийн бөмбөрцөг
2	A2 хэмжээтэй зурагт хуудас (зураг)	Түмпэн (гар угаах зориулалт бүхий)
3	A5 постер (зураг)	Усны сав (гар дээр ус хийх зориулалт бүхий)
		Саван
		Саа
		Нүүр гарын алчуур
		Хүнсний скоч

КЛУБЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БУСДЫГ ХЭРХЭН ТАТАН ОРОЛЦУУЛАХ ВЭ?

СУРГУУЛИЙН УДИРДЛАГА, БАГШ

Эрүүл мэндийн клубын үйл ажиллагаа тогтвортой бөгөөд амжилттай явагдахад сургуулийн удирдлага, багш, ажилчдын дэмжлэг чухал байдаг.

Клубын хамт олон сургуулийн удирдлагад өөрсдийн зорилго зорилт, үйл ажиллагаагаа танилцуулж, сургуулийн жилийн ажлын /стратеги/ төлөвлөгөөнд тусгах замаар дэмжлэг авах нь бие дааж үйл ажиллагаа явуулах, хүүхэд цааш хөгжихөд дөхөмтэй байдаг. Эсвэл эрүүл мэндийн асуудлыг сургуулийн дотоод журамд тусгуулах замаар дэмжлэг авах боломжтой. Тухайлбал хүүхэд бүр эрүүл мэндийг дэмжих ажлыг санаачлагатай, бүтээлчээр хийх гэх мэт заалт тусгуулах.

Нөгөө талаас сүүлийн хэдэн жилийн турш НҮБ хүүхдийн оролцоог удирдах түвшинд нэмэгдүүлэх олон талт ажлыг хийж байгаа ба үүнтэй холбоотойгоор бараг сургууль бүр хүүхдийн оролцох эрхийг хангах зорилт дэвшүүлсэн байдаг.

Хэрвээ сургуулиуд хүүхдийн оролцооны байгууллагын зүгээс гарч буй санал санаачлагыг бүгдийг биш гэхэд боломжит заримыг нь дэмжвэл хүүхдийн оролцох болон хөгжих (хүүхэд аливаа зүйлд оролцохын хирээр хөгжих байдаг) эрхийг хангах зорилтондоо хүрэх боломжтой болно. Иймээс эрүүл мэндийн клуб үйл ажиллагаагаа төлөвлөхдөө сургуулийнхаа тухайн жилийн зорилго, зорилттой уялдуулж өгөх нь үр дүнтэй.

Мөн сургуулийн удирдлага, багш ажилчдыг эрүүл мэндийн клубээс зохион байгуулж байгаа үйл ажиллагаа болон үр дүнгийн талаарх мэдээллээр байнга хангаж, бас үйл ажиллагаандаа татан оролцуулж, үр дүнгээ хагас жилээр (тайлан үзэсгэлэн гаргах, клубын өдөрлөг зохион байгуулах ..) тайлагнах зэрэг нь дэмжлэг авах нэг арга юм.

Одоогийн байдлаар ихэнх сургуулиуд эрүүл мэндийн клубын үйл ажиллагааг дараах байдлаар дэмжиж байна. Үүнд:

Хичээлийн цагийг зохицуулах \хүүхэд хөгжүүлэх сургалтын цагийг ашиглах\

ЭМК хичээллэх анги, танхимаар хангах

Багш, эмч нар арга зүйгээр хангах

ЭМК-ээс зарлаж буй уралдаан тэмцээний шагналыг гаргах зэрэг болно.

ЭЦЭГ ЭХ

Эцэг эхчүүд үр хүүхдээ өндөр боловсролтой, цэвэрч, нямбай, эцэг эхдээ энэрэлтэй, бүтээлч, бие даасан иргэн болгон хүмүүжүүлэхийг хүсдэг. Энэ хүсэлтийн биелэх боломж нь хүүхдийнхээ хийж буй сайн үйлийг дэмжих явдал юм. Хүүхдийн өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх, найз нөхдийн хүрээллийг сайжруулах арга бол хүүхдийн оролцооны байгууллага юм гэдгийг эцэг эхчүүдэд ойлгуулвал дэмжлэг болон нөлөөлөл үзүүлэх маш том хүч болно.

Тиймээс эрүүл мэндийн клуб өөрийн үйл ажиллагааг жилдээ 1-2 удаа эцэг эхдээ тайлагнаж, өөрсдийн хийж байгаа ажлын талаарх мэдээллээр хангаж, заримдаа үйл ажиллагаандаа татан оролцуулж байх хэрэгтэй. Эцэг эхчүүдээр дамжуулан сургуулийн удирдлага, багш нараас дэмжлэг авч болдог. Мэргэжлийн байгууллагын дэмжлэгийг эцэг эхийн тусламжтайгаар авч болох боломжтой.

СУРАГЧИД

Сонирхолтой, олон хувилбартай үйл ажиллагаа явуулах тусам сургуулийн сурагчдын дэмжлэгийг хурдан авна. Тиймээс үйл ажиллагаагаа төлөвлөхдөө арга барил дээрээ анхаарч, аль болох уламжлалт бус аргыг сонгох нь сурагчдын сэтгэлд хүрч, тэдний дэмжлэгийг авахад чухал нөлөө үзүүлнэ. Клубээс зохион байгуулсан үйл ажиллагаагаа бусад сурагчдад сонин сэтгүүл, facebook, гар утас, мэдээллийн самбар, эцэг эхийн болон сурагчдын зөвлөлийн хурал зэргээр дамжуулан сурталчилж болно. Сурагчдын бүтээлийг ашиглах нь илүү үр дүнтэй байдаг. Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр болон эх дэлхийгээ хайрлах, хог хаягдалгүй байх зэрэг олон чиглэлээр хийсэн өөрийн сургуулийн сурагчдын бүтээлийг эрүүл мэндийн клуб өөрийн үйл ажиллагаандаа ашиглах хэрэгтэй. Энэ нь хүүхдийг идэвхжүүлэх, клубээ дэмжүүлэх аргын нэг юм.

ЭМК-т элсэх өргөдлийн маягтын загвар

Овог:	Нэр:	Хүйс:	Анги бүлэг:
Төрсөн он өдөр	сар	Регистрийн дугаар:	
Зорилго:			
Мэдээллийн үүсвэр	эх	<input type="checkbox"/> Мэдээллийн самбар <input type="checkbox"/> АУБ <input type="checkbox"/> Вэбсайт <input type="checkbox"/> Найз нөхөд <input type="checkbox"/> Facebook <input type="checkbox"/> Бусад	
Клубт орох болсон шалтгаан:			
Хүүхдийн оролцооны байгууллагад гишүүнчлэлтэй эсэх		<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	
“Хэрвээ би эрүүл мэндийн гишүүн бол”- эссэ бичих (100-150)			
Холбоо барих утас:		E-mail хаяг:	

ЭМК-н ажлын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар

	Хийгдэх ажлууд	Тайлбар	Хугацаа
	Хийгдэх ажлууд	Тайлбар	Хугацаа
1	Клубын уулзалтууд	Клуб сард 2-3 удаа уулзаж тогтвортой үйл ажиллагаа явуулах	Сар бүрийн эхэн, дунд, сүүлд
2	Ус эрүүл ахуй, ариун цэвэр хүрээлэн буй орчны сургалтууд	Гар угаах	9-р сарын 5-аас 10-р сарыг дуустал
		Халдварт өвчлөл	9-р сарын 10-аас 11-р сарыг дуустал
		Ус авах гинжин хэлхээ	9-р сарын 10 –аас 12-10 хүртэл
		Хог хаягдал	2-р сарын 01-ээс 04-р сарын 01
		Ус, хүрээлэн буй орчин	2-р сарын 01-ээс 04-р сарын 01
	АЦБ-сайжруулах	9-10 саруудад мөн 3,4-р сард	
3	Бусад эрүүл мэндийн клубуудтай очиж танилцах туршлага солилцох	Ижил үйл ажиллагаа явуулж байгаа клубууд туршлага солилцох	Тухайн клубтэй цаг тохирох 11-р сард
4	Дэлхийн гар угаах өдөр	Гадаа талбайн арга хэмжээ	10-р сарын -15
5	ДГУӨ-Г угтаж зохиогдох ажлууд, бэлтгэл ажил	1-5 ангийн сурагчдад гар угаах хичээл заах уралдаан тэмцээн зохиох /Handart гм...../	10-р сарын 1 10-р сарын 31
6	Дэлхийн нойлын өдөр	Багш нарын хурал дээр танилцуулах мэдээлэл өгөх	11-р сарын -19
7	Дэлхийн нойлын өдөрийг угтаж зохиогдох ажлууд , бэлтгэл	Гар зураг, эссэ бичлэг уралдаан	11-р сарын 01 11-р сарны 31
8	Дэлхийн усны өдөр		3-р сарын 22
9	Дэлхийн усны өдөрийг угтаж зохиогдох ажлууд, бэлтгэл	Гэрэл зураг видео бичлэгийн уралдаан дунд ахлах ангийг ханд зохиох	3-р сарын 01 3-р сарын 31
10	Клубын өдөрлөг зохион байгуулах	Өдөрлөгт клубын гишүүд аав ээж, сургуулийн удирдлага сурагчид, багш нараа урих үйл ажиллагаагаа танилцуулах	12-р сарын эхний долоо хоногт
11	Олон нийтийн үйл ажиллагаа	Олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах	4-р сард
12	Хаалтын үйл ажиллагаа	Клуб жилийн хугацаанд хийсэн ажлаа тайлагнах	4-р сарын сүүлийн долоо хоногт

ХАВСРАЛТ 3

СУРАГЧДЫН ЭРҮҮЛ АХУЙН ЗАН ҮЙЛИЙН ӨӨРЧЛӨЛТӨД ҮНЭЛГЭЭ ХИЙХ НЬ

Энэхүү гарын авлагыг сургуулийн эрүүл ахуйг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих, үнэлгээ хийх зорилгоор ашиглана. Сургуулийн усан хангамж, эрүүл ахуйн нөхцөл, ариун цэврийн байгууламжийн дэд бүтцэд хяналт хийх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 2011 онд НҮБ-ын Хүүхдийн сангаас гаргасан “Сургуулиудын усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн хяналт шинжилгээний багц”-аас авна уу.

ХЯНАЛТ БА ҮНЭЛГЭЭ

ХЯНАЛТ

Хяналтын гол зорилго нь хөтөлбөр үе шат бүрт хэрхэн хэрэгжиж байгаа талаар эргэн харж, үр дүнг сайжруулах явдал юм. Эрүүл ахуйн сургалт сурталчилгааны үйл ажиллагаа нь маш нарийн зохион байгуулалт, хяналтын дагуу явагдах ёстой. Хяналт шинжилгээг тогтмол хийснээр төслийн үйл ажиллагаа бодитой явагдаж байгаа эсэх, сурагчдад хүрч үр дүн өгч чадаж байгааг тогтоодог. Ингэснээр хөтөлбөрөө сайжруулж, илүү үр дүнд хүрэх боломжтой.

ҮНЭЛГЭЭ

